IRIM
INDEPENDENT
RESEARCH
INSTITUTE OF
MONGOLIA

# ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ИЛ ТОД БАЙДАЛ 2017

## МОНИТОРИНГИЙН ТАЙЛАН




Улаанбаатар

2017 он

“Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдал: Мониторингийн тайлан” 2017 судалгааг IRIM Судалгааны хүрээлэн 6 дахь жилдээ хийж гүйцэтгэв.


| | |
|---|---|
| Мониторингийн багийн зохицуулагч | Хүрэлчулууны Баярмаа. *IRIM судалгааны хүрээлэнгийн Судалгааны менежер, Социологич* |
| Ахлах судлаач: | Эрдэнэбатын Цэрэндорж<br>*IRIM судалгааны хүрээлэнгийн судлаач, Социологич* |
| Багийн судлаач: | Батбаярын Баярмаа<br>*IRIM судалгааны хүрээлэнгийн судлаач* |

# АГУУЛГА


БАЙГУУЛЛАГЫН ТОВЧИЛСОН НЭРС 4

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ 6

ДҮРСИЙН ЖАГСААЛТ 7

ЗУРГИЙН ЖАГСААЛТ 9

УДИРТГАЛ 9

БҮЛЭГ 1. МОНИТОРИНГИЙН АРГА ЗҮЙ 10

1.1 МОНИТОРИНГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ 10

1.2 МОНИТОРИНГИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ЦАГ ХУГАЦАА 10

1.3 МОНИТОРИНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД 10

**БҮЛЭГ 2. ГОЛ ҮР ДҮН** 144

**2.1 ЯАМДЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ҮЗҮҮЛЭЛТ** 19

2.2 ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГУУДЫН ВЕБСАЙТЫН ҮЗҮҮЛЭЛТ 31

2.3 ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГУУДЫН ВЕБСАЙТЫН ҮЗҮҮЛЭЛТ 41

2.4 АЙМГУУДЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ҮЗҮҮЛЭЛТ 51

2.6 УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРГАА, ДҮҮРГҮҮДИЙН ВЕБСАЙТЫН ҮЗҮҮЛЭЛТ 65

2.7 ПАРЛАМЕНТИЙН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ВЕБСАЙТЫН ҮЗҮҮЛЭЛТ 77

ХАВСРАЛТ 1. ҮНДСЭН ОЙЛГОЛТУУД 84

ХАВСРАЛТ 2. АРГА ЗҮЙН ТАЙЛБАР 85

ХАВСРАЛТ 3. СУДАЛГААНД ХАМРУУЛСАН ЦАХИМ ХУУДСУУД 87

ХАВСРАЛТ 4. ЦАХИМ ХУУДСУУДЫН ЭРЭМБЭЛЭЛТ 89

ХАВСАРЛТ 5. ЦАХИМ ХУУДСУУДЫГ ДӨРВӨН ҮЗҮҮЛЭЛТЭЭР НЬ ЭРЭМБЭЛЭЛТ 91

# БАЙГУУЛЛАГЫН ТОВЧИЛСОН НЭРС

**Монгол Улсын яам**

| | |
|---|---|
| БОАЖЯ | Байгаль орчин, аялал жуулчлалын яам |
| БХЯ | Батлан хамгаалах яам |
| БСШУЯ | Боловсрол соёл шинжлэх ухааны яам |
| ГХЯ | Гадаад харилцааны яам |
| БХБЯ | Барилга, хот байгуулалтын яам |
| СЯ | Сангийн яам |
| ХЗДХЯ | Хууль зүй дотоод хэргийн яам |
| ХХААХҮЯ | Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрлэлийн яам |
| ЭМЯ | Эрүүл мэндийн яам |
| ЭХЯ | Эрчим хүчний яам |
| ЗТХЯ | Зам, тээвэр хөгжлийн яам |
| ХНХЯ | Хөдөлмөр нийгэм хамгааллын яам |
| УУХҮЯ | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам |

***Хэрэгжүүлэгч агентлаг***

| | |
|---|---|
| АЕГ | Архивын ерөнхий газар |
| АМГТГ | Ашигт малтмал, газрын тосны газар |
| БТСГ | Биеийн тамир спортын газар |
| ГЕГ | Гаалын ерөнхий газар |
| ГИХГ | Гадаадын иргэн харъяатын газар |
| ГЗБГЗЗГ | Газар зохион байгуулалт геодези, зураг зүйн газар |
| ГБХЗХГ | Гэр бүл, Хүүхэд, залуучуудын хөгжлийн газар |
| ИНЕГ | Иргэний нисэхийн ерөнхий газар |
| МЭҮГ | Мал эмнэлэгийн үржлийн газар |
| ОӨУБЕГ | Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар |
| СУГ | Соёл урлагын газар |
| ТЕГ | Татварын ерөнхий газар |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ХХҮЕГ | Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар |
| ЦУОШГ | Цаг уур орчны шинжилгээний газар |
| ШШГЕГ | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар |
| ЭМНДЕГ | Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар |

***Тохируулагч агентлаг***

| | |
|---|---|
| ЗХЖШ | Зэвсэгт хүчний жанжин штаб |
| ХХМТГ | Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар |
| МХЕГ | Мэргэжлийн хяналтын ерөнхий газар |
| ОБЕГ | Онцгой байдлын ерөнхий газар |
| СХЗГ | Стандартчилал, хэмжил зүйн газар |
| ТЕГ | Тагнуулын ерөнхий газар |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ХХЕГ | Хил хамгаалах ерөнхий газар |
| ЦЕГ | Цагдаагийн ерөнхий газар |
| ШӨХТГ | Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөөх газар |

**Парламентийн харьяа байгууллагууд**

| | |
|---|---|
| ТАЗ | Төрийн Албаны Зөвлөл |
| АТГ | Авлигатай Тэмцэх Газар |
| СЗХ | Санхүүгийн Зохицуулах Хороо |
| СЕХ | Сонгуулийн Ерөнхий Хороо |
| ХЭҮК | Хүний Эрхийн Үндэсний Комисс |
| ҮАГ | Үндэсний Аудитын Газар |
| ҮСХ | Үндэсний Статистикийн Хороо |

| | |
|---|---|
| УИХ | Монгол Улсын Их Хурал |
| МБ | Монгол банк |

**Улаанбаатар хотын засаг захиргаа**

| | |
|---|---|
| НЗДТГ | Улаанбаатар |
| УХЗА | Улаанбаатар хотын захирагчын алба |
| БРД | Багануур дүүрэг |
| БХД | Багахангай дүүрэг |
| НД | Налайх дүүрэг |
| БГД | Баянгол дүүрэг |
| БЗД | Баянзүрх дүүрэг |
| СБД | Сүхбаатар дүүрэг |
| ХУД | Хан-Уул дүүрэг |
| ЧД | Чингэлтэй дүүрэг |
| СХД | Сонгинохайрхан дүүрэг |

# ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Тухайн үзүүлэлтийг хангаж буй түвшин
Хүснэгт 2. Яамдын цахим хуудасны ерөнхий үзүүлэлт(хувиар)
Хүснэгт 3. ТОП 5 үзүүлэлттэй яам (хувь)
Хүснэгт 4. Төсөв санхүүгийн ил тод байдал ТОП 5 яам (хувь)
Хүснэгт 5. ХАА-ны ил тод байдал ТОП 3 яам (хувь)
Хүснэгт 6. Хэрэгжүүлэгч агентлагуудын цахим хуудасны ерөнхий үзүүлэлт (хувь)
Хүснэгт 7. ТОП 5 үзүүлэлттэй хэрэгжүүлэгч агентлагууд (хувь)
Хүснэгт 8. Төсөв санхүүгийн ил тод байдлын үнэлгээТОП 3 (хувь)
Хүснэгт 9. Худалдан авах ажиллагааны ил тод байдлын үнэлгээ ТОП 3 (хувь)
Хүснэгт 10. Тохируулагч агентлагуудын цахим хуудасны ерөнхий үзүүлэлт (хувь)
Хүснэгт 11. ТОП 5 үзүүлэлттэй тохируулагч агентлагууд (хувь)
Хүснэгт 12. Төсөв санхүүгийн ил тод байдал ТОП 3 тохируулагч агентлаг (хувь)
Хүснэгт 13. ХАА-ны ил тод байдал ТОП 3 тохируулагч агентлаг (хувь)
Хүснэгт 14. Аймгуудын цахим хуудасны ерөнхий үзүүлэлт (хувь)
Хүснэгт 15. ТОП 5 үзүүлэлттэй аймаг (хувь)
Хүснэгт 16. Хүний нөөцийн ил тод байдал ТОП 3 аймаг (хувь)
Хүснэгт 17. Төсөв санхүүгийн ил тод байдлын үнэлгээ ТОП 3 аймаг (хувь)
Хүснэгт 18. ХАА-ны ил тод байдал ТОП 3 аймаг (хувь)
Хүснэгт 19. Нийслэлийн захиргаа. дүүргүүдийн цахим хуудасны ил тод байдал (хувь)
Хүснэгт 20. Нийслэлийн захиргаа. дүүргийн ТОП 5 байгууллага
Хүснэгт 21. Хүний нөөцийн ил тод байдлын үнэлгээ ТОП 3 дүүрэг (хувь)
Хүснэгт 22. Төсөв санхүүгийн ил тод байдал ТОП 3 нийслэл. дүүрэг(хувь)
Хүснэгт 23. Нийслэлийн захиргаа. дүүргүүдийн ХАА-ны ил тод байдал ТОП 2 (хувь)
Хүснэгт 24. Парламентын харьяа байгууллагын цахим хуудасны ил тод байдлын үнэлгээ (хувь)
Хүснэгт 25. Төсөв, санхүүгийн ил тод байдал ТОП 4 (хувь)
Хүснэгт 26. Мониторингийн шалгуур үзүүлэлтүүд
Хүснэгт 27. Тухайн шалгуурыг ямар хэмжээнд хангаж байгааг үнэлэх үнэлгээ
Хүснэгт 28. 2015 оны мониторингийн аргазүйд нэмж оруулсан шалгуур үзүүлэлтүүд

## ДҮРСИЙН ЖАГСААЛТ

Дүрс 1. Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдал (хувиар харуулсан) 15
Дүрс 2. Төрийн байгууллагын мэдээллийн хамааралтай байдал (хувиар харуулсан) 16
Дүрс 3. Төрийн байгууллагын мэдээллийн найдвартай байдал (хувиар харуулсан) 16
Дүрс 4. Төрийн байгууллагын мэдээллийн цаг үеийн байдал (хувиар харуулсан) 17
Дүрс 5. Төрийн байгууллагын мэдээллийн хүртээмжтэй байдал (хувиар харуулсан) 18
Дүрс 6. Төрийн байгууллагын цахим хуудасны хэрэглэхэд хялбар байдал (хувиар харуулсан) 19
Дүрс 7. Яамдын цахим хуудасны ил тод байдал (хувиар харуулсан) 21
Дүрс 8. Яамдын ерөнхий мэдээлэл (хувь) 23
Дүрс 9. Яамдын цахим хуудас дахь байгууллагын олон нийттэй харилцах мэдээлэл (хувь) 24
Дүрс 10. Яамдын төсөв санхүүгийн ил тод байдлын үзүүлэлтүүд (хувь) 27
Дүрс 11. Яамдын төсөв санхүүгийн ил тод байдал (хувь) 28
Дүрс 12. Яамдын ХАА-ны ил тод байдлын үзүүлэлт (хувь) 29
Дүрс 13. Яамдын ХАА-ны ил тод байдал (хувь) 30
Дүрс 14. Хэрэгжүүлэгч агентлагуудын цахим хуудасны ил тод байдал (хувь) 32
Дүрс 15. Хэрэгжүүлэгч агентлагуудын ерөнхий мэдээлэл (хувь) 34
Дүрс 16. Хэрэгжүүлэгч агентлагуудын хүний нөөцийн ил тод байдлын үзүүлэлт (хувь) 35
Дүрс 17. Хэрэгжүүлэгч агентлагуудын хүний нөөцийн ил тод байдал (хувь) 36
Дүрс 19. Хэрэгжүүлэгч агентлагийн цахим хуудасны төсөв санхүүгийн ил тод байдлын үзүүлэлт (хувь) 37
Дүрс 18. Хэрэгжүүлэгч агентлагын төсөв санхүүгийн ил тод байдал (хувь) 38
Дүрс 20. Хэрэгжүүлэгч агентлагын ХАА-ны ил тод байдал (хувь) 39
Дүрс 21. Хэрэгжүүлэгч агентлагын ХАА-ны ил тод байдлын үзүүлэлтүүд (хувь) 40
Дүрс 22. Тохируулагч агентлагуудын ил тод байдал (хувь) 42
Дүрс 23. Тохируулагч агентлагуудын цахим хуудсыг хэрэглэх байдал (хувь) 42
Дүрс 24. Тохируулагч агентлагуудын ерөнхий мэдээлэл (хувь) 43
Дүрс 25. Тохируулагч агентлагуудын олон нийттэй харилцах мэдээлэл (хувь) 44
Дүрс 26. Тохируулагч агентлагуудын хүний нөөцийн ил тод байдал (хувь) 45
Дүрс 27. Тохируулагч агентлагуудын хүний нөөцийн ил тод байдлын үзүүлэлт (хувь) 46
Дүрс 28. Тохируулагч агентлагуудын төсөв санхүүгийн ил тод байдал (хувь) 47
Дүрс 29. Тохируулагч агентлагуудын санхүүгийн ил тод байдлын үзүүлэлтүүд (хувь) 48
Дүрс 30. Тохируулагч агентлагуудын ХАА-ны үзүүлэлт (хувь) 49
Дүрс 31. Аймгуудын цахим хуудасны ил тод байдал (хувь)
Дүрс 32. Аймгуудын цахим хуудсыг хэрэглэх байдал (хувь)
Дүрс 33. Аймгуудын ерөнхий мэдээлэл (хувь)
Дүрс 34. Аймгуудын цахим хуудасны олон нийттэй харилцах мэдээлэл (хувь)
Дүрс 35. Аймгуудын хүний нөөцийн ил тод байдал (хувь)
Дүрс 36. Аймгуудын хүний нөөцийн ил тод байдлын үзүүлэлт (хувь)
Дүрс 37. Аймгуудын төсөв санхүүгийн ил тод байдал (хувь)
Дүрс 38. Аймгуудын төсөв санхүүгийн ил тод байдлын үзүүлэлтүүд (хувь)
Дүрс 39. Аймгуудын цахим хуудасны ХАА-ны ил тод байдал (хувь)
Дүрс 40. Аймгуудын ХАА-ны ил тод байдал (хувь)

Дүрс 41. Нийслэлийн захиргаа. дүүргүүдийн цахим хуудасны ил тод байдал (хувь)
Дүрс 42. Нийслэлийн захиргаа. дүүргүүдийн ерөнхий үзүүлэлт (хувь)
Дүрс 43. Нийслэлийн захиргаа. дүүргүүдийн олон нийттэй харилцахтай холбоотой мэдээлэл (хувь)
Дүрс 44. Нийслэлийн захиргаа. дүүргүүдийн хүний нөөцийн ил тод байдал (хувь) **Error! Bookmark not defined.**
Дүрс 45. Нийслэлийн захиргаа. дүүргүүдийн хүний нөөцийн ил тод байдлын үзүүлэлт (хувь)
Дүрс 46. Нийслэлийн захиргаа. дүүргүүдийн төсөв санхүүгийн ил тод байдал (хувь)
Дүрс 47. Нийслэлийн захиргаа. дүүргүүдийн төсөв санхүүгийн ил тод байдлын үзүүлэлтүүд (хувь)
Дүрс 48. Нийслэлийн захиргаа. дүүргүүдийн ХАА-ны ил тод байдал (хувь)
Дүрс 49. Нийслэлийн захиргаа. дүүргүүдийн ХАА-ны ил тод байдал (хувь)
Дүрс 50. Парламентын харьяа байгууллагуудын ил тод байдлын үнэлгээ(хувь)
Дүрс 51. Парламентын харьяа байгууллагуудын ерөнхий мэдээллийн үнэлгээ (хувь)
Дүрс 52. Парламентын харьяа байгууллагуудын олон нийттэй харилцах мэдээлэл (хувь)
Дүрс 53. Парламентын харьяа байгууллагуудын хүний нөөцийн ил тод байдал(хувь)
Дүрс 54. Парламентын харьяа байгууллагуудын хүний нөөцийн ил тод байдлын үзүүлэлт (хувь)
Дүрс 55. ХАА-ны ил тод байдал (хувь)
Дүрс 56. Парламентын харьяа байгууллагуудын ХАА-ны ил тод байдлын үзүүлэлтүүд (хувь)

# УДИРТГАЛ

Монголын төр иргэдтэйгээ ямар хэлбэрээр харилцаа тогтоож байна вэ ?

Цахим хуудас, мэдээллийн самбар, утас, уулзалт гэсэн хэлбэрүүдээр дамжуулан иргэдтэйгээ харилцдаг байна. Гэвч бодит байдал дээр төрийн үйлчилгээг иргэд 81 хувь нь биечлэн, 16 хувь нь утсаар, 7 хувь нь бичгээр авдаг гэжээ[1]. Иргэд төрийн үйлчилгээг биечлэн авах нь цаг хугацаа алдах, тээврийн зардлаас эхлээд олон дутагдалтай учир төрийн байгууллагын зүгээс иргэддээ цахим хуудсаар дамжуулан мэдээлэл хүргэдэг болоод байна. Гэвч төрийн байгууллагын цахим хуудаснууд тогтсон стандартгүй, цахим хуудас дээрх мэдээллээ тогтмол шинэчлэдэггүй, иргэдэд хүрэх ёстой мэдээлэл цахим хуудаст байдаггүй зэрэг олон асуудлууд байдгаас цахим хуудас хангалттай төвшинд иргэдэд мэдээлэл хүргэж чаддаггүй.

Монгол улсын үндсэн хуулийн “Арван зургаадугаар зүйл”, “Цахим Монгол” үндэсний хөтөлбөр, “Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хууль”, Засгийн газрын “143 дугаар тогтоол” зэрэг эрх зүйн баримт бичгүүдэд тулгуурлан манай судалгааны хүрээлэнгээс төрийн байгууллагуудын цахим хуудасны ил тод байдлын төвшинг үнэлэх мониторингийн ажлыг 2011, 2014, 2015, 2016, 2017 онуудад тус тус хийж гүйцэтгээд байна.

Энэ удаагийн үнэлгээнд Орон нутгийн захиргаа 21, Улаанбаатар хотын захиргаа 11, Засгийн газрын яам 13, Хэрэгжүүлэгч агентлаг 17, Тохируулагч агентлаг 10, Парламентын харьяа 9 байгууллага нийт 81 байгууллагын цахим хуудас дахь мэдээллийн ил тод байдлыг 95-99 шалгуурын дагуу үнэлсэн билээ.

Энэхүү хяналт үнэлгээний гол ач холбогдол энэхүү мониторингийн үр дүн дээр суурилан төрийн байгууллагууд цахим хуудсаа тогтмол сайжруулах боломжийг бүрдүүлж байгаад орших юм. Үүний үр дүнд иргэд цаг хугацаагаа хэмнэж төрийн байгууллага болон төрийн үйлчилгээтэй холбоотой бүхий л мэдээллийг орон зай, цаг хугацаа хамаарахгүй авах боломж нээгдэх юм.

Цаашлаад иргэд төр хоорондын харилцаа сайжрах нь:

- Төр иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгана
- Төрийн үйлчилгээний чанар хүртээмж дээшилнэ
- Иргэдийн төрд итгэх итгэл дээшилнэ
- Иргэд төсөв санхүү, ажлын байр, тендер зэрэг дээр хяналт тавиад эхлэхээр авилга, ашиг сонирхлын зөрчил багасна
- Төрийн албан хаагчдын ажлын хариуцлага дээшилнэ зэрэг давуу талууд байдаг учир манай байгууллага нийгмийн хариуцлагынхаа хүрээнд энэхүү хяналт үнэлгээг таван жилийн турш тогтмол хийсээр ирсэн билээ.

[1] Нээлттэй нийгэм форум.*Төрийн үйлчилгээний мониторинг III.* Улаанбаатар.

# БҮЛЭГ 1. МОНИТОРИНГИЙН АРГА ЗҮЙ

## 1.1 МОНИТОРИНГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Энэ судалгаа нь төрийн байгууллагуудын цахим хуудаст мониторинг хийж “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дагуу төрийн байгууллагын цахим хуудаст холбогдох ил тод байдлын шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилтийг үнэлэх, цаашдын үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулах талаар санал зөвлөмж боловсруулах зорилготой.

Энэ хүрээнд доорх зорилтууд тавьсан:

- Өнгөрсөн удаагийн мониторингийн арга зүйг зарчмын хувьд баримтлах. Ингэх нь харьцуулагдахуйц байдлыг хадгална. Гэхдээ үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүү, худалдан авах ажиллагааны ил тод байдал тус бүрээр үнэлэх
- Төсөв санхүү, худалдан авах ажиллагааны ил тод байдлын шалгуур үзүүлэлтүүдийг Шилэн дансны тухай хуулийн заалтуудыг баримтлан хэрэгжилтийг үнэлэх
- Мониторингийн үр дүнг өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулан шинжлэх;
- Судалгаанд хамрагдсан төрийн байгууллагын цахим хуудсыг ил тод байдлын үзүүлэлтээр нь эрэмбэлж, төрөл тус бүрээр нь жагсаалт гаргах;
- Цахим хуудаст тавигдсан мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн санал зөвлөмж боловсруулах.

## 1.2 МОНИТОРИНГИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ЦАГ ХУГАЦАА

Мониторингийн мэдээллийг 2017 оны 07 сарын 10-аас 09 дүгээр сарын 10-ны хооронд цуглуулсан бөгөөд энэ хугацаанд 81 байгууллагын албан ёсны цахим хуудас бүгд ажиллаж байсан.

Тодруулбал судалгаанд:

- Монгол улсын яам -13;
- Монгол улсын хэрэгжүүлэгч агентлаг -17;
- Монгол улсын тохируулагч агентлаг -10;
- Монгол улсын орон нутгийн захиргаа- 21;
- Нийслэл, дүүргийн захиргаа - 11
- Улсын Их Хурал болон түүний харъяа байгууллага -9 хамрагдсан.

## 1.3 МОНИТОРИНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Уг мониторингийн арга зүйд ашиглагдсан үндсэн үзүүлэлтүүд нь тухайн төрийн байгууллага хэр ил тод байгааг хэмжихэд чиглэгдсэн. Хэдийгээр ил тод байдлыг хэмжих олон янзын үзүүлэлт байдаг ч (тухайлбал улс төрийн, эдийн засгийн, хэвлэл мэдээллийн, хүний эрхийн, бизнесийн өнцгөөс гэх мэт) энэ удаад үндсэн хоёр чиглэлээр шалгуур үзүүлэлтийг боловсруулсан. Үүнд:

1. Холбогдох хуулиудад туссан мэдээллийн ил тод байдлыг хангах үндсэн дөрвөн хүрээ болох “Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал”, “Хүний нөөцийн бодлогын ил тод байдал”, “Төсөв, санхүүгийн ил тод байдал”, “Төрийн болон орон нутгийн өмчөөр

бараа, ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааны ил тод байдал” гэсэн мэдээллийн хүрээг авч үзсэн.

2. Засгийн газрын болон төрийн байгууллагын цахим хуудаст тавигддаг олон улсын нийтлэг шаардлага, стандарт (MNS 6285:2011 гэх зэрэг) үзүүлэлтүүдэд тулгуурласан. (MNS 6285:2011) гэдэг нь төрийн байгууллагын цахим хуудаст тавигдах шаардлагыг хэлж байгаа юм.

Үзүүлэлтүүдийг боловсруулахдаа “*хэмжигдэхүйц”*, *“хэрэгжихүйц*”, “*бодитой*” байх зарчмыг баримталсан. Мэдээллийн агуулгын шинжилгээг хийх нийтлэг шалгуур үзүүлэлтийг тодорхойлохдоо Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа Хөгжлийн Байгууллага ил тод байдлын тодорхойлолтод ашигласан үндсэн гурван үзүүлэлт, НҮБ-ын Ази Номхон Далайн Эдийн Засаг Нийгмийн Комиссын ашигласан нэг үзүүлэлтийг хослуулснаас гадна ил тод байдлыг гэхээсээ илүүтэй цахим хуудсуудын чанарыг үнэлэхэд өргөн ашигладаг стандарт үзүүлэлтийг нэмж нийт таван үзүүлэлт бүхий дизайн боловсруулсан.

**Үзүүлэлт 1.** Мэдээллийн холбогдолтой байдал (Relevance): Төрөөс иргэдэд үзүүлж буй бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх мэдээллийг хүртэх боломжтой байдал. Нарийвчилбал, тухайн цахим хуудас нь мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай (МИТББМАЭтХ) , ШДтХ-д цахим хуудаст тавигдсан байхаар заасан дөрвөн хүрээний дагуух 40 төрлийн мэдээллийг хэрэглэгчдэд өгч байгаа эсэхийг хэмжинэ.

**Үзүүлэлт 2.** Мэдээллийн найдвартай байдал (Reliability): Тухайн цахим хуудас дахь мэдээлэл хэрэглэгчдэд итгэл төрүүлэхүйц байгаа эсэхийг илэрхийлнэ (Alanezi, Kamil, & Basri, 2010). Мөн МИТББМАЭтХ, ШДтХ-иуд дахь дөрвөн хүрээний дагуух 40 төрлийн мэдээлэл хэр найдвартай байгааг хэмжинэ.

**Үзүүлэлт 3.** Мэдээллийн цаг үеийн байдал (Timeliness): Цахим хуудаст цаг үеийн, ач холбогдлоо алдаагүй мэдээлэл тавьсан эсэхийг хэмжинэ (Harris, 2010). Өөрөөр хэлбэл, төрөөс иргэдэд хүргэж буй мэдээлэл цагаа олсон, тогтмол давтамжтай шинэчлэгддэг, уг мэдээллийг хэрэглэгчид хүлээн авч ашиглах боломжтой эсэхийг хянах юм.

**Үзүүлэлт 4.** Цахим хуудсуудын хүртээмжтэй байдал (Accessibility): Цахим хуудас нь хэрэглэгчид төрийн байгууллагад шууд хандан зөвлөгөө, мэдээлэл авах боломж олгосон, хоёр талын харилцааг хангахуйц байгаа эсэхийг хэмжинэ (Drew & Nyerges, 2004, p. 57). Ингэхдээ дээрх гурван шалгуур үзүүлэлтээс ялгаатай нь мэдээллийн агуулгад бус цахим хуудаст өөрт нь холбогдох хэмжүүрүүдийн дагуу шинжилгээ хийх юм.

**Үзүүлэлт 5.** Хэрэглэхэд хялбар байдал Usability): Хэрэглэгчид тухайн цахим хуудсыг хэрэглэхэд хялбар байгаа эсэх. Үүнд цахим хуудсуудын туслах хэрэгслүүд, үзэмж, төрх, дизайн зэрэг багтана (Weakley, 2004). Аливаа цахим хуудас нь иргэдийн интернэт хэрэглэх чадварт нийцсэн, энгийн, ойлгомжтой байх нь хэрэглэхэд хялбар байдлыг илтгэх чухал үзүүлэлт болдог.

Дээрх үндсэн таван үзүүлэлтийн тусламжтайгаар төрийн байгууллага цахим хуудсаараа дамжуулан МИТББМАЭтХ, ШДтХ-д заасан үндсэн дөрвөн хүрээний мэдээллийн ил тод байдлыг хэрхэн хангаж байгааг хэмжих юм.

Онцлон тэмдэглэхэд, хэдийгээр МИТББМАЭтХ, ШДтХ-д заасан мэдээллийн зарим хүрээ, тухайлбал хүний нөөц, төсөв, худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл тухайн төрийн

байгууллагын албан ёсны цахим хуудаснаас тусдаа нэгдсэн цахим хуудаст байрладаг шинжилгээг гаргасан нь:

1. Тухайн үзүүлэлтийн хэрэгжилт цахим хуудсуудад ямар түвшинд байгааг хэмжүүр тус бүрээр хувь тооцож үнэлэх
2. Өмнөх судалгаатай харьцуулагдахуйц байдлаар үзүүлэлтүүдийг харуулах
3. Байгууллага тус бүрийн үзүүлэлтүүдээс авсан оноо, хувийг эрэмбэлж, хавсралтад харуулах

Мониторингийн арга зүйд ашиглагдсан үзүүлэлтүүдийн аль нь ил тод байдлыг илтгэхэд илүү ач холбогдолтой үзүүлэлт вэ гэдгийг ялгаатай байдлаар тогтоосон. Эдгээр үзүүлэлтийн нийт үнэлгээний системд эзлэх ач холбогдлыг Дүрс 1-д харуулав.

**Дүрс 1. Шалгуур үзүүлэлт тус бүрийн үнэлгээний системд эзлэх хувь**




Мэдээллийн холбогдолтой байдал мэдээллийн ил тод байдлыг илтгэх үзүүлэлтүүдээс хамгийн өндөр буюу 30%-ийг эзэлж байгаа. Энэ нь цахим хуудаст тогтоолд заасан мэдээллийн бүх хүрээ ямар нэг байдлаар тавигдсан байгааг илтгэнэ. Тиймээс энэ нь ил тод байдлыг үнэлэх хамгийн чухал үзүүлэлт болох юм.

Харин тухайн мэдээлэл нь чанарын хувьд ямар мэдээлэл байна вэ гэдэгтэй холбоотой хоёр үзүүлэлт байгаа бөгөөд нийт үнэлгээний системд тус бүр 20 хувь, нийлээд 40 хувь эзэлнэ (мэдээллийн найдвартай ба цаг үеийн байдлын үзүүлэлтүүд).

Эцэст нь мэдээлэл хэрхэн хүрч байна вэ гэдэгт цахим хуудасны хүртээмжтэй байдал, хэрэглэхэд хялбар байдал багтсан бөгөөд эдгээр нь илүү хэлбэрийн шинжтэй үзүүлэлт тул нийт үнэлгээний системд тус бүр 15 хувь (мэдээллийн хүртээмжтэй байдал ба хэрэглэхэд хялбар байдал), нийт 30 хувийг эзэлж байна.

Мөн үзүүлэлтүүдийн хэрэгжилтийг үнэлэхдээ өмнөх мониторингийн арга зүйд ашигласан "шалгуурыг хангасан", "шалгуурыг хангаагүй" гэсэн үнэлгээг нарийвчилсан. Тухайлбал, тухайн үзүүлэлтийг хэдэн хувьтай биелүүлснээс хамаарч төрийн байгууллагын цахим хуудсуудын үзүүлэлтийн хэрэгжилтийг тоон утгаар хэмжих оролдлого хийсэн. Хэмжилтээр гарч ирсэн үр дүнг тухайн үзүүлэлт тус бүрээр уг мониторингийн ажилд хэрхэн ойлгож, тайлбарлаж байгаа вэ гэдгийг дараах хүснэгтээс харж болно.

**Хүснэгт 1. Тухайн үзүүлэлтийг хангаж буй түвшин**

| Хувь | Холбогдолтой байдал | Найдвартай байдал | Цаг үеийн байдал | Хүртээмжтэй байдал | Хэргэлэхэд хялбар байдал | Ил тод байдал |
|---|---|---|---|---|---|---|
| 81-100 | Бүрэн холбогдолтой | Мэдээлэл бүрэн найдвартай | Мэдээлэл тогтмол шинэчлэгддэг | Бүрэн хүртээмжтэй | Хэрэглэхэд маш хялбар | Бүрэн ил тод |
| 61-80 | Холбогдолтой | Найдвартай | Ихэнхи мэдээлэл шинэчлэгддэг | Хүртээмжтэй | Хэрэглэхэд боломжтой | Ил тод |
| 41-60 | Зарим талаар холбогдолтой | Зарим талаар найдвартай | Зарим мэдээлэл шинэчлэгддэг | Зарим талаар хүртээмжтэй | Хэрэглэхэд төвөгтэй | Зарим талаар ил тод |
| 0-40 | Мэдээлэл огт байхгүй эсвэл холбогдолгүй | Найдваргүй | Хоцрогдсон мэдээлэл | Хүртээмжгүй | Хэрэглэхэд маш төвөгтэй | Хаалттай |

Дээрх таван үзүүлэлт тус бүрийн үнэлгээний түвшний дэлгэрэнгүй тайлбарыг Хавсралт 2 хэсгээс харна уу.

# БҮЛЭГ 2. ГОЛ ҮР ДҮН

## 1. Ерөнхий үр дүн

Энэ бүлэгт судалгаанд хамрагдсан нийт төрийн байгууллагуудын цахим хуудсуудын дундаж үзүүлэлтийг дөрвөн оны үр дүнгүүдийг харьцуулан танилцуулна. Мөн гол шалгуур үзүүлэлтүүд болох “Хандалт” “Хамааралтай байдал”, “Найдвартай байдал”, “Цаг үеийн байдал”, “Хүртээмжтэй байдал”, “Хэрэглэхэд хялбар байдал” гэсэн зургаан үзүүлэлтүүдээр харуулна.

**Хандалт**
Энэ хэсэгт төрийн байгууллагуудын цахим хуудсуудыг ашиглаж байгаа хэрэглэгчдэд хүндрэл бэрхшээл тулгарахгүйгээр ашиглах боломжтой байдлыг үнэлсэн. Цахим хуудсын хандалтын байдлыг дөрвөн шалгуураар үнэлсэн. Эдгээр шалгууруудад “цахим хаягаар хандахад шууд нээгдсэн үү?”, “цахим хуудсанд хандсан үйлчлүүлэгчдийн тоо харах боломжтой байна уу?”, “цахим хуудсанд тавигдсан мэдээлэлд сэтгэгдэл оруулах боломжтой байна уу?”, “цахим хуудсаар дамжуулан өргөдөл, гомдол гаргах боломжтой байна уу?” гэсэн дөрвөн шалгуур үзүүлэлтүүдийн үр дүнг оруулсан.

Эхний шалгуурын хувьд судалгаанд хамрагдсан төрийн байгууллагын бүх цахим хуудсууд хандалт хийхэд нээгдэж байсан. Харин цахим хуудсанд хандсан үйлчлүүлэгчдийн тоог харах боломжийн хувьд 43.2 (35 цахим хуудас) хувь нь үйлчлүүлэгчдийн тоог харах боломжгүй байхад үлдсэн 56.8 (46 цахим хуудас) хувь нь хэдэн үйлчлүүлэгч тухайн сайтаар зочилж байгааг харах боломжгүй байна. Дараагийн үзүүлэлт болох цахим хуудсанд тавигдсан мэдээлэлд сэтгэгдэл оруулах боломжтой байдал нь Хандалт үзүүлэлтүүд дотроос хамгийн муу үр дүнтэй байна. Нийт байгууллагуудын зөвхөн дөрөвний нэг буюу 22 цахим хуудсанд (27.2%) сэтгэгдэл оруулах боломжтой харин үлдсэн 59 цахим хуудсанд (72.8%) сэтгэгдэл оруулах боломж бүрдээгүй байна. Эндээс үзэхэд төрийн байгууллагын цахим хуудсанд тавигдсан байгаа мэдээллийг үнэлэх, шинэчлэх талаар болон харилцах боломж маш хязгаарлагдмал байна. Харин нийт төрийн байгууллагын цахим хуудсын 84 хувь (68 цахим хуудас) өргөдөл, гомдол гаргах боломжийг бүрдүүлсэн байсан бол үлдсэн 16 (13 цахим хуудас) хувь нь цахим хуудсаар дамжуулан тухайн байгууллагад өргөдөл гомдол гаргах боломжгүй байна.

Дүрс 1. Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдал (хувиар харуулсан)




Төрийн байгууллагын цахим хуудсын үнэлгээний сүүлийн жилүүдийн үр дүнг 2011 онтой харьцуулахад бүгд сайжирсан, эерэг үзүүлэлтийг харуулж байна. Ялангуяа 2017 оны үнэлгээний үр дүн 2011 оноос 25 орчим хувиар, 2016 оноос 9 орчим хувиар сайн үнэлэгдсэн нь хамгийн өндөр үзүүлэлтийг харуулж байна. Сүүлийн 2 жилийн үнэлгээний хувьд 46-55 хувьтайгаар үнэлэгдсэн нь төрийн байгууллагын цахим хуудсын ил тод байдал "зарим талаар ил тод" гэсэн ангилалд байгаа хэрэг юм.

Энэ нь нэг талаас төрийн байгууллагуудын цахим хуудсын ил тод байдал нь талаас "Шилэн дансны тухай хууль" хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор өмнөх оны үзүүлэлтээс 9,3 хувиар өссөн байна. Гэсэн хэдий ч дээрхи үзүүлэлт нь цахим хуудасны мэдээллийн "Ил тод" түвшинд хүрэх хэмжээний хангалттай үзүүлэлт биш юм. Мөн төрийн байгууллагуудын 94 (76 цахим хуудас) орчим хувь нь шилэн дансны тусгайлсан цэс бий болгож, холбогдолтой мэдээллийг ил тод болгож байна. Энэ нь өнгөрсөн оныхоос дөрвөн хувиөр өссөн үзүүлэлт юм.

Төрийн байгууллагууд жил бүрийн үнэлгээнд жигд бус өөрлөлтийг үзүүлж байгааг дээрх дүрсээс харж болох юм. Тухайлбал 2011 онд яамд, 2015 онд Яамд, 2016 онд нийслэл дүүргүүд, 2017 онд Аймгуудын цахим хуудсын үнэлгээ бусдаас өндөр хувьтай үнэлэгдсэн байгаа нь төрийн байгууллагуудын цахим хуудсын ил тод байдал тогтворжоогүй байгааг илтгэж байна.

**Мэдээллийн хамааралтай байдал**

Энэ хэсэгт ЗГ-ын 143 дугаар тогтоолд цахим хуудаст тавигдсан байхаар заасан дөрвөн хүрээний дагуу 40 төрлийн мэдээллийг цахим хуудсандаа ил тод болгож буй эсэхийг үнэлсэн.

Дүрс 2. Төрийн байгууллагын мэдээллийн хамааралтай байдал (хувиар харуулсан)




Төрийн байгууллагуудын мэдээллийн хамааралтай байдлын 2017 оны үзүүлэлтийг өмнөх гурван жилийн үр дүнтэй харьцуулахад өссөн байгааг дээрхи графикаас харж болно. Нийслэл дүүргүүдийн хувьд энэ жилийн үнэлгээгээр өнгөрсөн жилийн үзүүлтүүдээс буурсан байна.

## Мэдээллийн найдвартай байдал

Мэдээллийн найдвартай байдлын үзүүлэлтийг тухайн цахим хуудаст тавьсан мэдээллийн эх сурвалж, нийтэлсэн хүний овог нэр байгаа эсэх зэрэг үзүүлэлтийг авч үзсэн юм.

Дүрс 3. Төрийн байгууллагын мэдээллийн найдвартай байдал (хувиар харуулсан)




Мэдээллийн найдвартай байдлын үзүүлэлтүүд 2011 оны судалгааны үр дүнгээр маш хангалтгүй үнэлэгдсэн байна. 2011 оны судалгааны үр дүнтэй сүүлийн 3 жилийн үзүүлэлтийг харьцуулж үзэхэд нилээдгүй хувиар өссөн байгааг дээрхи хүснэгтээс харж болно. Төрийн байгууллагын мэдээллийн найдвартай байдлыг дундаж үзүүлэлтээр нь харьцуулан авч үзвэл өнгөрсөн оны үр дүнгээс энэ жилийн үнэлгээний үр дүн бага зэрэг буурсан байна. Учир нь 2016 онд Парламентийн байгууллагуудын цахим хуудасны үнэлгээний үр дүн маш өндөр гарсан. Дараа жилийн үнэлгээгээр парламетийн байгууллагуудын үнэлгээ 39 хувиар буурсан нь нөлөөлж байна.

### Мэдээллийн цаг үеийн байдал

Мэдээллийн цаг үеийн байдал гэдэгт төрийн байгууллагууд цахим хуудастаа цаг үеийн, ач холбогдлоо алдаагүй мэдээлэл оруулж чадаж байгаа эсэхээр үнэлсэн. (Harris, 2010). Өөрөөр хэлбэл, төрөөс иргэдэд хүргэж буй мэдээлэл цаг үеэ олсон, тогтмол давтамжтай шинэчлэгддэг бөгөөд уг мэдээллийг хэрэглэгчид хүлээн авч, ашиглах боломжтой байдлыг бүрдүүлж байгаа эсэхийг энэ үзүүлэлтээр хянах юм.

Дүрс 4. Төрийн байгууллагын мэдээллийн цаг үеийн байдал (хувиар харуулсан)




Мэдээллийн цаг үеийн байдлын үзүүлэлт төрийн байгууллагуудын хувьд буурсан үр дүнг харуулж байна. Харин 2017 оны үнэлгээний үр дүнгээр Яамд, хэрэгжүүлэгч агентлагууд болон нийслэл дүүргүүдийн мэдээллийн цаг үеийн байдал өмнөх оны үнэлгээний үр дүнгээс 20 орчим хувиар буурсан. Дээрх төрийн байгууллагуудаас аймгуудын цахим хуудасны үнэлгээний үр дүн “Хаалттай” гэсэн ангилалаас “Ил тод” гэсэн ангилалд орсон гэдгийг дээрх графикаас харж болно. Аймгууд өнгөрсөн нэг жилийн хугацаанд цахим хуудасандаа цаг үеийн, ач холбогдлоо алдаагүй мэдээлэл оруулахдаа анхаардаг болсон нь ажиглагдаж байна.

### Мэдээллийн хүртээмжтэй байдал

Энэ үзүүлэлтээр цахим хуудас хэрэглэгчид төрийн байгууллагад шууд хандан зөвлөгөө, мэдээлэл авах боломж олгосон, хоёр талын харилцааг хангахуйц байгаа эсэхийг хэмжинэ (Drew & Nyerges, 2004, p. 57). Ингэхдээ өмнөх гурван үзүүлэлтээс ялгаатай нь мэдээллийн агуулгад бус, цахим хуудаст өөрт нь холбогдох хэмжүүрүүдийн дагуу шинжилгээ хийдэг.

Дүрс 5. Төрийн байгууллагын мэдээллийн хүртээмжтэй байдал (хувиар харуулсан)




Төрийн байгууллагуудын цахим хуудсаны мэдээллийн хүртээмжтэй байдал нь 2011 оноос хойш буурсан үзүүлэлтүүд ажиглагдаж байгаа бол энэ жилийн үзүүлэлт өмнөх жилүүдийн үзүүлэлтүүдээс өссөн байна. Дээрх дүрсээс харахад ихэнхи төрийн байгууллагуудын цахим хуудасны хүртээмжтэй байдлын үзүүлэлтэд эерэг өөрчлөлт гарчээ.

Өмнөх жилийн судалгааны үр дүнгээр 27.3 хувьтай буюу тааруу дүгнэгдэж байсан нийслэл дүүргүүдийн цахим хуудасны хүртээмжтэй байдлын үзүүлэлт энэ оны судалгаагаар хамгийн өндөр ахиц гаргаж 66.3 хувь болсон нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Мөн нэмэлт байдлаар цахим хуудасны хүртээмжтэй байдлыг тодруулах зорилготой 5 шалгуур үзүүлэлтээр үнэлсэн. Нэгдүгээр шалгуур үзүүлэлт болох “Цахим хуудсанд Асуулт хариултын булан байна уу? ” гэсэн үзүүлэлтэд 28.4 (23 цахим хуудас) хувь нь асуулт хариултын булантай байсан бол үлдсэн 71.6 (58 цахим хуудас) хувь нь тухайн цахим хуудсанд асуулт хариултын булан байхгүй байна. Эндээс үзэхэд судалгаанд хамрагдсан байгууллагуудын дийлэнх цахим хуудсууд үйлчлүүлэгч хүссэн зүйлээ хайх боломжгүй байгаа нь хүртээмжтэй байдал хангалтгүй гэж үзэж болно.

Дараагийн шалгуур үзүүлэлт болох “Хэлэлцүүлгийн булан байн уу?” гэсэн шалгуур үзүүлэлтэд 82.7 (67 цахим хуудас) хувь нь хэлэлцүүлгийн булан байхгүй гэсэн үр дүн гарсан. “Холбоотой байгууллагуудын холбоос линк байна уу? ” гэсэн шалгуур үзүүэлэлтэд судалгаанд хамрагдсан байгууллагуудын 80.2 (65 цахим хуудас) хувь нь холбоотой байгууллагуудын линк байна гэсэн үр дүн гарсан байна. “Тогтмол асуудаг асуултуудын хариулт байна уу?” гэсэн үзүүлэлтэд 70.4 (57 цахим хуудас) хувь нь тогтмол асуудаг асуултуудын хариулт байхгүй байна гэсэн үр дүн гарсан.

Сүүлийн шалгуур үзүүлэлт болох “Хэлний сонголт байна уу?” гэсэн үзүүлэлтэд судалгаанд хамрагдсан төрийн байгууллагын цахим хуудсуудын 43.2 (35 цахим хуудас) хувь нь Хэлний сонголттой цахим хуудас байсан бол 56.8 хувь буюу 46 цахим хуудас ямар нэгэн хэлний сонголтгүй байсан. Эндээс үзэхэд 50-с дээш хувь нь хэлний сонголтгүй байгаа нь монгол иргэдээс гадна бусад сонирхогч оролцогч талуудад (тухайлбал Монгол дахь донор байгууллагууд, Монгол улсад түр болон урт хугацаагаар оршин сууж буй гадаад иргэд) хүртээмж хангалтгүй байгаа нь ажиглагдаж байна.

## Цахим хуудсыг хэрэглэхэд хялбар байдал

Хэрэглэгчид тухайн цахим хуудсыг хэрэглэхэд хялбар байгаа эсэхийг мөн хэмжсэн. Үүнд цахим хуудасны туслах хэрэгслүүд, үзэмж, төрх, дизайн зэрэг багтана (Weakley, 2004). Аливаа цахим хуудас нь иргэдийн интернэт хэрэглэх чадварт нийцсэн, энгийн, ойлгомжтой байх нь хэрэглэхэд хялбар байдлыг илтгэх чухал үзүүлэлт болдог.

**Дүрс 6. Төрийн байгууллагын цахим хуудасны хэрэглэхэд хялбар байдал (хувиар харуулсан)**




Цахим хуудасны хэрэглэхэд хялбар байдлын үзүүлэлт бусад үзүүлэлттэй харьцуулахад харьцангүй өндөр үзүүлэлттэй гардаг. Цахим хуудсын хэрэглэхэд хялбар байдлын үзүүлэлт 2015 оны үнэлгээний дүнгээр хамгийн өндөр буюу 76 орчим хувьтай үнэлэгдсэн байна. Харин 2016 онд төрийн байгууллагуудын цахим хуудсын хэрэглэхэд хялбар байдлын үзүүлэлт огцом буурч 55 орчим хувьтай үнэлэгдсэн нь сөрөг үзүүлэлт болж байсан. 2017 оны үзүүлэлт 69 орчим хувьтай байгаа нь 2016 оны үзүүлэлттэй харьцуулахад өсөлттэй байна. дүрсээс харахад өнгөрсөн онд хамгийн өндөр үзүүлэлт харуулж байсан парламентын байгууллагуудын үзүүлэлт 35 орчим хувиар буурч 60 хувьтай болсон бол энэ оны хувьд мөн адил парлементийн байгууллагууд 7 орчим хувиар буурч сөрөг үзүүлэлт гарсан байгаа нь дээрх графикаас ажиглагдаж байна.

Мөн цахим хуудсыг хэрэглэхэд хялбар байдлыг нэмэлт багц арван шалгуур үзүүлэлтүүдээр (өнгөний зохицол, хайлтын цэс гэх мэт) авч үзсэн. Шалгуур үзүүлэлтүүдийг дундажлан авч үзвэл 69.4 хувь нь сайтын хэрэглэхэд хялбар байдлын үзүүлэлтүүдээ цахим хуудсандаа байрлуулсан сайн үзүүлэлттэй байна.

# ЯАМДЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ҮЗҮҮЛЭЛТ

Энэ бүлэгт одоо үйл ажиллагаа явуулж буй нийт 13 яамны албан ёсны цахим хуудаст хийсэн мониторингийн нэгдсэн үр дүнг харуулна.

Яамдын цахим хуудсыг таван үзүүлэлт тус бүрээр болон нийлбэр оноогоор өмнөх жилүүдийн судалгааны үр дүнтэй харьцуулан харуулав.

**Хүснэгт 2. Яамдын цахим хуудасны ерөнхий үзүүлэлт(хувиар)**

| № | Яам | Нийлбэр оноо | | | | Эрэмбэ /Ранк/ | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2011 | 2015 | 2016 | 2017 | 2011 | 2015 | 2016 | 2017 |
| 1 | Байгаль орчин, аялал жуулчлалын яам | 40.6 | 45.3 | 54.7 | 37.2 | 9 | 69 | 28 | **71** |
| 2 | Гадаад харилцааны яам | 27 | 56 | 48.5 | 46.1 | 47 | 29 | 37 | **57** |
| 3 | Сангийн яам | 47.2 | **74** | **62.6** | 51.3 | 3 | 1 | 10 | **48** |
| 4 | Хууль зүй, дотоод хэргийн яам | - | 53.9 | 21.2 | 37.7 | - | 37 | 76 | 70 |
| 5 | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | **63.1** | 59.5 | 33.7 | 51.6 | 1 | 19 | 65 | 46 |
| 6 | Барилга, хот байгуулалтын яам | - | 59.7 | 49.8 | 60.7 | - | 18 | 40 | 28 |
| 7 | Батлан хамгаалах яам | 33.4 | 46.2 | 51.8 | 46.7 | 24 | 63 | 37 | **55** |
| 8 | Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын яам | 46 | 65.9 | 61.7 | 55 | 4 | 8 | 13 | **42** |
| 9 | Зам, тээвэр хөгжлийн яам | - | 67.4 | 56.9 | 58.9 | - | 3 | 19 | **33** |
| 10 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам | 31.6 | 64.9 | 53.3 | 50 | 31 | 11 | 34 | **50** |
| 11 | Эрчим хүчний яам | - | 67.4 | 35 | **62.3** | - | 4 | 63 | 26 |
| 12 | Эрүүл мэндийн яам | 25.1 | 63.3 | 55.9 | 28.9 | 53 | 13 | 24 | **74** |
| 13 | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам | - | 45.2 | - | 49.7 | - | 70 | 80 | 51 |
| **Яамдын дундаж** | | **39.2** | **58.5** | **45.2** | **48.2** | | | | |
| **Ерөнхий дундаж** | | **28.7** | **52.2** | **45.9** | **55.4** | | | | |

Энэ жилийн яамдуудын дундаж үзүүлэлтийг 2016 оны үр дүнтэй харьцуулахад бага зэрэг (3 хувиар) өссөн үзүүлэлт харагдаж байгаа боловч яамдын дундаж үзүүлэлт нийт төрийн байгууллагуудын дундаж үзүүлэлтээс 7 хувиар бага гарсан байна. Нийт яамдын үзүүлэлтүүд өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад 2-27 хувиар нэмэгдсэн нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Нийт төрийн байгууллагуудын үзүүлэлтүүдийг хооронд нь эрэмбэлж үзэхэд, Эрчим хүчний яам 62.3 оноо (ил тод байгууллага) авсан үзүүлэлтээр 1-рт эрэмбэлэгдэж байна. Тодруулвал энэ оны үзүүлэлт өнгөрсөн оноос хамгийн их хувиар өссөн үзүүлэлт харагдаж байна. 2017 оны үр дүнгээр нийт 13 яамдын хувьд Барилга хот байгуулалтын яам, Эрчим хүчний яам **"Ил тод"** гэсэн ангилалд хамаарч байна. **"Зарим талаараа ил тод"** гэсэн ангилалд Гадаад хэргийн яам, Сангийн яам, Хөдөлмөр нийгэм хамгааллын яам, Барилга, хот байгуулалтын яам, Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын яам, Зам тээвэр хөгжлийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамдууд хамаарч байгаа бол Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Эрүүл мэндийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамдууд **"Хаалттай"** гэсэн ангилалд хамаарч байна.

Судалгааны дээрх үр дүнг бүх онуудаар харьцуулан харвал хоёр жил дараалан хамгийн өндөр үзүүлэлтийг Сангийн яам (2015, 2016 онуудад) үзүүлж байсан бол 2011 оны судалгаагаар яамдууды хамгийн өндөр үзүүлэлт нь 63.1 хувьтай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам байсан байна. Хэдийгээр зарим яамдуудын ранк өнгөрсөн жилийнхтэй харьцуулахад буурсан (13 яамны 8 яам нь буурсан) боловч яамны болон ерөнхий дунжаараа өссөн байна.

Яамдуудын цахим хуудасны мониторингийн үр дүнг таван үзүүлэлт тус бүрээр, дөрвөн оноор харьцуулсан үр дүнг дараах графикт харууллаа.

Дүрс 7. Яамдын цахим хуудасны ил тод байдал (хувиар харуулсан)




Дээрх хүснэгтээс харахад яамдуудын ил байдлын үзүүлэлтийн дундаж 2015 онд хамгийн өндөр (58.5%) байна. Харин 2017 оны судалгааны үр дүнгийн дундаж (48.2%) 2016 оныхоос 3 хувиар л дээшилсэн үзүүлэлт харагдаж байна. 2017 оны үзүүлэлтийг үзүүлэлт бус бүрээр задлан харвал өнгөрсөн оноосоо 3 үзүүлэлт буюу хялбар байдал, хүртээмжтэй байдал, хамааралтай байдал зэрэг нь 4-20 хувиар дээшилсэн бол үлдсэн 2 үзүүлэлт 1-24 хувиар буурсан байна. Өнгөрсөн оноос мэдээллийн хүртээмжтэй байдал 20 хувиар өссөн байгаа хэдий ч мэдээллийн цаг үеийн байдал 24 хувиар буурсан муу үзүүлэлтийг дээрх графикаас харагдаж байна. Хүртээмжтэй байдлыг үнэлсэн шалгуурруудаас “холбоотой байгууллагын холбоос линк” (84.6%), “хэлний сонголт” (61.5%) зэрэг нь өндөр үзүүлэлттэй байгаа бол “асуулт хариултын булан”, “тогтмол асуудаг асуултуудын хариулт”, “хэлэлцүүлгийн булан” зэрэг нь яамдуудын сайтанд муу үзүүлэлттэй байна.

Яамдуудын сайтыг ил тод байдлын үзүүлэлтээр жагсааж дараах хүснэгтэнд харуулав.

Хүснэгт 3. ТОП 5 үзүүлэлттэй яам, 2016 болон 2017 (хувь)

| № | Яамдын нэрс | 2016 Нийлбэр оноо | Яамдын нэрс | 2017 Нийлбэр оноо |
|---|---|---|---|---|
| 1 | Сангийн яам | 62.6 | Эрчим хүчний яам | 62.3 |
| 2 | Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын яам | 61.7 | Барилга, хот байгуулалтын яам | 60.7 |
| 3 | Зам, тээвэр хөгжлийн яам | 57 | Зам, тээвэр хөгжлийн яам | 58.9 |
| 4 | Эрүүл мэндийн яам | 55.9 | Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын яам | 55 |
| 5 | Байгаль орчин, аялал жуулчлалын яам | 54.7 | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | 51.6 |

Дээрх хүснэгтээс харахад Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын яам болон Зам, тээвэр хөгжлийн яамууд нь 2016 болон 2017 онуудад давтан топ 5-н үзүүлэлттэй яаманд багтаж байна.
2017 оны байдлаар топ 5-н үзүүлэлттэй яамыг тэргүүлсэн Эрчим хүчний яамны цахим хуудсыг зураг 1-с харна уу.

**Зураг 1. Эрчим хүчний яамны цахим хуудсан дахь мэдээллийн ил тод байдлын жишээ**




## 2.2.1 Үйл ажиллагааны ил тод байдал

Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг авч үзэхдээ 1. Байгууллагын ерөнхий мэдээлэл, 2. Байгууллагын олон нийттэй харилцах мэдээлэл гэсэн хоёр хэсэгт ангилан авч үзсэн.

***Байгууллагын ерөнхий мэдээлэл.*** Яамдын цахим хуудсанд хийсэн мониторингийн 201 оны үр дүнгээс харахад нийт судалгаанд хамрагдсан яамдын үзүүлэлтүүд өмнөх судалгааны үр дүнгээс 7-15 хувиар дээшилсэн үзүүлэлт харагдаж байна. Дээрх дүрсээс харахад яамдууд “эрхэм зорилго”, “үйл ажиллагааны стратегийн зорилго, зорилт”-ыг цахим хуудсанаа байршуулдаг байдал нь 2016 оны үр дүнгүүдээс өсч “бүрэн ил тод” гэсэн ангилалд хамаарах болсон байна. 2017 оны үзүүлэлтийн хувьд тэргүүлэх чиглэлийн мэдээллийг цахим хуудсандаа байршуулдаг байдал өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад 15 орчим хувиар нэмэгдсэн боловч бусад шалгуур үзүүлэлтээс 2017 оноос бусад онуудад доогуурхувьтай дүгнэгдсэн байна. Харин яамдууд байгууллагынхаа эрхэм зорилгын талаар цахим хуудсандаа байршуулдаг бүхий л онууда өндөр байна.

Дүрс 8. Яамдын ерөнхий мэдээлэл (хувь)




Дээрх хүснэгтээс харахад ихэнх яамдуудын ерөнхий мэдээлэл бүрэн ил тод гэсэн ангилалд орсноос харахад яамдууд цахим хуудасны ил тод байдалдаа анхаардаг болсон нь ажиглагдаж байна.

### *Байгууллагын олон нийттэй харилцах мэдээлэл.*

Байгууллагын олон нийттэй харилцах мэдээллийг дараах дүрсэд үзүүлсэн 11 үзүүлэлтээр хэмжсэн. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад яамдууд холбоо барих мэдээллүүд болох утасны дугаар, хаяг, факсын дугаар зэрэг мэдээллүүдээ цахим хуудастаа байршуулах байдал ихэнхи үзүүлэлтийн хувьд нэмэгдсэн байна. Эдгээрээс “олон нийттэй харилцах мэргэжилтний овог нэр” цахим хуудсанд байршуулах байдал 2015 онд хамгийн их хувиар буюу 6,2 хувиас 40 хувь болтлоо, 2016 онд 40-77 хувь болтлоо огцом дээшилсэн бол энэ жилийн үнэлгээгээр эргээд огцом унасан байна.

Эсрэгээр “байгууллагын хаяг” “ байгууллагын холбоо барих утас”, “цахим шуудангийн хаяг” зэрэг үзүүлэлт сүүлийн жилийн үнэлгээгээр 90-с дээш хувьтай үнэлэгдсэн нь тухайн шалгуур үзүүлэлтүүдийн хувьд ”бүрэн ил тод” гэсэн ангилалд багтаж байгаа юм.

**Дүрс 9. Яамдын цахим хуудас дахь байгууллагын олон нийттэй харилцах мэдээлэл (хувь)**




Ерөнхийд нь дүгнэхэд яамдын үйл ажиллагааны ил тод байдал 60,1 хувьтай үнэлэгдсэн хэдий ч “Төрийн үйлчилгээ авахтай холбоотой материалын жагсаалт”, “Олон нийттэй харилцах мэргэжилтний овог нэр”, “Тухайн цахим хуудаснаас шууд холбогдох боломж” гэсэн шалгуур үзүүлэлтүүдийн мэдээлэл цахим хуудсанд дутмаг тавигдсан байна. Энэ нь иргэд төрийн байгууллагаас үйлчилгээ авахдаа цаг хугацаа алдахгүйгээр цахим хуудсаар дамжуулан мэдээлэл авах байдал хязгаарлагдмал байна.

## 2.2.2 Хүний нөөцийн ил тод байдал

Хүний нөөцийн ил тод байдлын үзүүлэлтийг  2011 болон 2014 онд “хүний нөөцийн ил тод байдал” гэсэн хэсгийг дүгнэхдээ “сул орон тооны зар”, “албан хаагчийн ёс зүйн дүрэм” гэсэн 2 үзүүлэлтээр хэмжиж байсан бол 2015 оноос хуульд тусгагдсанчлан “хүний нөөцийн стратеги,  түүнийг хянаж үнэлэх журам”, хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах

чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх мэдээлэл" "Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх мэдээлэл" гэсэн гурван үзүүлэлт нэмэн оруулсан.

Энэ жилийн үнэлгээний үр дүнгээр яамдуудын хүний нөөцийн ил тод байдал 38 орчим хувьтай дүгнэгдсэн байгаа нь хаалттай ангилалд орох хэдий ч 2016 онтой харьцуулахад арав орчим хувиар өссөн эерэг үр дүнг харуулж байна.

**Дүрс 11. Яамдын хүний нөөцийн ил тод байдлын үзүүлэлт (хувь)**




2011 оноос хойш "хүний нөөцийн ил тод байдал" гэсэн хэсгийг дүгнэхдээ ашигладаг байсан шалгуур үзүүлэлтүүд төрийн байгууллагууд цахим хуудсандаа мэдээллийг түлхүү оруулдаг нь харагдаж байна. Харин 2015 оноос хойш нэмэгдсэн гурван шалгуур үзүүлэлтүүдийн мэдээллүүд дутмаг байдаг нь дээрх графикаас харагдаж байна. Өмнөх жилүүдийн судалгаанд мэдээллийн эх сурвалжтай байдал маш бага хувьтай цахим хуудсанд тавигдаж байсан ба тэдгээр мэдээллийн эх сурвалж тодорхойгүй байдал ажиглагдаж байсан бол 2017 оны судалгаагаар мэдээллийн цаг үеийн байдлын хувьд ач холбогдлоо алдах тохиолдол их байна.

Зураг 2. Эрчим хүчний яамны  хүний нөөцийн мэдээлэл




Дээрх зурагт харагдаж байгаачлан эрчим хүчний яамны цахим хуудаст хүний нөөцийн талаарх мэдээлэл агуулсан тусгай цэс байгаа бөгөөд тухайн цэсэнд энэхүү судалгааны хүний нөөцийн ил тод байдлыг үнэлэх шалгуур тус бүрээр дэд сонголттой цэс гаргасан байсан тул сайн жишээгээр орууллаа.

## 2.2.3 Төсөв санхүүгийн ил тод байдал

Төсвийн ил тод байдлыг үнэлсэн дараах 11 үзүүлэлтийн 7 нь өмнөх судалгаанд ашиглагдсан ба энэ жил шинээр 4 үзүүлэлт нэмж оруулсан юм. Эдгээр үзүүлэлтүүдээс “шилэн дансны тусгай цэс” нь байршуулсан байдал хамгийн өндөр хувьтай байгаа нь эерэг үр дүнг харуулж байна. Мөн өмнөх оны судалгааны үр дүнтэй харьцуулан харвал ихэнхи нь нэлээд хувиар өсөлттэй байгааг дараах дүрсээс харж болохоор байна.

### Дүрс 10. Яамдын төсөв санхүүгийн ил тод байдлын үзүүлэлтүүд (хувь)




Энэ оны үнэлгээний үр дүнгээр ихэнх үзүүлэлтийн ил тод байдлын хувь буурсан байгаа ба тэр дундаа “санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлт”, “аудитын тайлан дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээлэл” зэрэг нь огт ил тод бус байна.

Яамдын цахим хуудсанд “шилэн дансны цэс байх”, төсвийн хэмнэлт хэтрэлт түүний шалтгааны тайлбар, төсвийн гүйцэтгэлийн биелэлт зэргийн мэдээлэл хамгийн өндөр хувьтай ил тод болсон хэвээр байна.

Харин яамдын төсөв санхүүгийн ил тод байдлын шалгуур тус бүрээр төсөв, санхүүгийн мэдээллийн ил тод байдлыг авч үзвэл мэдээллийг ил тод болгож буй хамааралтай байдал болон мэдээллийн эх сурвалжтай байдал өмнөх оноос бага зэрэг буурсан байна. Харин мэдээллийн цаг үеийн байдлын үзүүлэлт өнгөрсөн жилүүдээс өсөлттэй байгааг дүрс 11-с харж болно. Яамдын төсөв санхүүгийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулахдаа цаг хугацааны хувьд тохирсон тодорхой байдлыг-28.6 хувиас, тус мэдээллийн эх сурвалж тодорхой байдалыг- 28.6 хувиас, төсөв, санхүүгийн талаарх мэдээлэл байгаа эсэхийг-42.8 хувиас тус тус бодож боловсруулсан.

**Дүрс 11. Яамдын төсөв санхүүгийн ил тод байдал (хувь)**




Төсөв санхүүтэй холбоотой мэдээллийн ил тод байдал нь "шилэн дансны хууль"-аар зохицуулагдаж байгаа бөгөөд хууль хэрэгжиж эхэлсэн сүүлийн хоёр жилийн хугацаанд эх сурвалжтай байдал 2015 онд огцом өсөөд 2016, 2017 онуудад буурсан үзүүлэлттэй байгааг дээрх дүрсээс харж болох юм.

**Хүснэгт 4. Төсөв санхүүгийн ил тод байдал ТОП 5 яам (хувь)**

| Яамд | Төсөв санхүүгийн мэдээлэл байгаа эсэх | Эх сурвалж тодорхой эсэх | Цаг хугацаа нь байгаа эсэх | Нийт хувь |
|---|---|---|---|---|
| Эрчим хүчний яам | 31.1 | 20.0 | 28.6 | 79.7 |
| Уул уурхай хүнд үйлдвэрийн яам | 31.1 | 20.0 | 27.0 | 78.2 |
| Зам тээвэр хөгжлийн яам | 31.1 | 20.0 | 25.4 | 76.6 |
| Гадаад харилцааны яам | 27.2 | 17.2 | 25.4 | 69.8 |
| Батлан хамгаалах яам | 27.2 | 17.2 | 20.7 | 65.1 |

Дээрх хүснэгтээр "төсөв санхүүгийн ил тод байдал"-аар хамгийн өндөр үзүүлэлттэй байгаа 5-н яамыг жагсаасан болно. Урчим хүчний яам хамгийн өндөр үзүүлэлттэй байгаа бол бусад 4 яамд ижил 65-70 орчим хувьтай ард нь үнэлэгджээ. Гэсэн ч эдгээр топ үзүүлэлттэй яамд нь төсөв санхүүгийн мэдээллийн хувьд "бүрэн ил тод" гэсэн ангилалд хараахан багтаагүй байна.

Яамдаас төсөв санхүүгийн мэдээлэл агуулсан шилэн дансны тусгай цэсгүй болон шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цэс үүсгэгдээгүй байгууллага байхгүй байна. Гэвч тухайн шилэн дансны цэс нь "шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд" холбогдох, түүндээ мэдээллээ оруулаагүй байх тохиолдол их гарч байна.

## 2.2.4 Худалдан авах ажиллагааны ил тод байдал

Яамдын хувьд ХАА-ны тухай мэдээлэл буюу тендертэй холбоотой баримт бичгийг цахим хуудастаа цаг тухай бүрт нь байршуулах ёстой юм. Шилэн дансны хууль батлагдсантай

холбогдуулан өмнө нь 4 үзүүлэлтээр хэмжигддэг байсан худалдан авах ажиллагааны ил тод байдал 2015 оноос хойш 9 үзүүлэлтээр хэмжиж байна.

**Дүрс 12. Яамдын ХАА-ны ил тод байдлын үзүүлэлт (хувь)**




Энэ жилийн үнэлгээний үр дүнгээр тендер шалгаруулал явуулах журам огт байршуулдаггүй нь харагдаж байна. Өнгөрсөн жилийн үзүүлэлтээс хамгийн өндөр өсөлттэй байгаа үзүүлэлт бол “мөнгө зарцуулах өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр” өнгөрсөн жилийн үнэлгээнээс 76.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Дүрс 13. Яамдын ХАА-ны ил тод байдал (хувь)




Дээрх дүрсээс харахад 2016 оны хувьд яамдын ХАА-ны ил тод байдал 29.4 хувьтай байсан нь энэ жилийн судалгааны дүнгээр 37.4 хувь болж нэлээд хэмжээгээр өссөн байна. Гэвч ил тод байдал гэсэн шалгуурт ороход болоогүй байна. Нарийчилсан үзүүлэлтээс харахад ХАА-ны талаарх мэдээллийн найдвартай байдал буюу эх сурвалж тодорхой байдал зэрэг нь гурав орчим хувиар, цаг хугацааны тохиромжит байдал нь хоёр орчим хувиар нэмэгдсэн байгааг харж болох юм.

Хүснэгт 5. ХАА-ны ил тод байдал ТОП 3 яам (хувь)

| **Яамд** | **Мэдээлэл байгаа эсэх** | **Эх сур-валж тодорхой эсэх** | **Цаг хугацаа нь байгаа эсэх** | **Нийт хувь** |
|---|---|---|---|---|
| Барилга хот байгуулалтын яам | 23.8 | 15.9 | 16.1 | 55.8 |
| Эрчим хүчний яам | 23.8 | 15.9 | 14.3 | 54.0 |
| Боловсрол соёл шинжлэх ухааны яам | 19.0 | 12.7 | 14.3 | 46.0 |

Нийт судалгаанд хамрагдсан яамдаас хамгийн өндөр оноо авсан нь Барилга хот байгуулалтын яам (55.8%), Эрчим хүчний яам (54%) болон боловсрол соёл шинжлэх ухааны яам (46%) дууд хоёр болон гарвдугаар байрт жагссан байна.

Нийт 13 яамны 50 хувь нь буюу найм нь ХАА-ны талаарх мэдээллийг ямар нэгэн байдлаар цахим хуудастаа ил тод байршуулсан байна.

## 2.1 ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГУУДЫН ВЕБСАЙТЫН ҮЗҮҮЛЭЛТ

Энэ хэсэгт одоо үйл ажиллагаа явуулж буй нийт 17 хэрэгжүүлэгч агентлагуудын албан ёсны цахим хуудаст хийсэн мониторингийн нэгдсэн үр дүнг харуулна.

Хэрэгжүүлэгч агентлагуудын цахим хуудсыг 5 үзүүлэлт тус бүрээр болон нийлбэр оноогоор өмнөх жилүүдийн судалгааны үр дүнтэй харьцуулан харуулав.

**Хүснэгт 6. Хэрэгжүүлэгч агентлагуудын цахим хуудасны ерөнхий үзүүлэлт (хувь)**

| № | Нэрс | Нийлбэр оноо | | | | Эрэмбэ /Ранк/ | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2011 | 2015 | 2016 | 2017 | 2011 | 2015 | 2016 | 2017 |
| 1 | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар | - | - | 44.2 | 60.1 | - | - | 50 | 30 |
| 2 | Биеийн тамир, спортын газар | - | - | 40 | 43.9 | - | - | 58 | 63 |
| 3 | Цаг уур, орчны шинжилгээний газар | 49 | 18.2 | 56.1 | 58.1 | 2 | 84 | 23 | 35 |
| 4 | Гаалийн ерөнхий газар | 32.4 | 54.9 | 42.9 | 48.3 | 27 | 35 | 55 | 54 |
| 5 | Татварын ерөнхий газар | 35.9 | 47 | 61.8 | 46.0 | 17 | 61 | 12 | 58 |
| 6 | Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар | 33.9 | 56.6 | 60 | 60.8 | 23 | 26 | 18 | 27 |
| 7 | Архивын ерөнхий газар | 34.3 | 50.1 | 53 | 58.2 | 21 | 49 | 36 | 34 |
| 8 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар | 29.7 | 52.3 | 68.9 | 65.6 | 39 | 42 | 7 | 22 |
| 9 | Гадаадын иргэн, харьяатын газар | 36.2 | 41.2 | 65.8 | 55.2 | 15 | 74 | 9 | 41 |
| 10 | Соёл урлагийн газар | | | 53 | 22.6 | | | 36 | 77 |
| 11 | Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар | 24.4 | 40.3 | 70 | 41.4 | 57 | 75 | 5 | 68 |
| 12 | Иргэний нисэхийн ерөнхий газар | 31.5 | 31.7 | 71.9 | 51.4 | 32 | 82 | 3 | 47 |
| 13 | Ашигт малтмал, газрын тосны газар | 23.1 | 52 | 41.5 | 56.0 | 60 | 45 | 56 | |
| 14 | Мал эмнэлэг, үржлийн газар | 31.8 | 48.8 | 46.9 | 55.4 | 29 | 52 | 46 | 40 |
| 15 | Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар | 38 | 45.3 | 70 | 52.6 | 12 | 67 | 11 | 38 |
| 16 | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар | 43.9 | 43.4 | 11 | 66.4 | 5 | 73 | 78 | 20 |
| 17 | Гэр бүл, Хүүхэд залуучуудын хөгжлийн газар | 35.8 | 48.2 | 11 | 43.5 | 18 | 55 | 79 | 64 |
| **Хэрэгжүүлэгч агентлагийн дундаж** | | | **44.5** | **50.6** | **52.1** | | | | |
| **Ерөнхий дундаж** | | **28.7** | **52.2** | **45.9** | **55.4** | | | | |

Хэрэгжүүлэгч агентлагуудын дундаж үзүүлэлт 2016 оны үр дүнгээс 1.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Нийт 17 агентлагаас долоон агентлагийнх нь ил тод байдлын оноо өмнөх судалгааны үр дүнгээс тодорхой хэмжээгээр буурчээ. Харин арван агентлагийн ил тод байдлын оноо өмнөх үр дүнгээс дунджаар найман хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хэрэгжүүлэгч агентлагаас хамгийн өндөр үзүүлэлттэй байгаа хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газрын үнэлгээ нь (66.4 хувь) нийт төрийн байгууллагууд дунд 20-т эрэмбэлэгдэх үзүүлэлт болж байна. Харин эсрэгээр хамгийн муу үзүүлэлттэй байгаа соёл урлагийн газрын үзүүлэлт нь нийт төрийн байгууллагууд дунд 77-р байранд эрэмбэлэгдэж байна.

Вэб мониторингийн үр дүнг таван үзүүлэлтийн дагуу 4 оноор харьцуулан, өөрчлөлтийг дараах дүрсэд харууллаа.

**Дүрс 14. Хэрэгжүүлэгч агентлагуудын цахим хуудасны ил тод байдал (хувь)**




Хэрэгжүүлэгч агентлагын цахим хуудасны үнэлгээгээр веб сайтыг хэрэглэхэд хялбар байдал болон мэдээллийн хүртээмжтэй байдлын үзүүлэлтүүд бусад шалгуур үзүүлэлтээс илүү өндөр хувьтай байна. 2017 оны судалгааны үр дүнгээр мэдээллийн цаг үеийн байдал, мэдээллийн найдвартай байдлын үзүүлэлт буурчээ. Бусад төрийн байгууллагатай харьцуулахад хэрэгжүүлэгч агентлагын цахим хуудсын ил тод байдал ихэнх үзүүлэлтээр өссөн нь сайшаалтай үр дүнг харуулсан байна.

**Хүснэгт 7. ТОП 5 үзүүлэлттэй хэрэгжүүлэгч агентлагууд (хувь)**

| Хэрэгжүүлэгч агентлагуудын нэрс | Нийлбэр оноо | | | |
|---|---|---|---|---|
| | 2011 | 2015 | 2016 | 2017 |
| Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар | 43.9 | 43.4 | 11 | 66.4 |
| Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар | 29.7 | 52.3 | 68.9 | 65.6 |
| Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар | 33.9 | 56.6 | 60 | 60.8 |
| Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар | - | - | 44.2 | 60.1 |
| Архивын ерөнхий газар | 34.3 | 50.1 | 53 | 58.2 |

2017 оны үнэлгээний үр дүнгээр хэрэгжүүлэч агентлагуудаас ХХҮЕГ-ын цахим хуудас хамгийн өндөр үнэлгээ (66.4) авсан бол өнгөрсөн жил нэгдүгээр байрт жагсаж байсан ШШГЕГ-ын цахим хуудас нэг байр ухарч хоёрдугаар байрт жагссан байна. Дээрх хүснэгтээс харахад АХГ-ын цахим хуудаснаас бусад дөрвөн цахим хуудас маань "ил тод" гэсэн ангилалд хамаарч байна.

## 2.3.1 Үйл ажиллагааны ил тод байдал

Хэрэгжүүлэгч агентлагуудын цахим хуудсанд хийсэн мониторингийн үр дүнгээс харахад нийт судалгаанд хамрагдсан агентлагуудын танилцуулга болох ерөнхий мэлээллээ цахим хуудастаа тавих байдал төдийлэн дээшлээгүй байна. Сүүлийн гурван жилийн үнэлгээнээс харахад хэрэгжүүлэгч агентлагууд байгууллагын "эрхэм зорилго",-ыг цахим хуудсанаа байршуулдаг байдал нь "бүрэн ил тод" гэсэн үнэлгээнд орохуйц болсон байна.




“Үйл ажиллагааны стратегийн зорилго, зорилт”-ын цахим хуудсандаа байршуулдаг байдал 60 орчим хувьтай байгаа нь өнгөрсөн хоёр жилийн үнэлгээний үр дүнгээс10 орчим хувиар буурчээ. Хэрэгжүүлэгч агентлагуудын хувьд байгууллагын тэргүүлэх чиглэлийг цахим хуудсаараа нийтэд ил тод болгох байдал сул байна.

**Дүрс 15. Хэрэгжүүлэгч агентлагуудын ерөнхий мэдээлэл (хувь)**




Хэрэгжүүлэгч агентлагуудын хувьд байгууллагын холбоо барих мэдээллээс холбоо барих утас, байгууллагын хаяг, цахим шуудангийн хаяг, шуудангийн хаяг, байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж буй хууль, тогтоомж, журам заавар зэргийг өндөр хувьтай ил тод болгосон байна.

Харин эсрэгээр байгууллагын олон нийттэй харилцах мэдээллээс тухайн цахим хуудаснаас шууд оператор ажилтантай шууд холбогдох боломж, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хувиар зэргийг бага хувьтай ил тод болгосон байна.

## 2.3.2 Хүний нөөцийн ил тод байдал

Хүний нөөцийн ил тод байдлыг 2011 онд зөвхөн сул орон тооны талаарх мэдээлэл байгаа эсэхээр хэмжиж байсан бол сүүлийн 2 жилийн хугацаанд “Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журам”, “Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээлэл”, “Албан хаагчийн ёс зүйн дүрэм” “Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга

болгох чигэлэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх мэдээлэл" гэсэн үзүүлэлтүүдийг нэмж дараах дүрсэд үзүүлсэн 4 үзүүлэлтээр хэмжсэн.

**Дүрс 16. Хэрэгжүүлэгч агентлагуудын хүний нөөцийн ил тод байдлын үзүүлэлт (хувь)**




Энэ онд хэрэгжүүлэгч агентлагийн хүний нөөцийн ил тод байдлын үнэлгээ энэ онд нэлээд хувьтай буурчээ. Албан хаагчийн ёс зүйн дүрэм нь 70.6 хувьтай үнэлэгдсэн нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Харин эсрэгээр хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг энэ онд огт ил тод болгоогүй байна. Мөн "Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чигэлэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх мэдээлэл"-ыг огт оруулаагүй байна.

**Дүрс 17. Хэрэгжүүлэгч агентлагуудын хүний нөөцийн ил тод байдал (хувь)**




Хэрэгжүүлэгч агентлагийн хүний нөөцийн мэдээллийн шалгуур үзүүлэлт тус бүрийн үнэлгээ энэ онд буурчээ. Тэр дундаа цахим хуудсанд “хүний нөөцийн ил тод байдлын талаарх мэдээлэлбайгаа эсэх” үзүүлэлтүүд 11.1 орчим хувьтай байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Цаашид хүний нөөцийн мэдээллийн хамааралтай байдал буюу цахим хуудсад ил тод болгох байдлыг сайжруулах шаардлагатай байна. Мөн хэрэгжүүллэгч агентлагуудын хүний нөөцийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулахдаа цаг хугацааны хувьд тохирсон тодорхой байдлыг-28.6 хувиас, тус мэдээллийн эх сурвалж тодорхой байдалыг- 28.6 хувиас, төсөв, санхүүгийн талаарх мэдээлэл байгаа эсэхийг-42.8 хувиас тус тус бодож боловсруулсан.

### 2.3.3 Төсөв санхүүгийн ил тод байдал

Төсөв санхүүгийн ил тод байдлын дундаж үзүүлэлтийг 4-н жилээр харьцуулж дараах дүрсээр харууллаа.

**Дүрс 18. Хэрэгжүүлэгч агентлагийн цахим хуудасны төсөв санхүүгийн ил тод байдлын үзүүлэлт (хувь)**




Хэрэгжүүлэгч агентлагуудын төсөв санхүүгийн холбогдолтой мэдээллийг үнэлэхэд “шилэн дансны тусгай цэс байршуулсан байдал” 70 дээш хувьтай байна. Энэ жилийн үнэлгээний үр хамгийн өндөр үнэлэгдсэн жил болж байна. Дундаж үзүүлэлтийг авч үзвэл өмнөх жилийн үзүүлэлтээс энэ жилийн үзүүлэлт даруй 25.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. хамгийн өндөр өсөлтийг үзүүлсэн шалгуур үзүүлэлт бол “төсвийн хэмнэлт хэтрэлт түүний шалтгааны тайлбар” 47 хувиар өссөн үзүүлэлт гарсан байна. Энэ нь байгууллагууд цахим хуудсны төсөв санхүүгий ил тод байдлын мэдээллийг шилэн дансанд байршуулдаг болсонтой холбож тайлбарлаж болох юм. Харин хууль тогтоомжид заасан төлбөр хураамжийн хэмжээ, аудитын тайлан дүгнэлт, түүний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг цахим хуудсандаа ил тод болгох байдал бага хувьтай хэвээр байна.

Дүрс 19. Хэрэгжүүлэгч агентлагын төсөв санхүүгийн ил тод байдал (хувь)




Төсөв санхүүгийн мэдээллийн эх сурвалжийн тодорхой байдал болон цаг үеийн тодорхой байдал нь ижил 10 орчим хувиар, харин төсөв санхүүгийн талаарх мэдээлэл оруулсан байдал нь 9.1 хувиар тус тус өссөн байна. Мөн адил төсөв санхүүгийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулахдаа цаг хугацааны хувьд тохирсон тодорхой байдлыг-28.6 хувиас, тус мэдээллийн эх сурвалж тодорхой байдалыг- 28.6 хувиас, төсөв, санхүүгийн талаарх мэдээлэл байгаа эсэхийг-42.8 хувиас тус тус бодож боловсруулсан.

Хүснэгт 8. Төсөв санхүүгийн ил тод байдлын үнэлгээТОП 5 (хувь)

| Хэрэгжүүлэгч агентлаг | Мэдээлэл байгаа эсэх | Эх сурвалж тодор-хой эсэх | Цаг хугацаа нь байгаа эсэх | Нийт хувь |
|---|---|---|---|---|
| Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар | 38.9 | 25.7 | 28.6 | 93.2 |
| Архивын ерөнхий газар | 35 | 22.9 | 28.6 | 86.5 |
| Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар | 35 | 22.9 | 28.6 | 86.5 |
| Гадаадын иргэн харъяатын газар | 35 | 22.9 | 28.6 | 86.5 |
| Цаг уур орчны шинжилгээний газар | 35 | 22.9 | 27 | 84.9 |

Нийт 17 агентлагуудыг төсөв санхүүгийн ил тод байдлаар жагсаасан байдлаас харахад ОӨУБЕГ 93.2 хувь, АЕГ, ШШГЕГ, ГИХГ-ууд 86.5 хувь, ЦУОШГ 84.9 хувиар тавдугаар байрт жагссан байна. Эндээс үзэхэд хэрэгжүүлэгч агентлагийн төсөв санхүүгийнил тод байдлын үнэлгээгээр  энхий таван байгууллагын цахим хуудсууд бүгд “бүрэн ил тод” гэсэн ангилалд хамаарч байгаа нь сайшаалтай хэрэг юм.

### 2.3.3 Худалдан авах ажиллагааны ил тод байдал

Хэрэгжүүлэгч агентлагуудын хувьд ХАА-ны тухай мэдээллээ цахим хуудастаа ил тод байршуулах байдал мөн өмнөх судалгааны үр дүнгээс ялимгүй буурсан байдалтай байна. 2016 онд 47.1 хувь байсан бол энэ жил 37.7 хувь болж 9.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Мөн адил худалдан авах ажиллагааны ил тод байдлын шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулахдаа цаг хугацааны хувьд тохирсон тодорхой байдлыг-28.6 хувиас, тус мэдээллийн эх сурвалж тодорхой байдалыг- 28.6 хувиас, төсөв, санхүүгийн талаарх мэдээлэл байгаа эсэхийг-42.8 хувиас тус тус бодож боловсруулсан.

**Дүрс 20. Хэрэгжүүлэгч агентлагын ХАА-ны ил тод байдал (хувь)**




Нарийвчилсан үзүүлэлтүүдээс харвал ХАА-ны талаарх мэдээлэл тавигдсан байдал. мэдээллийн цаг хугацааны хувьд тохирсон тодорхой байдлын үзүүлэлтүүд бараг өөрчлөгдөөгүй бол ХАА-ны талаарх тус мэдээллийн эх сурвалж тодорхой байдал 4 орчим хувиар буурсан байна.

**Хүснэгт 9. Худалдан авах ажиллагааны ил тод байдлын үнэлгээ ТОП 3 (хувь)**

| Хэрэгжүүлэгч агентлаг | Мэдээлэл байгаа эсэх | Эх сурвалж тодорхой эсэх | Цаг хугацаа нь байгаа эсэх | Нийт хувь |
|---|---|---|---|---|
| Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар | 23.7 | 15.9 | 16.1 | 55.7 |
| Ашигт малтмал, газрын тосны газар | 19 | 12.7 | 16.1 | 47.8 |
| Архивын ерөнхий газар | 19 | 12.7 | 12.5 | 44.2 |

Нийт судалгаанд хамрагдсан агентлагуудаас “соёл урлагийн газар”-аас бусад 16 агентлаг нь 40-өөс дээш хувьтай буюу ХАА-ны талаарх мэдээлэл зарим талаар ил тод гэсэн ангилалд багтаж байна.

Дүрс 21. Хэрэгжүүлэгч агентлагын ХАА-ны ил тод байдлын үзүүлэлтүүд (хувь)




Хэрэгжүүлэгч агентлагууд өөрсдийн цахим хуувастаа "*тендерийн баримт бичиг*", "*тендер шалгаруулалт явуулах журам*", "*тендерт оролцохыг сонирхогчид тавигдах шалгуур үзүүлэлт*", "*тендерийн шалгаруулалтын талаарх мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй үнэслэл*" гэсэн шалгуур үзүүлэлтүүдийн мэдээллийг цахим хуудсандаа маш хангалтгүй байршуулдаг. Энэ нь тухайн төрийн байгууллага дээр зарлагдаж байгаа тендерт оролцох байгууллагуудад хүндрэл бэрхшээлтэй. Харин эсрэгээрээ огцом өндөр өсөлттэй үр дүн үзүүлсэн шалгуур үзүүлэлтүүд хэд хэд байна. Үүнд: "*тендерийн урилга*", "*худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тайлан /5 сая төгрөгнөөс дээш/*", "*цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга*" гэсэн шалгуур үзүүлэлтүүд өнгөрсөн жилийн үзүүлэлтээс дунджаар 47 орчим хувиар өссөн нь ажиглагдаж байна.

Дүгнэж хэлэхэд хэрэгжүүлэгч агентлагуудын дундаж үзүүлэлт өмнөх оны үзүүлэлтүүдээс өссөн байгаа хэдий ч нийт төрийн байгууллагуудын цахим хуудсандаа худалдан авах ажиллагааны ил тод байдлын талаарх мэдээллүүд оруулж байгаа байдал тун хангалтгүй байсан нь мэдээлэл цуглуулалтын явцад ажиглагдаж байлаа.

## 2.2 ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГУУДЫН ВЕБСАЙТЫН ҮЗҮҮЛЭЛТ

Энэ хэсэгт одоо үйл ажиллагаа явуулж буй нийт 10 тохируулагч агентлагуудын албан ёсны цахим хуудаст хийсэн мониторингийн нэгдсэн үр дүнг харуулна. Төрийн өмчийн хороо татан буугдаж үндэсний хөгжлийн газар нэмэгдсэн байна.

Тохируулагч агентлагуудын цахим хуудсыг 5 үзүүлэлт тус бүрээр болон нийлбэр оноогоор бусад судалгааны үр дүнгүүдтэй харьцуулан харуулав.

**Хүснэгт 10. Тохируулагч агентлагуудын цахим хуудасны ерөнхий үзүүлэлт (хувь)**

| № | Нэрс | Нийлбэр оноо | | | | Эрэмбэ /Ранк/ | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2011 | 2015 | 2016 | 2017 | 2011 | 2015 | 2016 | 2017 |
| 1 | Зэвсэгт хүчний жанжин штаб | 20.3 | 29.5 | 44.03 | 26.5 | 68 | 83 | 51 | 76 |
| 2 | Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар | - | 48.1 | 31.3 | 45.8 | - | 56 | 70 | 59 |
| 3 | Мэргэжлийн хяналтын ерөнхий газар | 31.4 | 50.6 | 69.6 | 67.5 | 33 | 47 | 6 | 18 |
| 4 | Онцгой байдлын ерөнхий газар | 27.5 | 47.8 | 53.9 | 67.9 | 45 | 57 | 31 | 17 |
| 5 | Хил хамгаалах ерөнхий газар | 33.2 | 47.1 | 43.9 | 66.7 | 25 | 60 | 53 | 19 |
| 6 | Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар | 17 | 47.1 | 29.4 | 39.8 | 78 | 59 | 72 | 70 |
| 7 | Стандартчилал хэмжил зүйн газар | 31.8 | 39.9 | 54.4 | 56.7 | 30 | 76 | 29 | 37 |
| 8 | Тагнуулын ерөнхий газар | 29.9 | 35.7 | 25.2 | 12 | 38 | 78 | 74 | 78 |
| 9 | Үндэсний хөгжлийн газар | - | - | - | 45 | - | - | - | 60 |
| 10 | Цагдаагийн ерөнхий газар | 34 | 67.1 | 53.3 | 79.3 | 22 | 5 | 34 | 10 |
| **Тохируулагч агентлагийн дундаж** | | **27.9** | **46.9** | **42.4** | **50.7** | | | | |
| **Ерөнхий дундаж** | | **28.7** | **52.2** | **43.5** | **55.4** | | | | |

Тохируулагч агентлагуудын дундаж үзүүлэт энэ онд нийт төрийн байгууллагуудын дундаж үзүүлэлтээс 4.7 хувиар бага түвшинд байна. Харин 2016 оны судалгааны дундаж үзүүлэлтээс 8.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Нийт 10 агентлагаас 3 агентлагийнх (ЗХЖШ, МХЕГ, ТЕГ) нь ил тод байдлын оноо өмнөх судалгааны үр дүнгээс дунджаар 10 орчим хувиар буурчээ. Бусад 7 агентлагийн ил тод байдлын оноо өмнөх жилийн үр дүнгээс дунджаар 8.4 хувиар өссөн байна.

Өмнөх судалгааны үр дүнгээр хангалттай оноо авч эхний 10 байранд жагсаж байсан МХЕГ-ын цахим хуудас 2016 онд 69.6 хувьтай үнэлэгдэж зургадугаар байранд жагсаж байсан бол энэ жилийн үнэлгээний үр дүнгээр 67.5 хувьтай үнэлэгдэж 18-р байр луу ухарсан үзүүлэлттэй байна.

Вэб мониторингийн үр дүнг таван үзүүлэлтийн дагуу дөрвөн оноор харьцуулан гаргаж өөрчлөлтийг дараах дүрсэд харууллаа. Эдгээр таван үзүүлэлтийг үнэлэхдээ (Дүрс 1 шалгуур үзүүлэлт тус бүрийн үнэлгээний системд эзлэх хувь) буюу Хамааралтай байдал- 30 хувиас, найдвартай байдал-20 хувиас, цаг үеийн байдал-20 хувиас, хүртээмжтэй байдал-15 хувиас, хэрэглэхэд хялбар байдал-15 хувиас тус тус бодосныг дүрс 22-д харуулсан байгаа.

Дүрс 22. Тохируулагч агентлагуудын ил тод байдал (хувь)




Энэ жилийн үнэлгээний үр дүнгээс харахад мэдээллийн цаг үеийн байдалаас бусад дөрвөн үзүүлэлтүүд 2016 оны үзүүлэлтүүдээс дунджаар 10.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Харин мэдээллийн цаг үеийн байдлын хувьд өнгөрсөн оныхоос 0.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Нийт таван үзүүлэлтийн дундаж оноог харьцуулан харвал 2016 оны үзүүлэлтээс 2017 оны үнэлгээний үр дүн 10 орчим хувиар өссөн харагдаж байна.

Дүрс 23. Тохируулагч агентлагуудын цахим хуудсыг хэрэглэх байдал (хувь)



Тохируулагч агентлагуудын цахим хуудасны хүртээмжтэй байдал өмнөх онтой харьцуулахад 15.1 хувиар, хэрэглэхэд хялбар байдал нь 4.2 хувиар хувиар өссөн байна.

**Хүснэгт 11. ТОП 5 үзүүлэлттэй тохируулагч агентлагууд (хувь)**

| Агентлагуудын нэрс | Нийлбэр оноо | | |
|---|---|---|---|
| | 2015 | 2016 | 2017 |
| Цагдаагийн ерөнхий газар | 67.1 | 53.3 | 79.3 |
| Онцгой байдлын ерөнхий газар | 47.8 | 53.9 | 67.9 |
| Мэргэжлийн хяналтын ерөнхий газар | 50.6 | 69.6 | 67.5 |
| Хил хамгаалах ерөнхий газар | 47.1 | 43.9 | 66.7 |
| Стандартчилал хэмжил зүйн газар | 39.9 | 54.4 | 56.7 |

2017 оны үнэлгээний үр дүнгээс харахад цагдаагийн ерөнхий газар хамгийн өндөр үнэлгээг авсан байна. Өнгөрсөн жил цагдаагийн ерөнхий газар тавдугаарт эрэмбэлэгдэж байсан. МХЕГ-н хувьд өнгөрсөн жил хамгийн өндөр үнэлгээ авч нэгдүгээрт эрэмбэлэгдэж байсан бол энэ жил хоёр байр ухарч гуравдугаар байранд орсон байна. Дээрх хүснэгтээс харахад ОБЕГ, СХЗГ-уудын жил бүрийн үнэлгээний нийлбэр оноо өсч байна. Энэ нь эдгээр байгууллагууд цахим хуудасны ил тод байдалаа илүү сайжруулж байгаа нь ажиглагдаж байна.

### 2.4.1 Үйл ажиллагааны ил тод байдал

Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг авч үзэхдээ 1. Байгууллагын ерөнхий мэдээлэл. 2. Байгууллагын олон нийттэй харилцах мэдээлэл гэсэн хоёр хэсэгт ангилан авч үзсэн.

***Байгууллагын ерөнхий мэдээлэл.*** Тохируулагч агентлагуудын цахим хуудсанд хийсэн мониторингийн үр дүнгээс харахад нийт судалгаанд хамрагдсан агентлагуудын танилцуулга болох ерөнхий мэлээллээ цахим хуудастаа тавих байдал 2016 онд дунджаар 40 хувь байсан бол 2017 онд 66.6 хувь болж 26.6 хувиар дээшилсэн байна. Энэ жилийн үнэлгээний үр дүнгийн хувьд өмнөх жилүүдийнхтэй харьцуулахад хамгийн өндөр үнэлэгдсэн жил болж байна.

**Дүрс 24. Тохируулагч агентлагуудын ерөнхий мэдээлэл (хувь)**



Өнгөрсөн жил агентлагууд “*тэргүүлэх чиглэлээ*” огт байршуулаагүй байсан бол 2017 онд агентлагуудын тал хувь нь цахим хуудасдаа байршуулсан байна. Тохируулагч агентлагууд “*үйл ажиллагааны стратеги зорилго зорилтоо”* тавих байдал эргээд 20 хувиар өссөн байгаа бол “*эрхэм зорилгоо*” тавих байдал 10 хувиар өссөн үзүүлэлт гарсан байна.

## *Байгууллагын олон нийттэй харилцах мэдээлэл.*

Өнгөрсөн онуудын жишгээр байгууллагын олон нийттэй харилцах мэдээллийг дараах дүрсэд үзүүлсэн 11 үзүүлэлтээр хэмжсэн.

**Дүрс 25. Тохируулагч агентлагуудын олон нийттэй харилцах мэдээлэл (хувь)**



Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад *"Олон нийттэй харилцах мэргэжилтний овог нэр"* гэсэн шалгуур үзүүлэлт 2016 онд 20 хувь байсан бол 2016 онд 70 хувь болж өссөн дүнтэй гарсан байна. Тохируулагч агентлагуудын хувьд дийлэнх үзүүлэлтүүд нь өнгөрсөн оныхоос өссөн үзүүлэлттэй байна. Мөн байгууллагын олон нийттэй харилцах мэдээллийг дундаж үзүүлэлтээр нь харж үзвэл энэ жилийн үнэлгээний үр дүн өмнөх онуудынхаас найм орчим хувиар өссөн байна. Энэ нь байгууллагууд олон нийттэй харилцах мэдээллийг цахим хуудсандаа илүү их байршуулж байна. Ангилалын хувьд "зарим талаар ил тод" гэсэн ангилалаас "ил тод" гэсэн ангилалд шилжиж байна.

## 2.2.5 Хүний нөөцийн ил тод байдал

Тохируулагч агентлагуудын цахим хуудасны хүний нөөцийн ил тод байдлыг үнэлэхдээ шалгуур үзүүлэлтүүдийг гурав багцлан боловсруулалт хийсэн. Үүнд *"цаг хугацааны хувьд тохирсон, тодорхой байдал"*, *"Тус мэдээллийн эх сурвалж тодорхой байдал"*, *"Хүний нөөцийн ил тод байдлын талаарх мэдээлэл байгаа эсэх"* гэсэн гурван багц шалгуур үзүүлэлтүүдэд хувааж үр дүнг харуулсан байгаа. Доорх хүснэгтэнд байгаа үр дүнгүүдийг боловсруулахдаа хүний нөөцийн ил тод байдлын талаарх мэдээлэл байгаа эсэхийг-42.8 хувиас, тус мэдээллийн эх сурвалж тодорхой байдлийг-28.6 хувиас, цаг хугацааны хувьд тохирсон, тодорхой байдлыг-28.6 хувиас тус тус бодож үр дүнг боловсруулсан байгаа.

**Дүрс 26. Тохируулагч агентлагуудын хүний нөөцийн ил тод байдал (хувь)**




Хүний нөөцийн талаарх мэдээлиийн эх сурвалж тодорхой байдал 2016 оноос 5.7 хувиар, цаг хугацааны хувьд тохиромжтой байдал нь өмнөх онтой харьцуулахад 1.4 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Тохируулагч агентлагуудын хувьд хүний нөөцийн талаарх мэдээллээ байршуулах байдал 14.8 хувиар өссөн нь хүний нөөцийн ил тод байдлын ерөнхий үзүүлэлт бусад онуудаас өндөр гарсны гол шалтгаан болж байна.

**Дүрс 27. Тохируулагч агентлагуудын хүний нөөцийн ил тод байдлын үзүүлэлт (хувь)**




2015 онд “*Албан хаагчийн ёс зүйн дүрмийг*” байршуулах байдал эрс нэмэгдэж 90 хувь болтлоо өссөн бол 2017 оны үр дүнгээр 20 хувиар буурсан нь харагдаж байна. *Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээлэл* байршуулсан байдал нь 2015 онд 70 хувьтай байсан бол 2016 онд тэг, 2017 онд 40 хувь болж буурсан байна. Эндээс харахад тохируулагч агентлагууд цахим хуудсандаа хүний нөөций талаарх мэдээллээ оруулах байдал нь тогтворжоогүй байгаа нь ажиглагдаж байна. Харин эсрэгээрээ “*Хүний нөөцийн стратеги. түүний хэрэгжилтийг хянаж. үнэлэх журам*”, “*Сул орон тооны зар*” гэх хүний нөөцтэй холбоотой мэдээллийг цахим хуудсандаа байршуулсан байдал нь жил жилийн үзүүлэлт нь өссөн үр дүнг харуулж байна.

## 2.4.2 Төсөв санхүүгийн ил тод байдал

Тохируулагч агентлагуудын цахим хуудасны төсөв санхүүгийн ил тод байдал нь өмнөх онтой харьцуулахад дунджаар 15.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Мөн хүний нөөцийн ил тод байдалын хэсэгт дурьдсанчилан шалгуур үзүүлэлтүүдийг гурван багц болгож боловсруулсан. *“цаг хугацааны хувьд тохирсон, тодорхой байдал”*, *“Тус мэдээллийн эх сурвалж тодорхой байдал”*, *“Төсөв, санхүүгийн талаарх мэдээлэл байгаа эсэх ”* гэсэн гурван багц шалгуур үзүүлэлтүүдэд хувааж үр дүнг харуулсан. Доорх хүснэгтэнд байгаа үр дүнгүүдийг боловсруулахдаа *“Төсөв, санхүүгийн талаарх мэдээлэл байгаа эсэхийг”*-42.8 хувиас, *“тус мэдээллийн эх сурвалж тодорхой байдлийг”*-28.6 хувиас, “*цаг хугацааны хувьд тохирсон, тодорхой байдлыг”*-28.6 хувиас тус тус бодож үр дүнг боловсруулсан. Дараах дүрсээс дэлгэрэнгүй харна уу.

**Дүрс 28. Тохируулагч агентлагуудын төсөв санхүүгийн ил тод байдал (хувь)**




Төсөв санхүүгийн талаарх мэдээлэл оруулсан байдал нь 5.5 хувиар, эх сурвалжийн тодорхой байдал 2.1 хувиар, цаг хугацааны хувьд тохирсон, тодорхой байдал 7.9 хувиар тус тус өссөн байна.

**Хүснэгт 12. Төсөв санхүүгийн ил тод байдал ТОП 3 тохируулагч агентлаг (хувь)**

| Тохируулагч агентлаг | Мэдээлэл байгаа эсэх | Эх сурвалж тодорхой эсэх | Цаг хугацаа нь байгаа эсэх | Нийт хувь |
|---|---|---|---|---|
| Мэргэжлийн хяналтын ерөнхий газар | 38.9 | 26 | 28.9 | 93.5 |
| Цагдаагийн ерөнхий газар | 38.9 | 23.4 | 25.4 | 87.7 |
| Онцгой байдлын ерөнхий газар | 31.1 | 18.2 | 25.4 | 74.7 |

Төсөв санхүүгийн ил тод байдлыг шалгуур үзүүлэлтүүдийн үр дүнгээр топ гурван тохируулагч агентлагуудыг эрэмбэлэж харуулсан байна. 2016 оны судалгааны үр дүнгээр МХЕГ-ын цахим хуудас төсөв санхүүгийн ил тод байдлаар 85.3 хувиар 1-т эрэмбэлэгдэж байсан бол 2017 оны үнэлгээний үр дүнгээр 93.5 хувиар 1-т эрэмбэлэгдсэн байна. ЦЕГ 87.7 хувиар хоёрдугаар байрт эрэмбэлэгдсэн. ОБЕГ-ын хувьд 2016 оны үнэлгээгээр 55.8 хувиар гуравдугаар байрт жагсаж байсан бол энэ жилийн хувьд мөн адил 74.7 хувиар гуравдугаар байрт жагссан байна.

**Дүрс 29. Тохируулагч агентлагуудын санхүүгийн ил тод байдлын үзүүлэлтүүд (хувь)**




Төсвийн ил тод байдлыг үнэлсэн дараах үзүүлэлтүүдээс "*байгууллагын тухайн жилийн төсөв*", "*төсөвт оруулсан нэмэлт өөрчлөлт*", "*хууль тогтоомжинд заасан төлбөр хураамжийн хэмжээ*", "*төсвийн хэмнэлт хэтрэлт түүний шалтгааны тайлбар*", "*аудтин тайлан дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээлэл*", "*шилэн дансны тусгай цэс байгаа эсэх*" эдгээр шалгуур үзүүлэлтүүд дунджаар 33.3 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Үлдсэн шалгуур үзүүлэлтүүд болох "*Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт*", "*Урьд оны төсвийн гүйцэтгэл*", "*хагас бүтэн жилийн санхүүгийн тайлан*", "*төсвийн гүйцэтгэлийн биелэлт*" гэх шалгуур үзүүлэлтүүд дунджаар 20 орчим хувиар 2016 оны үр дүнгээс буурсан үзүүлэлттэй байна.

## 2.4.3 Худалдан авах ажиллагааны ил тод байдал.

Тохируулагч агентлагуудын хувьд ХАА-ны тухай мэдээллээ цахим хуудасдаа ил тод байршуулах байдал өмнөх судалгааны үр дүнгээс нэг дахин нэмэгдсэн байна.

Худалдан авах ажиллагааны ил тод байдлын шалгуур үзүүлэлтүүдийг гурван багц болгож боловсруулсан. *"цаг хугацааны хувьд тохирсон, тодорхой байдал"*, *"Тус мэдээллийн эх сурвалж тодорхой байдал"*, *"худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл байгаа эсэх "* гэсэн гурван багц шалгуур үзүүлэлтүүдэд хувааж үр дүнг харуулав. Доорх хүснэгтэнд байгаа үр дүнгүүдийг боловсруулахдаа *"худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл байгаа эсэхийг"*-42.8 хувиас, *"тус мэдээллийн эх сурвалж тодорхой байдлийг"*-28.6 хувиас, *"цаг*

*хугацааны хувьд тохирсон, тодорхой байдлыг"*-28.6 хувиас тус тус бодож үр дүнг боловсруулсан. ХАА-ны ил тод байдлын үзүүлэлт тус бүр өссөн бөгөөд дунджаар 12.3 хувиар нэмэгдсэн байна.

**Дүрс 30. Тохируулагч агентлагуудын ХАА-ны ил тод байдал (хувь)**




Дээрх дүрсээс харахад ХАА-ны талаарх мэдээлэл тавигдсан байдал өмнөх оны үр дүнгээс 4.8 хувиар, мэдээллийн эх сурвалж тодорхой байдал 3.5 хувиар, мэдээллийн цаг үеийн байдал дөрвөн хувиар өссөн үзүүлэлттэй байна.

**Хүснэгт 13. ХАА-ны ил тод байдал ТОП 3 тохируулагч агентлаг (хувь)**

| Агентлаг | Мэдээлэл байгаа эсэх | Эх сурвалж тодорхой эсэх | Цаг хугацаа нь байгаа эсэх | Нийт хувь |
|---|---|---|---|---|
| Цагдаагийн ерөнхий газар | 33.3 | 22.2 | 19.7 | 75.2 |
| Хил хамгаалах ерөнхий газар | 28.5 | 19.1 | 19.7 | 67.3 |
| Онцгой байдлын ерөнхий газар | 23.8 | 15.9 | 19.7 | 59.3 |

Нийт судалгаанд хамрагдсан тохируулагч агентлагуудаас 2016 онд ЦЕГ 38.9 хувиар гуравдугаар байрт эрэмбэлэгдэж байсан бол 2017 оны үнэлгээгээр 75.2 хувиар нэгдүгээр байрт эрэмбэлэгдсэн байна. ХХЕГ 67.3 хувиар хоёрдугаар байрт эрэмбэлэгдсэн. 2016 оны үнэлгээний үр дүнгээр 46.1 хувиар нэгдүгээр байрт эрэмбэлэгдэж байсан бол энэ жилийн хувьд 59.3 хувиар гуравдугаар байрт эрэмбэгдсэн нь харагдаж байна. Хэдийгээр ОБЕГ-ын хувьд үнэлгээний үр дүн 13.2 хувиар дээшилж эерэг үзүүлэлт гаргаж топ гурван байгууллагад багтаж чадсан нь сайшаалтай.

Тохируулагч агентлагуудын ХАА-ны үзүүлэлтийг өмнөх онуудтай харьцуулахад өссөн шатлалтай байна. Энэ оны хувьд өнгөрсөн жилийн үр дүнгээс 16.6 хувир өссөн үзүүлэлт гарсан.

**Дүрс 30. Тохируулагч агентлагуудын ХАА-ны үзүүлэлт (хувь)**




Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тайлан /5 сая.төг-с дээш/ 2016 онд 40 хувь байсан нь 60 хувь болж өссөн үр дүнг харж болохоор байна. *2015 онд мониторингийн арга зүйд нэмж руудсан үзүүлэлтүүдээс Цалингийн зардлаас бусад 5 сая.төг-с дээш үнийн дүн бүхий орлого. зарлагын мөнгөн гүйлгээ тус бүрээр. гүйлгээний агуулга хамгийн өндөр буюу 90 хувь болтлоо үнээдэгдсэн* бол *Тендерийн баримт бичиг. Тендер шалгаруулалт явуулах журам* болон *Мөнгө зарцуулах өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр/бонд. зээл. өрийн бичиг гэх мэт/* мэдээлэл огт тавигдаагүй байна. Харин *Тендерт оролцохыг сонирхогчид тавигдах шалгуур үзүүлэлт*ийн талаар мэдээлэл агентлагуудын 10 хувьд нь буюу 1 агентлагийн цахим хуудсанд тавигдсан байна.

## 2.4 АЙМГУУДЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ҮЗҮҮЛЭЛТ

Энэ хэсэгт 21 аймгийн албан ёсны цахим хуудаст хийсэн мониторингийн нэгдсэн үр дүнг харуулна.

**Зураг 3. 2015 судалгааны аймгуудын ил тод байдлын үзүүлэлт[2]**







Аймгуудыг цахим хуудасыг ил тод байдлаар нь эрэмбэлж оноожуулсан болно. 0-40 оноог улаанаар, 41-60 оноог шараар, 61-80 оноог ногооноор 81-ээс дээш оноог цэнхэрээр тэмдэглэв.

Аймгуудын хувьд цахим хуудасны ил тод байдлаараа Хөвсгөл аймаг нийт 99 оноо авахаас 90 оноо авснаар 93.8 хувьтай үнэлэгдэн нийт аймгууд болон 81 төрийн байгууллагаас нэгдүгээрт эрэмбэлэгдсэн байна. Ховд аймаг 99 оноо авахаас 36 оноо авснаар 32.3 хувьтайгаар үнэлгээнд хамрагдсан 81 байгууллагаас 72-д эрэмбэлэгдсэн. Ийнхүү цахим хуудасны ил тод байдлаараа 21 аймгаас хамгийн муу үр дүн үзүүлсэн байна.

Засгийн газрын бүтцэд өөрчлөлт орсноор яам, агентлагуудын нэр, эрх үүрэг, хамаарах асуудлын хүрээ зэрэг өөрчлөгдсөнөөс цахим хуудсаа шинээр хийх шаардлага гардаг бол аймгуудын цахим хуудасны хувьд тогтмол сайжруулаад явах бүрэн боломжтой байдгаараа онцлог юм.

**Хүснэгт 14. Аймгуудын цахим хуудасны ерөнхий үзүүлэлт (хувь)**

| № | Нэрс | Нийлбэр оноо | | | | Эрэмбэ /Ранк/ | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2011 | 2015 | 2016 | 2017 | 2011 | 2015 | 2016 | 2017 |
| 1 | Архангай | 19.9 | 53.7 | 51.5 | 46.4 | 69 | 39 | 39 | 56 |
| 2 | Баянхонгор | - | 56.2 | 83.8 | 76 | - | 28 | 1 | 13 |
| 3 | Баян-Өлгий | 23.6 | 61.2 | 57.7 | 59.8 | 59 | 15 | 18 | 31 |
| 4 | Булган | 26.3 | 51.3 | 20 | 74.6 | 49 | 46 | 75 | 14 |
| 5 | Говь-Алтай | 22.2 | 60.3 | 32.3 | 65.3 | 63 | 17 | 68 | 23 |
| 6 | Говьсүмбэр | 37.4 | 56.6 | 58.5 | 76.9 | 14 | 25 | 20 | 11 |
| 7 | Дархан-Уул | 17.7 | 33.8 | 57.7 | 68.1 | 76 | 81 | 22 | 16 |
| 8 | Дорноговь | 21.6 | 43.9 | 17.7 | 91.9 | 65 | 72 | 77 | 4 |
| 9 | Дорнод | - | 64.5 | 70.7 | 92.4 | - | 12 | 6 | 3 |
| 10 | Дундговь | 15.6 | 52.9 | 43.8 | 62.5 | 80 | 40 | 53 | 25 |
| 11 | Завхан | 30.7 | 57.6 | 53 | 93.2 | 35 | 22 | 37 | 2 |
| 12 | Орхон | - | 65.3 | 75.4 | 91.4 | - | 10 | 2 | 5 |
| 13 | Өвөрхангай | 29.1 | 60.4 | 38.5 | 76.2 | 42 | 16 | 59 | 12 |
| 14 | Өмнөговь | 31.2 | 45.8 | 36.9 | 73.6 | 34 | 66 | 61 | 15 |
| 15 | Сүхбаатар | 28.6 | - | 69.2 | 87.5 | 44 | - | 8 | 7 |
| 16 | Сэлэнгэ | 26.4 | 54.9 | 47.7 | 64.1 | 48 | 33 | 45 | 24 |
| 17 | Төв | 28.6 | 50.5 | 46.1 | 59.2 | 44 | 48 | 47 | 32 |
| 18 | Увс | 32.8 | 55.2 | 35.4 | 54.5 | 26 | 31 | 64 | 43 |
| 19 | Ховд | 10.7 | 45.3 | 44.6 | 32.3 | 84 | 69 | 49 | 72 |
| 20 | Хөвсгөл | 29.2 | 57.5 | 40.7 | 93.8 | 41 | 23 | 57 | 1 |
| 21 | Хэнтий | - | 52.1 | 59.2 | 85.8 | - | 43 | 19 | 8 |
| **Аймгийн дундаж** | | **25.1** | **54** | **49.6** | **72.6** | | | | |
| **Ерөнхий дундаж** | | **28.7** | **52.2** | **46.1** | **55.5** | | | | |

2016 онд аймгуудын дундаж 49,6 хувьтай байсан нь “зарим талаар ил тод” гэсэн ангилалд багтаж байсан бол 2017 онд дээрхи хувь 72,6 хувь болж “ил тод” гэсэн ангилалд орж дээшилсэн харагдаж байна. Энэ нь иргэд өөрийн аймгийн цахим хуудаснаас өөрт хэрэгтэй мэдээллээ олж авах, ашиглах боломж нэмэгдсээр байгааг илэрхийлж байгаа юм.

**Хүснэгт 15. ТОП 5 үзүүлэлттэй аймаг (хувь)**

| Аймгуудын нэрс | Нийлбэр хувь | | | |
|---|---|---|---|---|
| | 2011 | 2015 | 2016 | 2017 |
| Хөвсгөл | 29.2 | 57.5 | 40.7 | 93.8 |
| Завхан | 30.7 | 57.6 | 53 | 93.2 |
| Дорнод | - | 64.5 | 70.7 | 92.4 |
| Дорноговь | 21.6 | 43.9 | 17.7 | 91.9 |
| Орхон | - | 65.3 | 75.4 | 91.4 |

Нийт 21 аймгийн цахим хуудаст үнэлгээ хийснээс долоон аймгийн цахим хуудас 81 хувиас дээш үзүүлэлттэйгээр *“бүрэн ил тод*” ангилалд орсон. Есөн аймгийн цахим хуудас 61 хувиас дээш үзүүлэлттэйгээр *“ил тод”* ангилалд багтсан. Дөрвөн аймгийн цахим хуудас 41 хувиас дээш үзүүлэлттэйгээр *“зарим талаар ил тод”* гэсэн ангилалд оржээ. Ховд аймгийн цахим

хуудас 40-өөс доош хувьтай байснаар “хаалттай” ангилалд багтсан байна. Дүгнэж үзвэл монгол улсын 21 аймгын цахим хуудасны 90 хувь нь ил тод байна гэж хэлж болно.

2017 оны энэхүү мониторингод нийт 81 байгууллагын цахим хуудаст үнэлгээ хийхэд хамгийн нэгдүгээрт эрэмбэлэгдсэн цахим хуудсаар Хөвсгөл аймгийн цахим хуудас тодорсон нь аймгуудын цахим хуудас бусад төрийн байгууллагын цахим хуудастай харьцуулахад илүү ил тод болж байгаагийн илрэл юм.

Вэб мониторингийн үр дүнг таван үзүүлэлтээр нь задлаад харьцуулан гарсан өөрчлөлтийг дараах графикт харууллаа.

Дүрс 31. Аймгуудын цахим хуудасны ил тод байдал (хувь)




2017 онд аймгуудын цахим хуудасны ил тод байдлыг илтгэх таван үзүүлэлтийн нийлбэр хувь 72.6 хувь байгаа нь 2016 оноос 23 хувиар өссөн байна. Дээрх таван үзүүлэлт бүгд 2016 оны судалгааны үр дүнгээс өссөн байна. Үүнээс мэдээллийн хүртээмжтэй байдлын үзүүлэлт хамгийн их өссөн байгаа юм.

Дараагийн хамгийн их өссөн үзүүлэлт бол мэдээллийн цаг үеийн байдал байна. Хэрвээ тухайн мэдээлэллийн цаг үеийн байдал шаардлага хангахгүй бол тухайн цахим хуудсанд шаардлагатай мэдээлэл байгаа хэдий ч ашиглах боломжгүй байгааг илэрхийлнэ. Жишээлбэл: Сул орон тооны зар байгаа боловч өнгөрсөн жилийн зар байвал уг мэдээлэл ач холбогдолгүй болох юм. Зарим төрлийн мэдээллийн гол ач холбогдол нь тухайн мэдээлэл хүрч буй цаг хугацаанд оршиж байдаг юм. Тиймээс аймгууд цахим хуудсандаа тавьж буй мэдээллийнхээ хугацаанд анхаарч, оруулсан мэдээллээ тогтмол шинэчилж байх шаардлага үүсэж байна.

## Аймгуудын цахим хуудсыг хэрэглэх байдал

Цахим хуудсыг хэрэглэх байдлыг тооцохдоо цахим хуудсын хүртээмжтэй байдал болон хэрэглэхэд хялбар байдлын үзүүлэлтүүдээр тус тус тооцсон болно.

Дүрс 32. Аймгуудын цахим хуудсыг хэрэглэх байдал (хувь)




**Х**үртээмжтэй байдал гэдэг нь цахим хуудаснаас иргэд шууд хандан зөвлөгөө, мэдээлэл авах боломжтой байгаа эсэхийг хэмжих үзүүлэлт юм. Жишээлбэл: Тухайн цахим хуудасд асуулт тавиад  хариулт авах боломжтой эсэх, шаардлагатай мэдээлэл авах албан тушаалтны холбоо барих мэдээлэл байгаа эсэх зэрэг багтана.

Хэрэглэхэд хялбар байдал гэдэг нь цахим хуудсыг ямар ч түвшний иргэн хэрэглэх боломжтой энгийн, ойлгомжтой байхыг хэлж байгаа юм. Хайлтын цэстэй байх, үсгийн фонт нь ямарч насны хүнд харагдхуйц байх зэрэг багтана.

## 2.4.1 Үйл ажиллагааны ил тод байдал

Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг авч үзэхдээ байгууллагын талаарх

1. Байгууллагын ерөнхий мэдээлэл
2. Байгууллагын олон нийттэй харилцах мэдээлэл гэсэн хоёр хэсэгт ангилан авч үзсэн.

***Байгууллагын ерөнхий мэдээлэл.***

Байгууллагын ерөнхий мэдээллийг цахим хуудсандаа байршуулсан эсэхийг үндсэн гурван асуултаар шалгаж үзэхэд 55,5 хувьтай байгаа нь 2016 оны үзүүлэлттэй харьцуулахад 21,9 хувиар буурсан байна.

Дүрс 33. Аймгуудын ерөнхий мэдээлэл (хувь)




Аймгуудын цахим хуудасны 23 хувьд нь тухайн аймгийн тэргүүлэх чиглэл, 61 хувьд нь тухайн аймгийн үйл ажиллагааны стратеги зорилго зорилт, 80 хувьд нь тухайн аймгийн эрхэм зорилго байсан байна гэж ойлгож болно.

***Байгууллагын олон нийттэй харилцах мэдээлэл.***

Цахим хуудсан дахь олон нийттэй харилцах чиглэлийн мэдээлэл ил тод эсэхийг тодорхойлохдоо 11 үзүүлэлтийг шалгуур болгон авсан. Тэдгээр үзүүлэлтийн үр дүнгүүдээ 2011, 2014, 2015, 2016 оны үр дүнтэй харьцуулан дараах дүрсээр илэрхийллээ.

Дүрс 34. Аймгуудын цахим хуудасны олон нийттэй харилцах мэдээлэл (хувь)




Аймгуудын цахим хуудсанд олон нийттэй харилцах мэдээлэл байршуулсан хувийг дундажлаж харвал 2017 онд 55.8 хувь байгаа нь өмнөх оны дунджаас 7,6 хувиар өссөн байна. 2017 оны үзүүлэлтүүдийг 2016 онтой харьцуулбал 11 үзүүлэлтийн дөрвөн үзүүлэлт дээр өсөлттэй, долоо үзүүлэлт дээр бууралттай байна.

**Өссөн 4 үзүүлэлт:**

- Цахим шуудангийн хаяг
- Факсын дугаар
- Цахим шуудангаас шууд холбогдох боломж
- Төрийн үйлчилгээ авахтай холбоотой мэдээллийн жагсаалт

**Буурсан 7 үзүүлэлт:**

- Байгууллагын холбоо барих утас
- Байгууллагын хаяг
- Иргэд хүлээн авч уулзах цагийн хуваарь
- Шуудангийн хаяг
- Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж буй хууль тогтоомж
- Олон нийттэй харилцах мэргэжилтний овог нэр
- Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж буй дүрэм, журам, заавар

### 2.4.2 Хүний нөөцийн ил тод байдал

Аймгуудын цахим хуудасны хүний нөөцийн мэдээлэлд гол төлөв төрийн жинхэнэ албаны мэргэшлийн болон нөөцийн судалгаа тавигдсан байсан. Тиймээс энэ үзүүлэлтийг тус судалгаа болон сул орон тоог нөхөх зар тавигдсан эсэх байдлаар үнэлсэн.

**Дүрс 35. Аймгуудын хүний нөөцийн ил тод байдал (хувь)**




2017 онд аймгуудын цахим хуудасны хүний нөөцийн ил тод байдал 72,3 хувь байгаа нь өмнөх жилийн үр дүнгээс 11,1 хувиар өссөн байна.Нийт гурван үзүүлэлт байгаагаас хоёр үзүүлэлт дээр нь өмнөх оноос өссөн байна.Тухайн цахим хуудсанд хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод байдлын хувиар бусад аймгаа тэргүүлсэн таван аймгийг эрэмбэлж доорх хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 16 Хүний нөөцийн ил тод байдал ТОП 5 аймаг (хувь)

| Аймгийн нэрс | Мэдээлэл байгаа эсэх | | | | Эх сурвалж тодорхой эсэх | | | | Цаг хугацаа нь байгаа эсэх | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2015 | 2016 | 2017 | 2011 | 2015 | 2016 | 2017 | 2011 | 2015 | 2016 | 2017 |
| Дорноговь | - | 25.7 | 42.8 | 42.8 | - | 28.6 | 28.6 | 28.6 | - | 28.6 | 28.6 | 28.6 |
| Орхон | - | 25.7 | 42.8 | 42.8 | - | 28.6 | 28.6 | 28.6 | - | 28.6 | 28.6 | 28.6 |
| Сүхбаатар | - | 34.2 | 34.2 | 42.8 | - | 28.6 | 28.6 | 28.6 | - | 28.6 | 28.6 | 28.6 |
| Завхан | - | - | - | 42.8 | - | - | - | 28.6 | - | - | - | 28.6 |
| Сэлэнгэ | - | - | - | 42.8 | - | - | - | 28.6 | - | - | - | 28.6 |

Хүний нөөцийн мэдээллийн ил тод байдлын үнэлгээгээр 2017 онд Дорноговь, Орхон, Сүхбаатар, Завхан, Сэлэнгэ гэсэн аймгууд бусад аймгуудаас өндөр үнэлгээ авсан байна.

Дүрс 36. Аймгуудын хүний нөөцийн ил тод байдлын үзүүлэлт (хувь)




2017 оны үнэлгээний хувьд албан хаагчийн ёс зүйн дүрэм, албан хаагчдын ажлын гүйцэтгэл үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх мэдээлэл аймгуудын цахим хуудасд энэ онд өмнөх жилийхээс бага байрласан нь дээрхи дүрсээс харагдаж байна.

**Зураг 4. Дорноговь аймгийн цахим хуудас дахь хүний нөөцийн мэдээлэл**




Дээрх зурагт цахим хуудсанд хүний нөөцийн мэдээллийн ил тод байдлаараа тэргүүлсэн таван аймгийн төлөөлөл болгож Дорноговь аймгийн цахим хуудасны хүний нөөцийн мэдээллийн булангын зургийг харуулж байна.

Бусад аймгуудын хувьд холбогдолтой буюу хүний нөөцийн талаархи шаардлагатай мэдээллийг оруулсан эсэх, найдвартай буюу тухайн оруулсан мэдээллийнхээ эх сурвалжийг тавьсан эсэх , цаг хугацааны буюу тухайн цахим хуудасны хэрэглэгч уг мэдээллийг ашиглах боломжтой эсэх  зэрэг үзүүлэлтүүд дээр ямар нэгэн байдлаар дутуу мэдээлсэн байсан нь доогуур үнэлэгдэхэд нөлөөлсөн болно .

Ийнхүү 2017 оны цахим хуудасны ил тод байдлын үнэлгээгээр 21 аймгуудын цахим хуудсан дахь хүний нөөцтэй холбоотой мэдээллийн ил тод байдал дунджаар 72,3 хувьтай байгаа нь "ил тод" гэсэн ангилалд багтаж байгаа юм.

## 2.4.3 Төсөв санхүүгийн ил тод байдал

Аймгуудын цахим хуудасны төсөв санхүүгийн ил тод байдлыг дараах дүрсэд харуулья.

Дүрс 37. Аймгуудын төсөв санхүүгийн ил тод байдал (хувь)




2017 оны аймгуудын цахим хуудасны төсөв, санхүүгийн ил тод байдлын үр дүнг харуулсан дээрх дүрсээс харахад бүх үзүүлэлт дээр өмнөх оноос өсөлттэй байгаа нь харагдаж байна. Төсөв санхүүгийн талаарх мэдээлэл байгаа эсэх гэсэн үзүүлэлт дээр хамгийн их өссөн байгаа нь аймгуудын цахим хуудаст тухайн орон нутгийн төсөв санхүүтэй холбоотой мэдээлэл илүү ил тод болж буйг илтгэж байна.

Хүснэгт 17. Төсөв санхүүгийн ил тод байдлын үнэлгээ ТОП 3 аймаг (хувь)

| Аймгийн нэрс | Мэдээ-лэл байгаа эсэх | | | Эх сурвалж тодор-хой эсэх | | | Цаг хугацаа нь байгаа эсэх | | | Нийт хувь | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2015 | 2016 | 2017 | 2015 | 2016 | 2017 | 2015 | 2016 | 2017 | 2015 | 2016 | 2017 |
| **Дорнод** | 28.1 | 42.8 | 42.8 | 19.06 | 7.8 | 28.6 | 13.7 | 28.6 | 28.6 | 61.3 | 79.2 | 100 |
| **Хөвсгөл** | 32,1 | 42.8 | 42.8 | 21.4 | 28.6 | 28.6 | 18.7 | 20.4 | 28.6 | 72.2 | 91.8 | 100 |
| **Дорноговь** | - | 35.02 | 42.8 | - | 23.4 | 28.6 | - | 22.5 | 28.6 | - | 80.9 | 100 |

2017 оны төсөв санхүүгийн ил тод байдлын үнэлгээгээр өндөр үзүүлэлттэй гарсан гурван аймгийг жагсааж дээрх хүснэгтээр илэрхийллээ.

Дүрс 38. Аймгуудын төсөв санхүүгийн ил тод байдлын үзүүлэлтүүд (хувь)




Аймгуудын цахим хуудсан дахь төсөв санхүүгийн ил тод байдлыг үнэлэхэд 2017 онд дээрх 12 үзүүлэлтийг ашигласан юм. 2016 оны үр дүнтэй харьцуулахад 2017 оны дүнгээр өссөн болон буурсан үзүүлэлтүүдийг жагсааж үзүүллээ.

**Өссөн 8 үзүүлэлт:**

- Санхүүгийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлт
- Байгууллагын тухайн жилийн төсөв
- Хагас бүтэн жилийн тайлан
- Төсвийн гүйцэтгэлийн биелэлт
- Урьд оны төсвийн гүйцэтгэл
- Хуульд тогтоомжид заасан төлбөр хураамжид орсон нэмэлт өөрчлөлт
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө
- Аудитын тайлан дүгнэлтэнд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ зэрэг нийт 7 төрлийн мэдээллийг 2017 оны байдлаар 21 аймгийн цахим хуудсанд хангалттай түвшинд мэдээллэсэн байгаа нь харагдаж байна.

**Буурсан 3 үзүүлэлт:**

- Төсөвт оруулсан нэмэлт өөрчлөлт
- Төсвийн хэмнэлт хэтрэлт түүний шалтгааны тайлбар
- Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт

**Тэнцсэн 1 үзүүлэлт:**

Шилэн дансны цэс байгаа эсэх гэсэн үзүүлэлтийн хувь 2016 онтой яг ижил байсан юм.

Аудитыг тайлан дүгнэлтэнд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ гэсэн үзүүлэлт дээр өмнөх оноос 57,1 хувиар өссөн нь энэ онд аймгуудын цахим хуудасны ил тод байдлыг үнэлсэн бүх үзүүлэлтээс хамгийн их хувийн өсөлттэй үзүүлэлт болж байна.

Ийнхүү 2017 оны хувьд 21 аймгын цахим хуудас дахь төсөв санхүүгийн ил тод байдлын дунджаар 81,6 хувьтай байгаа нь “бүрэн ил тод” гэсэн ангиллын шалгуурыг давж энэ ангилалд багтаж байгаа юм.

## 2.4.4 Худалдан авах ажиллагааны ил тод байдал

Аймгуудын ХАА-ны тухай мэдээлэл тухайн аймгийнхаа албан ёсны цахим хуудаст цаг тухай бүрт нь байршиж байх нь ихээхэн чухал. Хэдийгээр төрийн байгууллагын ХАА-ны талаарх мэдээллийг түгээдэг тусдаа цахим хуудас байгаа хэдий ч иргэд өөрийн аймгийн цахим хуудасруу ороод нэг дороос өөрт хэрэгтэй мэдээллээ авах боломжтой байх нь чухал мөн ихэнхи иргэд худалдан авах ажиллагааны мэдээллийг өөр цэснээс харах боломжтой талааар мэдээлэлгүй байдаг зэрэгтэй холбоотойгоор бид өмнөх арга зүйгээ баримтлан тухайн байгууллагын цахим хуудсанд мэдээлэх ёстой гэж үзсэн юм.

Дүрс 39. Аймгуудын цахим хуудасны ХАА-ны ил тод байдал (хувь)



Хамгийн их өсөлттэй байгаа нь ХАА-ны талаарх мэдээлэл байгаа эсэх гэсэн үзүүлэлт байна.

ХАА-ны ил тод байдлаар тэргүүлсэн аймгуудыг доорх хүснэгтэд харууллаа

**Хүснэгт 18. ХАА-ны ил тод байдал ТОП 3 аймаг (хувь)**

| Аймгийн нэрс | Мэдээлэл байгаа эсэх | | Эх сурвалж тодорхой эсэх | | Цаг хугацаа нь байгаа эсэх | | Нийт хувь | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2016 | 2017 | 2016 | 2017 | 2016 | 2017 | 2016 | 2017 |
| **Хэнтий** | 38 | 42.8 | 26 | 28.6 | 22 | 28.6 | 86 | 100 |
| **Хөвсгөл** | 38 | 42.8 | 26 | 25.4 | 22 | 28.6 | 86 | 96.8 |
| **Сүхбаатар** | 34 | 42.8 | 23 | 25.4 | 22 | 25.0 | 79 | 93.2 |

ХАА-тай холбоотой мэдээ мэдээлэл дээрхи аймгуудын цахим хуудасд илүү ил тод байсан гэж дүгнэж болно. Учир нь ХАА-ны талаар мэдээлэгдсэн байдал, ХАА-ны талаарх мэдээллийн эх сурвалж, ХАА-ны талаар оруулсан мэдээлэл цаг хугацааны хувьд тохиромжтой эсэх гэсэн үзүүлэлтүүд дээр бусад аймгуудтай харьцуулахад илүү өндөр хувь үзүүлсэн байсан.

**Дүрс 40. Аймгуудын ХАА-ны ил тод байдал (хувь)**



2017 оны үр дүнгээ өмнөх оны аймгуудын цахим хуудас дахь худалдан авах ажиллагааны ил тод байдлын үзүүлэлтүүдтэй харьцуулж өссөн болон буурсан үзүүлэлтүүдийг жагсаан харцгаая.

**Өссөн 6 үзүүлэлт:**

- Тендерийн урилга
- Худалдан авсан бараа үйлчилгээний тайлан
- Тендерт оролцхыг сонирхогчдод тавигдах шалгуур
- Мөнгө зарцуулах,өр,авлага үүсгэсэн аливаа шийдвэр
- Цалингын зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ
- Тендерийн баримт бичиг

**Буурсан 2 үзүүлэлт:**

- Тендерийн шалгаруулалтын талаар мэдээлэл шалгарсан шалгараагүй үндэслэл
- Тендер шалгаруулалт явуулах журам

**Тэнцсэн 1 үзүүлэлт:**

- Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын дүгнэлт бусад хяналт шалгалтын дүн

Ийнхүү 21 аймгийн цахим хуудас дахь худалдан авах ажиллагааны ил тод байдал 68,4 хувьтай байгаа нь “ил тод” ангилалд багтаж байгаа юм.

## 2.5 УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРГАА, ДҮҮРГҮҮДИЙН цахим хуудасны ҮЗҮҮЛЭЛТ

Энэ хэсэгт НЗДТГ-ын цахим хуудас, УБ хотын захирагчийн ажлын албаны цахим хуудас болон есөн дүүргийн ЗДТГ-ын цахим хуудсыг хамруулсан болно.

Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн цахим хуудсыг таван үзүүлэлт тус бүрээр болон нийлбэр оноогоор 2016 оны судалгааны үр дүнтэй харьцуулан харуулав.

**Зураг 5. Дүүргүүдийн ил тод байдлын үзүүлэлт[3]**




Улаанбаатар хотын захиргаа дүүргүүдийн цахим хуудасны ил тод байдлыг эрэмбэлж оноожуулсан болно. 0-40 оноо улаан өнгөөр, 41-60 оноог шар өнгөөр, 61-80 оноог ногоон өнгөөр тэмдэглэсэн байна.

Улаанбаатар хотын захиргаа дүүргүүдийн цахим хуудасны үзүүлэлт гэсэн энэхүү хэсэгт нийт 11 цахим хуудаст үнэлгээ хийсэн болно. Энэхүү мониторингийн арга зүйн дагуу 11 цахим хуудсыг ил тод байдлын дөрвөн түвшинд ангилж үзсэн байгаа.

“Бүрэн ил тод” ангилалд:

- Сүхбаатар дүүрэг
- Баянгол дүүрэг

“Ил тод” ангилалд:

- Хан-уул дүүрэг
- Баянзүрх дүүрэг
- Улаанбаатар хотын захирагчийн алба

“Зарим талаар ил тод” ангилалд:

- Багахангай дүүрэг
- Налайх дүүрэг
- Багануур дүүрэг

- Сонгинохайрхан дүүрэг
- Чингэлтэй дүүрэг
- Нийслэл хотын засаг даргын тамгын газар тус тус орсон байна.

**Хүснэгт 19. Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн цахим хуудасны ил тод байдал (хувь)**

| № | Дүүргүүдийн нэрс | Нийлбэр оноо | | | | Эрэмбэ /Ранк/ | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2011 | 2015 | 2016 | 2017 | 2011 | 2015 | 2016 | 2017 |
| 1 | НЗДТГ | - | 57.3 | 55.8 | 44.9 | - | 24 | 27 | 60 |
| 2 | УБ хотын захирагчийн ажлын алба | - | 62.7 | 60.4 | 60.1 | - | 14 | 17 | 30 |
| 3 | БГД-ийн ЗДТГ | - | 67 | 39.4 | 88.4 | - | 6 | 58 | 6 |
| 4 | БХД-ийн ЗДТГ | - | 39.5 | 55.2 | 57.0 | - | 77 | 28 | 36 |
| 5 | БЗД-ийн ЗДТГ | - | 55.2 | 49.4 | 60.6 | - | 32 | 41 | 29 |
| 6 | БНД-ийн ЗДТГ | - | 59.4 | 54.4 | 48.7 | - | 20 | 32 | 53 |
| 7 | ЧД-ийн ЗДТГ | - | 54.6 | 54.6 | 43 | - | 36 | 30 | 64 |
| 8 | СБД-ийн ЗДТГ | - | 49.5 | 70.4 | 85.8 | - | 50 | 4 | 8 |
| 9 | СХД-ийн ЗДТГ | - | 48.7 | 48.3 | 46 | - | 54 | 44 | 58 |
| 10 | ХУД-ийн ЗДТГ | - | 65.8 | 60.8 | 80.9 | - | 9 | 16 | 9 |
| 11 | НД-ийн ЗДТГ | - | 54.9 | 56.6 | 49.4 | - | 34 | 24 | 52 |
| **Нийслэлийн дундаж** | | - | | **55.9** | **60.4** | - | | | |
| **Ерөнхий дундаж** | | - | | **52.2** | **55.5** | - | | | |

Нийслэлийн захиргаа дүүргүүдийн цахим хуудасны дундаж үзүүлэлт энэ онд нийт аймгийн дундаж үзүүлэлтээс 12.2 пунктаар бага төвшинд байна. Дундаж үзүүлэлтийг харьцуулаж үзэхэд нийслэлийн дундаж 2016 онд 55.9 байсан бол 2017 онд 60.4 болж өссөн байна. 2017 онд нийслэлийн захиргаа дүүргийн цахим хуудсаас ил тод байдлаараа эхний арван байр дотор Баянгол, Сүхбаатар, Хан-Уул дүүргүүдийн цахим хуудас багтсан байна.

Тухайлбал: Баянгол дүүргийн цахим хуудас 2016 онд эрэмбээрээ 58 дугаарт байсан бол 2017 онд зургаа дугаар байрт орж огцом урагшилсан нь цахим хуудсын ил тод байдал богино хугацаанд сайжрах боломжтой гэдгийг харуулж байна. Налайх дүүрэг цахим хуудасныхаа ил тод байдлаар 24 дугаар байраас 52 дугаар байранд орж 28 байраар хойшилсон байгаа нь цахим хуудасны ил тод байдалдаа анхаарах шаардлага буйг харуулж байна.

**Дүрс 41. Нийслэлийн захиргаа. дүүргүүдийн цахим хуудасны ил тод байдал (хувь)**



Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн цахим хуудасны ил тод байдал өмнөх онтой харьцуулахад 5,4 пунктаар нэмэгдсэн байна. Нийслэлийн захиргаа дүүргүүдийн цахим хуудасны ил тод байдал жилээс жилд өсөлттэй байгааг 2011 оны үзүүлэлтийг 2017 оны үзүүлэлттэй харьцуулан харж болно.

**Хүснэгт 20. Нийслэлийн захиргаа. дүүргийн ТОП 5 байгууллага**

| Дүүргүүдийн нэрс | 2016 | 2017 | 2016 эрэмбэ/ранк | 2017 эрэмбэ/ранк |
|---|---|---|---|---|
| **БГД-ийн ЗДТГ** | 39.4 | 88.4 | 58 | 6 |
| **СБД-ийн ЗДТГ** | 70.4 | 85.8 | 4 | 8 |
| **ХУД-ийн ЗДТГ** | 60.8 | 80.9 | 16 | 9 |
| **БЗД-ийн ЗДТГ** | 49.4 | 60.6 | 41 | 29 |
| **УБ хотын захирагчийн АА** | 60.4 | 60.1 | 17 | 30 |

2017 онд цахим хуудасны ил тод байдлаараа эхний таван байранд Баянгол дүүрэг, Сүхбаатар дүүрэг, Хан-Уул дүүрэг, Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба зэрэг байгууллагуудын цахим хуудас багтсан байна.

## 2.5.1 Үйл ажиллагааны ил тод байдал

Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг авч үзэхдээ:

1. Байгууллагын ерөнхий мэдээлэл
2. Байгууллагын олон нийттэй харилцах мэдээлэл гэсэн хоёр хэсэгт ангилан авч үзсэн.

### Байгууллагын ерөнхий мэдээлэл

Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн цахим хуудсан дахь ерөнхий мэдээллийн ил тод байдлын талаар энэ хэсэгт авч үзнэ.

**Дүрс 42. Нийслэлийн захиргаа. дүүргүүдийн ерөнхий үзүүлэлт (хувь)**




“Тэргүүлэх чиглэл” гэсэн үзүүлэлт дээр өсөлттэй байгаа боловч эрхэм зорилго болон “үйл ажиллагааны стратеги зорилго, зорилтын” мэдээлэл байршуулсан байдал гэсэн үзүүлэлтүүд дээр ихээхэн буурсан байгаа харагдаж байна. Эндээс дүгнэхэд нийслэлийн захиргаа, дүүргүүдийн цахим хуудас дээр эрхэм зорилго, үйл ажиллагааны стратеги зорилго, зорилтын талаарх мэдээлэл хангалтгүй түвшинд байгаа нь илэрхий байна. Байгууллагын ерөнхий

мэдээлэл гэсэн үзүүлэлт дээр нийслэлийн 11 байгууллага дунджаар 42,4 хувьтай байгаа нь "зарим талаар ил тод" гэсэн ангилалд багтаж байна. Өөрөөр хэлбэл хаалттай ангилалд орход их ойрхон байгаа юм.

### *Байгууллагын олон нийттэй харилцах мэдээлэл.*

**Дүрс 43. Нийслэлийн захиргаа. дүүргүүдийн олон нийттэй харилцахтай холбоотой мэдээлэл (хувь)**




2016 оны мониторингийн үр дүнтэй харьцуулахад өссөн болон буурсан үзүүлэлтүүдээ жагсаан харвал:

**Өссөн 4 үзүүлэлтүүд:**

- Байгууллагын хаяг
- Факсын дугаар
- Цахим шуудангаас шууд холбогдох боломж
- Шуудангийн хаяг

**Буурсан 6 үзүүлэлтүүд:**

- Үйл ажиллагаанд дагаж мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм журам, заавар
- Байгууллагын холбоо барих утас

- Цахим шуудангийн хаяг
- Үйлчилгээ авахтай холбоотой материалын жагсаалт
- Олон нийттэй харилцах мэргэжилтний овог нэр

Нийслэлийн захиргаа дүүргийн байгууллагууд хаягаа цахим хуудастаа байршуулах нь ихэссэн байна. Энэ нь 2016 онд 63,6 хувьтай байсан үзүүлэлт энэ онд 90,9 хувьд хүрсэн байгаагаар илэрч байгаа юм.

### 2.5.2 Хүний нөөцийн ил тод байдал

Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн цахим хуудасны хүний нөөцийн ил тод байдал 2016 онд 35,6 хувьтай байсан бол 2017 онд 43.4 хувьтай болж 7,8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

**Дүрс 44. Нийслэлийн захиргаа. дүүргүүдийн хүний нөөцийн ил тод байдал (хувь)**




Нийслэлийн захиргаа дүүргүүдийн цахим хуудсан дахь хүний нөөцийн ил тод байдал өмнөх онтой харьцуулбал 7,8 хувиар өссөн байна. Эдгээр байгууллагын цахим хуудсаас иргэд хүний нөөцтэй холбоотой бүхий л төрлийн мэдээллийг авах, ашиглах боломж нэмэгдэж байна гэж ойлгож болно.

**Дүрс 45. Нийслэлийн захиргаа. дүүргүүдийн хүний нөөцийн ил тод байдлын үзүүлэлт (хувь)**




2017 онд нийслэлийн захиргаа дүүргүүдийн цахим хуудсанд хүний нөөцийн стратеги түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журамтай холбоотой мэдээлэл 27.3 хувьтай байсан байна. Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээлэл 2016 онд 9 хувьтай үнэлэгдсэн бол 2017 онд 36.4 хувь болж ихээхэн өссөн байна.Сул орон тооны зар 2016 онд 36,4 хувьтай мэдээлэгдсэн байгаа нь "*хаалттай*" ангилалд багтаж байсан байна.

Өөрөөр хэлбэл нийслэлийн эдгээр байгууллагууд цахим хуудсандаа сул орон тооны зараа маш хангалтгүй байршуулдаг байсан гэж ойлгогдож байна. Ийм байдлаар аливаа мэдээлэл ил тод биш байгаа нь ашиг сонирхлын зөрчил, авлигыг өөхшүүлж байдаг. Харин 2017 онд сул орон тооны зараа эдгээр 11 байгууллагын 50-аас илүү хувь нь цахим хуудсандаа байршуулсан нь дэвшил гэж үзэж болох юм. Дээрх гурван үзүүлэлт дээр өссөн байгаа бол албан хаагчийн ёс зүйн дүрэм цахим хуудсандаа байршуулах байдал нь өмнөх онд 90.9 хувь байсан бол 54.5 хувь болтлоо буурсан байна.

**Хүснэгт 21. Хүний нөөцийн  ил тод байдлын үнэлгээ ТОП 3 дүүрэг (хувь)**

| Дүүргүүдийн нэрс | Мэдээлэл байгаа эсэх | | Эх сурвалж тодорхой эсэх | | Цаг хугацаа нь байгаа эсэх | | Нийт хувь | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2016 | 2017 | 2016 | 2017 | 2016 | 2017 | 2016 | 2017 |
| БГД-ийн ЗДТГ | 25.7 | 42.8 | 28.6 | 28.6 | 28.6 | 28.6 | 82.8 | 100 |
| ХУД-ийн ЗДТГ | 17.1 | 42.8 | 28.6 | 28.6 | 28.6 | 28.6 | 74.3 | 100 |
| СБД-ийн ЗДТГ | 17.1 | 42.8 | 28.6 | 28.6 | 28.6 | 14.3 | 74.3 | 85.7 |
| Нийт дундаж | 14.8 | 18.7 | 10.4 | 15.6 | 10.4 | 9.1 | 35.6 | 51.9 |

2017 онд цахим хуудсан дахь хүний нөөцийн ил тод байдлаараа Баянгол, Сүхбаатар, Хан-Уул дүүргүүд тэргүүлсэн байна. Хан-Уул, Баянгол дүүргийн цахим хуудас хүний нөөцийн ил тод байдлын шаардлагыг бүрэн хангаж 100 хувь гэж үнэлэгдсэн. Жишээ болгож Баянгол дүүргийн цахим хуудас дахь хүний нөөцийн мэдээллийн буланг та бүхэнд хүргэж байна.

**Зураг 6. БГД-ийн хүний нөөцийн ил тод байдал**




Баянгол дүүргийн цахим хуудасны хүний нөөцийн ил тод байдлын цэс нь сул орон тооны зараас гадна, хүний нөөцийн удирдлагын ил тод байдал, дүрэм журам, хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр гэх зэрэг хамаарал бүхий мэдээллийг багтаасан байсан юм.

## 2.5.3 Төсөв санхүүгийн ил тод байдал

Энэ онд нийслэлийн захиргаа, дүүргүүдийн төсөв санхүүгийн ил тод байдлын хувь өмнөх оноос 1.2 пунктаар өссөн байна.

**Дүрс 46. Төсөв санхүүгийн ил тод байдал (хувь)**




Нийслэлийн захиргаа дүүргүүдийн төсөв санхүүгийн ил тод байдал өмнөх оноос өсөлттэй байгаа харагдаж байна.

**Дүрс 46. Нийслэлийн захиргаа. дүүргүүдийн төсөв санхүүгийн ил тод байдлын үзүүлэлтүүд (хувь)**




Нийслэлийн захиргаа дүүргийн төсөв санхүүгийн ил тод байдлын хувийг 2017 онтой харьцуулан харсан юм. Шилэн дансны цэс байгаа эсэх гэсэн үзүүлэлт дээр өмнө жилийн 100 хувиа хадгалж чадсан байна.

**Өссөн 6 үзүүлэлт:**

- Аудитын тайлан дүгнэлтэнд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
- Төсвийн хэмнэлт хэтрэлт түүний шалтгааны тайлбар
- Хууль тогтоомжинд заасан төлбөр хураамж
- Төсөвт оруулсан нэмэлт өөрчлөлт

- Урьд оны төсвийн гүйцэтгэл
- Санхүүгийн тайланд хийсэн аудит бусад хяналт шалгалтын дүн

**Буурсан 5 үзүүлэлт:**

- Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө
- Байгууллагын тухайн жилийн төсөв
- Төсвийн гүйцэтгэлийн биелэлт
- Хагас бүтэн жилийн санхүүгийн тайлан

**Хүснэгт 22. Төсөв санхүүгийн ил тод байдал ТОП 3 нийслэл, дүүрэг(хувь)**

| Дүүргүүдийн нэрс | Мэдээлэл байгаа эсэх | | Эх сурвалж тодорхой эсэх | | Цаг хугацаа нь байгаа эсэх | | Нийт хувь | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2016 | 2017 | 2016 | 2017 | 2016 | 2017 | 2016 | 2017 |
| БГД-ийн ЗДТГ | 42.8 | 42.8 | 26 | 28.6 | 25.5 | 28.6 | 94.3 | 100 |
| СБД-ийн ЗДТГ | 38.9 | 39.2 | 23.4 | 26 | 22.5 | 25.7 | 84.8 | 90.9 |
| ХУД-ийн ЗДТГ | 38.9 | 35.7 | 23.4 | 23.4 | 22.5 | 22.9 | 84.8 | 82 |
| Нийт дундаж | 33.6 | 31.9 | 21.3 | 20.7 | 20.6 | 24.1 | 75.5 | 76.7 |

Энэ жилийн хувьд цахим хуудасны төсөв санхүүгийн ил тод байдлын үзүүлэлтээр бусад байгууллагаа тэргүүлж эхний гурван байранд Баянгол, Сүхбаатар, Хан-Уул дүүргүүд орсон байгаагаас та бүхэнд Баянгол дүүргийн цахим хуудсан дахь төсөв санхүүгийн ил тод байдлын буланг үзүүлж байна.

**Зураг 7. БГД-ийн төсөв. санхүүгийн ил тод байдал**




Төсөв санхүүгийн талаарх мэдээллүүд зохих ангиллын хувьд тавигдсан байгаагаас гадна мэдээллүүдийг татаж авч ашиглах боломжтой. Тайлан гүйцэтгэлээ шинэчилсэн, шилэн

дансны хэрэгжилтийг хангах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг мөн байршуулсан байсан. 2017 онд нийслэлийн захиргаа дүүргүүдийн төсөв санхүүгийн ил тод байдлын хувь 76,7 байгааг түвшингээр нь авч үзвэл “Ил тод” гэсэн ангилалд багтаж байна.

### 2.5.4 Худалдан авах ажиллагааны ил тод байдал

Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн цахим хуудасны хувьд худалдан авах ажиллагааны ил тод байдлын талаар энэ хэсэгт бичигдсэн болно.

**Дүрс 47. Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн ХАА-ны ил тод байдал (хувь)**




Дүрс дээр харуулсанчлан нийслэлийн захиргаа, дүүргийн худалдан авах ажиллагааны ил тод байдлын хувьд өмнөх онтой харьцуулахад 0,9%-аар өссөн байгаа нь хангалтгүй өсөлт юм. Гэвч 40-өөс дээш хувьтай байгаа учир “зарим талаар ил тод” гэсэн ангилалд багтаж байна.

Цаг хугацааны хувьд тохирсон, тохиромжтой байдал их биш ч гэсэн тодорхой хувиар өссөн байна. Нийслэлийн захиргаа, дүүргүүд өөрийн цахим хуудастаа ХАА-ны талаарх мэдээллээ оруулахдаа оруулсан цаг хугацааг тавих байдал сайнгүй байсан боловч шилэн дансны тусгай сайт дахь мэдээллийн доор тухайн мэдээллийг оруулсан хугацааг тавьсан байгаа нь мэдээллийн цаг хугацааны хувьд тодорхой, тохиромжтой байдал гэсэн үзүүлэлтийн хувийг нэмэгдүүлсэн гэж үзэж байна.

Худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг цахим хуудастаа байршуулахдаа тухайн тендерийн ерөнхий мэдээллийг тавихаас гадна хүлээн авах газар, хүлээн авах огноо, хүлээн авах хүнтэй холбоо барих мэдээлэл зэрэг байгаа тохиолдолд ХАА-ны мэдээллийн эх сурвалж тодорхой байна гэж үзэж байгаа юм. Энэхүү үзүүлэлтийн хувьд өмнөх жилтэй харьцуулахад өссөн болон буурсан зүйлгүй байгаа нь харагдаж байна**.**

Худалдан авах ажиллагааны талаар мэдээлэл байгаа эсэх гэсэн үзүүлэлт дээр өмнөх жилтэй харьцуулахад тодорхой хувиар буурсан байгаа нь нийслэлийн захиргаа дүүргүүд цахим хуудсандаа төсвийн мөнгөөр худалдан авсан бараа үйлчилгээний талаарх мэдээллээ оруулах байдал нь буурсныг илэрхийлж байна.

**Дүрс 48. Нийслэлийн захиргаа. дүүргүүдийн ХАА-ны ил тод байдал (хувь)**




2017 онд нийслэлийн захиргаа, дүүргийн ХАА-ны ил тод байдлын үзүүлэлтүүд зарим нь өсөлттэй байхад зарим нь буурсан байна.

**Өссөн 5 үзүүлэлт:**

- Тендерийн урилга
- Худалдан авсан бараа ажил үйлчилгээний тайлан
- Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын дүгнэлт бусад хяналт шалгалтын дүн
- Мөнгө зарцуулах өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр
- Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ

**Буурсан 4 үзүүлэлт:**

- Тендерийн шалгаруулалтын талаарх мэдээлэл шалгарсан болон шалгараагүй үндэслэл
- Тендерт оролцогчдод тавигдах шалгуур
- Тендерийн шалгаруулалт явуулах журам

- Тендерийн баримт бичиг

**Хүснэгт 23. Нийслэлийн захиргаа. дүүргүүдийн ХАА-ны ил тод байдал ТОП 2 (хувь)**

| Дүүргүүдийн нэрс | Мэдээ-лэл байгаа эсэх | | Эх сурвалж тодор-хой эсэх | | Цаг хугацаа нь байгаа эсэх | | Нийт хувь | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2016 | 2017 | 2016 | 2017 | 2016 | 2017 | 2016 | 2017 |
| **СБД-ийн ЗДТГ** | 34.2 | 38.04 | 22.8 | 25.4 | 22.1 | 26.8 | 79.2 | 90.2 |
| **ХУД-ийн ЗДТГ** | 34.2 | 33.3 | 22.8 | 22.2 | 22.1 | 23.2 | 79.2 | 78.7 |
| **Нийт дундаж** | 34.2 | 22.9 | 22.8 | 15.3 | 22.1 | 14.3 | 79.2 | 52.5 |

ХАА-ны ил тод байдлын үнэлгээгээр Сүхбаатар дүүргийн цахим хуудас 90.2 оноогоор “бүрэн ил тод” гэж үнэлэгдсэн байна. Тиймээс та бүхэнд уг цахим хуудсыг харуулая.

**Зураг 8. СБД-ийн ХАА-ны ил тод байдал**




Сүхбаатар дүүргийн цахим хуудасны хувьд ХАА-ны талаарх мэдээллүүд ХАА-ны төлөвлөгөө, тендерийн урилга, тендер шалгаруулатын үр дүн, худалдан авах ажиллагааны зохион байгуулалтын тайлан гэсэн хэсгүүдэд ангилан оруулсан байсан. Ихээхэн ойлгомжтой бөгөөд мэдээлэл бүрэн байсныг онцлож байна.

## 2.6 ПАРЛАМЕНТИЙН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ВЕБСАЙТЫН ҮЗҮҮЛЭЛТ

Энэхүү бүлэгт парламентын харьяа байгууллагуудын цахим хуудасны ил тод байдлын үнэлгээг харуулна.

Байгууллага бүрийг 2011, 2015, 2016, 2017 оны судалгааны үр дүнгээр харьцуулан, дундаж хувийг ерөнхий төрийн байгууллагуудын дундажтай харьцуулан дараах хүснэгтээр харууллаа.

**Хүснэгт 24. Парламентын харьяа байгууллагын цахим хуудасны ил тод байдлын үнэлгээ (хувь)**

| № | Байгууллагын нэрс | Нийлбэр оноо | | | | Эрэмбэ /Ранк/ | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2011 | 2015 | 2016 | 2017 | 2011 | 2015 | 2016 | 2017 |
| 1 | ТАЗ | 40.9 | 46.4 | 33.5 | 42.2 | 7 | 62 | 67 | 65 |
| 2 | АТГ | 31.5 | 58.5 | 44.8 | 41.8 | 32 | 21 | 49 | 66 |
| 3 | СЗХ | 30.7 | 48.9 | 36.7 | 41.1 | 35 | 51 | 62 | 68 |
| 4 | СЕХ | 19 | 73.3 | 41.1 | 66.3 | 72 | 2 | 57 | 21 |
| 5 | ХЭҮК | 27.1 | 45.9 | 37.2 | 50.5 | 46 | 65 | 61 | 49 |
| 6 | ҮАГ | 35.1 | 44.7 | 22.9 | 60.6 | 20 | 71 | 75 | 29 |
| 7 | ҮСХ | 40.6 | 47.3 | 31.3 | 55.8 | 10 | 58 | 69 | 39 |
| 8 | Монгол банк | 35.1 | 66.5 | 48.5 | 31.3 | 19 | 7 | 42 | 73 |
| 9 | УИХ | 23.8 | 52 | 33.8 | 44.5 | 58 | 44 | 65 | 61 |
| **Парламентын байгууллагын дундаж** | | 28.8 | 53.7 | 42.4 | 48.2 | | | | |
| **Ерөнхий дундаж** | | 28.7 | 52.2 | 43.5 | 55.5 | | | | |

Судалгааны үр дүнгээр парламентийн харьяа байгууллагуудаас Монгол банкны цахим хуудасны ил тод байдал 31.3 хувьтай үнэлэгдэж "*Хаалттай*" ангилалд багтсан байна. ТАЗ, АТГ, СЗХ, ХЭҮК, ҮСХ, УИХ гэсэн зургаан байгууллагын цахим хуудас "*зарим талаар ил тод*" гэсэн ангилалд орсон байна. СЕХ, ҮАГ-н цахим хуудас 60-аас дээш хувиар үнэлэгдэж "*ил тод*" гэсэн ангилалд багтсан байна. Нийтэд нь авч үзвэл парламентын харьяа байгууллагуудын цахим хуудасны ил тод байдал 48,2 хувьтайгаар "*зарим талаар ил тод*" гэсэн ангилалд багтаж байна.

Парламентын байгууллагуудын цахим хуудсуудын ил тод байдлыг хэмжиж буй таван үзүүлэлт тус бүрээр үр дүнг хоёр оноор харьцуулан дор харууллаа.

Дүрс 49. Парламентын харьяа байгууллагуудын ил тод байдлын үнэлгээ(хувь)




Өмнөх онтой харьцуулбал цахим хуудсыг хэмжиж буй таван шалгуур үзүүлэлтээс дөрвөн үзүүлэлт дээр өссөн харагдаж байна. Мэдээллийн найдвартай байдал буюу мэдээллийн эх сурвалж гэсэн үзүүлэлт дээр өмнөх оныхоос 6,4 хувиар буурсан байна.

## 2.6.1 Үйл ажиллагааны ил тод байдал

***Байгууллагын ерөнхий мэдээлэл.***

Байгууллагын ерөнхий мэдээлэл буюу эрхэм зорилго, үйл ажиллагааны зорилго, зорилт, тэргүүлэх чиглэлээ мэдээллэсэн байдлын талаар энэ хэсэгт авч үзнэ.

Дүрс 50. Парламентын харьяа байгууллагуудын ерөнхий мэдээллийн үнэлгээ (хувь)




2016 оны судалгааны үр дүнтэй харьцуулахад дээрх гурван үзүүлэлтүүд бүгд тодорхой хувиар өссөн нь харагдаж байна. Энэ нь парламентийн харьяа байгууллагуудын тэргүүлэх чиглэл, үйл ажиллагааны стратеги зорилго зорилт, эрхэм зорилго зэрэг мэдээлэл илүү ил тод болсонтой холбоотой.

***Байгууллагын олон нийттэй харилцах мэдээлэл.***

Парламентийн харьяа байгууллагуудын олон нийттэй харилцах мэдээллүүд цахим хуудаст байршсан байдлыг авч үзвэл хамгийн дутмаг мэдээлэгддэг нь иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь гэсэн үзүүлэлт юм. Байгууллагатай холбоо барих утас, байгууллагын хаяг, факсын дугаар, цахим шуудангын хаяг зэрэг мэдээллүүд хангалттай түвшинд мэдээлэгдэж байдаг нь доорхи дүрсээс харагдаж байна.

Дүрс 51. Парламентын харьяа байгууллагуудын олон нийттэй харилцах мэдээлэл (хувь)



**Хүний нөөцийн ил тод байдал.**

Байгууллагуудын хүний нөөцийн ил тод байдлын үзүүлэлтүүдийг хүний нөөцийн мэдээлэл байгаа эсэх, тус мэдээллийн эх сурвалж байгаа эсэх, цаг хугацааны хувьд тохирсон байдал зэрэг шалгуураар дараах хүснэгтэнд харууллаа.

Дүрс 52. Парламентын харьяа байгууллагуудын хүний нөөцийн ил тод байдал(хувь)




Дүрс 53. Парламентын харьяа байгууллагуудын хүний нөөцийн ил тод байдлын үзүүлэлт (хувь)




Та бүхний харж байгаачлан хүний нөөцийн стратеги түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам гэсэн үзүүлэлт 2016 онтой харьцуулбал энэ онд 44,5 хувиар өссөн байна. Парламентийн харьяа байгууллагын цахим хуудас дахь хүний нөөцийн ил тод байдал 39,4 хувьтай байгаа нь 2016 оны судалгааны үр дүнтэй харьцуулахад 26.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Гэсэн хэдий ч 40-оос доош хувьтай учраас “хаалттай” ангилалд багтсаар байгаа юм.

## Төсөв санхүүгийн ил тод байдал

Төсөв, санхүүгийн ил тод байдалд үндэслэсэн үзүүлэлтүүдийг доорх үр дүнгүүдээр илэрхийлж байна.

Дүрс 65. **Парламентын харьяа байгууллагуудын төсөв санхүүгийн ил тод байдал (хувь)**




Парламентийн байгууллагуудын төсөв санхүүгийн талаарх мэдээллээ нийтэлж байгаа байдал 28,5 хувьтай, тус мэдээллийнхээ эх сурвалжийг нийтлэх байдал 16 хувьтай, цаг хугацааны тохиромжтой үед нь оруулж буй байдал 18 хувьтай байна. Нийт гурван үзүүлэлт байгаагаас бүгд өссөн байна.

Төсөв санхүүгийн мэдээллээ бусдаас илүү мэдээлэж байгаа топ байгууллагуудыг дор жагсаан харуулав.

**Хүснэгт 25. Төсөв, санхүүгийн  ил тод байдал ТОП 3 (хувь)**

| Байгууллагын нэрс | Мэдээлэл байгаа эсэх | | Эх сурвалж тодорхой эсэх | | Цаг хугацаа нь байгаа эсэх | | Нийт хувь | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2016 | 2017 | 2016 | 2017 | 2016 | 2017 | 2016 | 2017 |
| Сонгуулийн ерөнхий хороо | 19.4 | 35.02 | 13 | 22.9 | 12.3 | 22.2 | 44.7 | 80.1 |
| Үндэсний аудитын газар | 19.4 | 35.02 | 13 | 22.9 | 8.2 | 19.07 | 40.6 | 76.9 |
| Монгол улсын их хурал | 19.4 | 35.02 | 7.8 | 20.02 | 12.3 | 19.07 | 39.5 | 58.5 |
| Нийт дундаж | 4.3 | 28.5 | 4.04 | 16.03 | 11.7 | 18.01 | 46.9 | 62.6 |

Дээрх байгууллагуудаас “Сонгуулийн ерөнхий хороо”  80,1 хувийн үзүүлэлттэйгээр төсөв, санхүүгийн мэдээллээ цахим хуудсандаа “бүрэн ил тод” түвшинд мэдээллэдэг гэж үнэлэгдлээ.

Үндэсний Аудитын Газар 76,9 хувийн үзүүлэлттэй “ил тод” гэсэн ангилалд багтсан бол Улсын Их Хурал 58,5 хувиар “зарим талаар ил тод” гэсэн ангилалд багтсан байна.

Зураг 9. СЕХ-ын төсөв, санхүүгийн ил тод байдал




Сонгуулийн ерөнхий газар нь аудитын тайлан, батлагдсан төсөв, дараа жилийн төсвийн төсөл, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл гэж ангилан шаардлагатай мэдээллүүдийг байршуулжээ. Энэ бүлгийг дүгнэвэл парламентийн байгууллагуудын бүх үзүүлэлтүүдийн дундаж хувь нь 36,2 байгаа нь энэ ангиллын байгууллагуудын цахим хуудас “хаалттай” түвшинд байгааг илэрхийлж байгаа юм.

## 2.6.2 Худалдан авах ажиллагааны ил тод байдал

ХАА-ны ил тод байдлын дундаж үнэлгээг доор харууллаа.

Дүрс 54. ХАА-ны ил тод байдал (хувь)



Парламентын харьяа байгууллагуудын ХАА-ны ил тод байдлын дундаж үнэлгээ 36,2 хувьтай байгаа нь "хаалттай" гэсэн ангилалд орж байна. Гэвч 2016 оны судалгааны үр дүнтэй харьцуулан үзвэл 35,2 хувиар огцом өссөнийг илтгэх үзүүлэлт болж байна.

Дүрс 55. Парламентын харьяа байгууллагуудын ХАА-ны ил тод байдлын үзүүлэлтүүд (хувь)




**Өссөн 8 үзүүлэлт:**

- Худалдан авсан бараа ажил үйлчилгээний тайлан
- Тендерийн урилга
- Тендерийн шалгаруулалтын талаарх мэдээлэл шалгарсан болон шалгараагүй үндэслэл
- ХАА-д хийсэн аудитын дүгнэлт бусад хяналт шалгалтын дүн
- Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ
- Тендерт оролцохыг сонирхогчид тавигдах шалгуур үзүүлэлт
- Мөнгө зарцуулах өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр
- Тендерийн баримт бичиг

Та бүхний харж байгаачлан буурсан үзүүлэлт байхгүй харин тендерийн шалгаруулалт явуулах журам гэсэн үзүүлэлт өмнөх жилийнхтэй тэнцсэн байгаа юм.

# ХАВСРАЛТ 1. ҮНДСЭН ОЙЛГОЛТУУД

Төрийн байгууллын “ил тод” болон “нээлттэй байдал” гэдэг нь ялгаатай ойлголтууд бөгөөд уг мониторинг эхний ойлголтод суурилна. Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа. Хөгжлийн Байгууллагын тодорхойлсноор ил тод байдал бол сайн засаглалын тулгын гурван чулуу болох *хариуцан тайлагнах байдал* (accountability); ил *тод байдал* (transparency). *Нээлттэй байдал* (openness)-ын нэг бүрэлдэхүүн хэсэг юм (OECD, 2011). Харин НҮБ-ын Ази. Номхон Далайн Эдийн засаг Нийгмийн Комисс ил тод байдлыг сайн засаглалыг илэрхийлэх найман шинж байдлын нэг гэж үзээд энэ нь нээлттэй байдал гэх ойлголтоос тусдаа болохыг тэмдэглэжээ. Мөн бидний судалгаандаа гол мөрдлөг болгон ашиглаж буй 143 дугаар тогтоол “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт” нь нээлттэй байдлыг гэхээс илүүтэй ил тод байдлыг онцлон авч үзсэн байна. Тиймээс эдгээрээс үндэслэн мониторинг нь “ил тод” байдлыг онцлон шинжилсэн.

**Ил тод байдал:** “Төрийн байгуулагын үйл ажиллагааны талаарх мэдээлэл нь найдвартай. холбогдолтой. цаг үеэс хоцролгүй олон нийтэд хүрч байгааг хэлнэ” (OECD, 2011). Харин НҮБ-ын Ази Номхон Далайн Эдийн Засаг Нийгмийн комисс “Ил тод байдал гэдэг нь төрөөс гаргаж буй шийдвэр. үйл ажиллагааны талаарх мэдээлэл нь уг шийдвэрийн нөлөөлж буй хэнд ч чөлөөтэй. хүртээмжтэй байхыг хэлнэ” гэжээ (UNESCAP, 2011).

**Цахим үйлчилгээ:** Төрийн байгууллагаас иргэдэд үзүүлдэг үндсэн үйлчилгээг цахим хуудсаар дамжуулан үзүүлэх

**Цахим оролцоо:** Төрийн байгууллагын үйл ажиллагаа болон гаргаж буй хууль. тогтоол.

**Төрийн байгууллагын цахим хуудас:** Төрийн байгууллагаас өөрсдийн шийдвэр. үйл ажиллагаа. бүтээгдэхүүн болон иргэдэд шаардлагатай. хуулиар хориогүй бусад мэдээллийн үйлчилгээ үзүүлэх. төрийн үйлчилгээг сүлжээгээр дамжуулан иргэдэд хүргэхэд зориулсан вэб технологид суурилсан мэдээллийн систем

**Байгууллагын бүтэц. зохион байгуулалт:** Тухайн байгууллага үйл ажиллагаагаа хэвийн хэмжээнд явуулахад баримтлах хууль. эрхзүйн актаар баталгаажуулсан албан ёсны бүтэц. зохион байгуулалт

**Байгууллагын үйл ажиллагаа:** Тухайн байгууллагын өдөр тутмын болон иргэдэд үйлчилгээ үзүүлэхэд чиглэсэн бүхий л үйл ажиллагаа

**Хүний нөөцийн бодлогын ил тод байдал:** Төрийн байгууллагын албан хаагчийн ажлын зар болон сонгож авах шалгуур үзүүлэлт. түүнтэй холбоотой баримт бичгийг иргэд олж авах боломжоор хангасан байдал

**Төсөв. санхүүгийн ил тод байдал:** УИХ-аас батлан тухайн төрийн байгууллагад зарцуулах эрх олгосон төсөв. түүний зарцуулалт. төсвийн төсөл. мөн эдгээр баримт бичигт хийгдсэн аудит болон бусад хяналтын тайланг иргэдэд ойлгомжтой байдлаар түгээх. түүнийг ашиглах боломж олгосон байдал

**Худалдан авах ажиллагааны ил тод байдал:** Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа. ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу хийгдэж буй бүхий л худалдан авалтын урилга болон холбогдох баримт бичгүүдийг ашиглахад хялбар байдлаар иргэдэд түгээх. түүнийг ашиглах боломж олгосон байдаг.

# ХАВСРАЛТ 2. АРГА ЗҮЙН ТАЙЛБАР

Хүснэгт 26. Мониторингийн шалгуур үзүүлэлтүүд

| Шалгуур үзүүлэлт | Тодорхойлолт | Хэмжүүр | Хүрээ |
|---|---|---|---|
| **Мэдээллийн холбогдолтой байдал (Relevance)** | Тухайн цахим хуудас нь МИТББМАЭтХ болон ШДтХ-д заасан мэдээллүүдийг хэрэглэгчдэд өгч байгаа эсэх | Мэдээлэл цогц бүрэн байгаа эсэх | Үйл ажиллагаа |
| | | | Хүний нөөц |
| | | | Төсөв. санхүү байдал |
| | | | Худалдан авах ажиллагаа |
| **Мэдээллийн найдвартай байдал (Reliability)** | Тухайн цахим хуудас дахь мэдээлэл хэрэглэгчдэд итгэл төрүүлэхүйц байгаа эсэх | Мэдээллийн эх сурвалж тодорхой байгаа эсэх | Хүний нөөц |
| | | | Төсөв. санхүү байдал |
| | | | Худалдан авах ажиллагаа |
| **Мэдээллийн цаг үеийн байдал (Timeliness)** | Цахим хуудас цаг үеийн. ач холбогдлоо алдаагүй мэдээлэл тавьсан эсэх | Тухайн мэдээллийг оруулсан хугацаа тодорхой эсэх | Хүний нөөц |
| | | | Төсөв. санхүү байдал |
| | | | Худалдан авах ажиллагаа |
| | | Тухайн мэдээлэл хэрэглэгчдэд зориулж боломжит хугацаанд нийтлэгдэж байгаа эсэх | Хүний нөөц |
| | | | Төсөв. санхүү байдал |
| | | | Худалдан авах ажиллагаа |
| | | Тухайн мэдээлэл тогтмол шинэчлэгддэг эсэх | Хүний нөөц |
| | | | Төсөв. санхүү байдал |
| | | | Худалдан авах ажиллагаа |
| **Цахим хуудасны хүртээмжтэй байдал (Accessibility)** | Цахим хуудас нь хэрэглэгчид төрийн байгууллагаас шууд хандан мэдээлэл авах боломж олгосон. мөн хоёр талын оролцоог хангасан эсэх | Асуулт хариултын булан байгаа эсэх | |
| | | Хэлэлцүүлгийн булан байгаа эсэх | |
| | | Холбоотой байгууллагын холбоос линк байгаа эсэх | |
| | | Тогтмол асуудаг асуултуудын хариулт байгаа эсэх (FAQ) | |
| | | Хэлний сонголт байгаа эсэх | |
| **Цахим хуудасны хэрэглэхэд хялбар байдал (Usability)** | Хэрэглэгчдэд тухайн цахим хуудсын бүтэц. дизайн. үзэмж зэрэг нь ашиглахад хялбар байгаа эсэх | Цахим хуудасны үсгийн хэмжээ тохиромжтой. харагдахуйц байгаа эсэх | |
| | | Цахим хуудасны цэс ойлгомжтой эсэх | |
| | | Цахим хуудас өнгөний зохицолтой эсэх | |
| | | Цахим хуудасны бүх мэдээлэл нь нэгэн жигд сонгосон хэл дээр гарч байгаа эсэх | |
| | | Цахим хуудасны мэдээлэл уншиж үзэхэд шаардлагатай программыг татаж авах боломжтой байгаа эсэх | |
| | | Дурын браузерээс тухайн цахим хуудас руу орох боломж байгаа эсэх | |
| | | Цахим хуудаст алдаа гарч байгаа тохиолдолд шийдэх арга замыг зааж өгч байгаа эсэх | |
| | | Цахим хуудаст хайлтын цэс байгаа эсэх | |
| | | Цахих хуудаст цахим шуудангийн хаяг байгаа эсэх | |
| | | Цахим хуудаснаас хэвлэх боломж байгаа эсэх | |
| | | Цахим хуудаст файлыг хадгалах боломж байгаа эсэх | |
| | | Цахим хуудаснаас мэдээллийг бусдад илгээх боломж байгаа эсэх | |

**Хүснэгт 27. Тухайн шалгуурыг ямар хэмжээнд хангаж байгааг үнэлэх үнэлгээ**

| Хувь | Холбогдолтой байдал | Найдвартай байдал | Цаг үеийн байдал | Хүртээмжтэй байдал | Хэрэглэхэд хялбар байдал | Ил тод байдал |
|---|---|---|---|---|---|---|
| 81-100 | Бүрэн холбогдолтой | Мэдээлэл бүрэн найдвартай | Мэдээлэл тогтмол шинэчлэгддэг | Бүрэн хүртээмжтэй | Хэрэглэхэд маш хялбар | Бүрэн ил тод |
| 61-80 | Холбогдолтой | Найдвартай | Ихэнхи мэдээлэл шинэчлэгддэг | Хүртээмжтэй | Хэрэглэхэд боломжтой | Ил тод |
| 41-60 | Зарим талаар холбогдолтой | Зарим талаар найдвартай | Зарим мэдээлэл шинэчлэгддэг | Зарим талаар хүртээмжтэй | Хэрэглэхэд төвөгтэй | Зарим талаар ил тод |
| 0-40 | Мэдээлэл огт байхгүй эсвэл холбогдолгүй | Найдваргүй | Хоцрогдсон мэдээлэл | Хүртээмжгүй | Хэрэглэхэд маш төвөгтэй | Хаалттай |

**Хүснэгт 28. 2015 оны мониторингийн аргазүйд нэмж оруулсан шалгуур үзүүлэлтүүд**

| Шалгуур үзүүлэлтийн хүрээ | Нэмсэн үзүүлэлт | Эх сурвалж |
|---|---|---|
| **Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал** | Төрийн үйлчилгээ авахтай холбоотой материалын жагсаалт | МИТББМАЭтХ-ийн 7.1.3-р зүйл |
| | Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж буй хууль. тогтоомж. дүрэм. журам. заавар | МИТББМАЭтХ-ийн 7.1.4-р зүйл |
| **Хүний нөөцийн бодлогын ил тод байдал** | Албан хаагчийн ёс зүйн дүрэм | МИТББМАЭтХ-ийн 8.1.3-р зүйл |
| | Хүний нөөцийн стратеги. түүний хэрэгжилтийг хянаж. үнэлэх журам | МИТББМАЭтХ-ийн 8.1.4-р зүйл |
| | Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлж байга | МИТББМАЭтХ-ийн 8.1.5-р зүйл |
| **Төсөв. санхүүгийн ил тод байдал** | Шилэн дансны тусгай цэс байгаа эсэх | ШДтХ-ийн 5.1.1-р зүйл |
| | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө | ШДтХ-ийн 6.1.1-р зүйл |
| | Аудитын тайлан дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээлэл | ШДтХ-ийн 6.1.5-р зүйл |
| | Төсвийн хэмнэлт хэтрэлт түүний шалтгааны тайлбар | ШДтХ-ийн 6.1.5-р зүйл |
| **Худалдан авах ажиллагааны ил тод байдал** | Тендерийн баримт бичиг | ШДтХ-ийн 6.4.3-р зүйл |
| | Тендер шалгаруулалт явуулах журам | ШДтХ-ийн 6.4.3-р зүйл |
| | Тендерт оролцохыг сонирхогчид тавигдах шалгуур үзүүлэлт | ШДтХ-ийн 6.4.3-р зүйл |
| | Цалингийн зардлаас бусад 5 сая.төг-с дээш үнийн дүн бүхий орлого. зарлагын мөнгөн гүйлгээ тус бүрээр. гүйлгээний агуулга | ШДтХ-ийн 6.4.5-р зүйл |
| | Мөнгө зарцуулах өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр/бонд. зээл. өрийн бичиг гэх мэт/ | ШДтХ-ийн 6.4.8-р зүйл |

# ХАВСРАЛТ 3. СУДАЛГААНД ХАМРУУЛСАН ЦАХИМ ХУУДСУУД

## Монгол Улсын яам

| | | |
|---|---|---|
| 1. | Байгаль орчин аялал жуулчлалын яам | www.mne.mn |
| 2. | Гадаад харилцааны яам | www.mfa.gov.mn |
| 3. | Сангийн яам | www.mof.gov.mn |
| 4. | Хууль зүй дотоод хэргийн яам | www.mojha.gov.mn |
| 5. | Барилга хот байгуулалтын яам | www.mcud.gov.mn |
| 6. | Батлан хамгаалах яам | www.mod.gov.mn |
| 7. | Боловсрол соёл шинжлэх ухааны яам | www.mecss.gov.mn |
| 8. | Зам тээвэр хөгжлийн яам | www.mrtd.gov.mn |
| 9. | Уул уурхай хүнд үйлдвэрийн яам | www.mmhi.gov.mn |
| 10. | Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрлэлийн яам | www.mofa.gov.mn |
| 11. | Хөдөлмөр нийгэм хамгааллын яам | www.mlsp.gov.mn |
| 12. | Эрчим хүчний яам | www.energy.gov.mn |
| 13. | Эрүүл мэндийн яам | www.mohs.mn |

### *2.1 Хэрэгжүүлэгч агентлаг*

| | | |
|---|---|---|
| 1. | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар | www.pcsp.gov.mn |
| 2. | Биеийн тамир, спортын газар | www.sport.gov.mn |
| 3. | Цаг уур, орчны шинжилгээний газар | www.namem.gov.mn |
| 4. | Гаалийн ерөнхий газар | www.customs.gov.mn |
| 5. | Татварын ерөнхий газар | www.mta.mn |
| 6. | Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар | www.burtgel.gov.mn |
| 7. | Архивын ерөнхий газар | www.archives.gov.mn |
| 8. | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар | www.cd.gov.mn |
| 9. | Гадаад иргэн харьяатын газар | www.immirgration.gov.mn |
| 10. | Соёл урлагийн газар | www.culture.gov.mn |
| 11. | Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар | www.gazar.gov.mn |
| 12. | Иргэний нисэхийн ерөнхий газар | www.mcaa.gov.mn |
| 13. | Ашигт малтмал газрын тосны газар | www.mrpam.gov.mn |
| 14. | Мал эмнэлэг, үржлийн газар | www.dvab.gov.mn |
| 15. | Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар | www.ndaatgal.mn |
| 16. | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар | www.hudulmur-halamj.gov.mn |
| 17. | Гэр бүл, Хүүхэд, залуучуудын хөгжлийн газар | www.fcy.gov.mn |

### *2.2 Тохируулагч агентлаг*

| | | |
|---|---|---|
| 1. | Тагнуулын ерөнхий газар | www.gia.gov.mn |
| 2. | Үндэсний хөгжлийн газар | www.nda.gov.mn |
| 3. | Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар | www.cita.gov.mn |
| 4. | Мэргэжлийн хяналтын ерөнхий газар | www.inspection.gov.mn |
| 5. | Онцгой байдлын ерөнхий газар | www.nema.gov.mn |
| 6. | Шудрага өрсөлдөөн , хэрэглэгчийн төлөө газар | www.afccp.gov.mn |
| 7. | Стандарчлал, хэмжил зүйн газар | www.masm.gov.mn |
| 8. | Цагдаагийн ерөнхий газар | www.police.gov.mn |
| 9. | Хил хамгаалах ерөнхий газар | www.bpo.gov.mn |
| 10. | Зэвсэгт хүчний жанжин штаб | www.gsmaf.gov.mn |

## Орон нутгийн засаг даргийн тамгийн газар

| | | |
|---|---|---|
| 1. | Архангай | www.arkhangai.gov.mn |
| 2. | Баян-Өлгий | www.bayanulgii.gov.mn |
| 3. | Баянхонгор | www.bayankhongor.mn |
| 4. | Булган | www.bulgan.gov.mn |

| | | |
|---|---|---|
| 5. | Говь-Алтай | www.govi-altai.gov.mn |
| 6. | Говьсүмбэр | www.govisumber.gov.mn |
| 7. | Дархан-Уул | www.e-darkhan.com |
| 8. | Дорноговь | www.dornogobi.gov.mn |
| 9. | Дорнод | www.dornod.gov.mn |
| 10. | Дундговь | www.dundgovi.gov.mn |
| 11. | Завхан | www.zavkhan.mn |
| 12. | Орхон | www.erdenet.mn |
| 13. | Өвөрхангай | www.uvurkhangai.gov.mn |
| 14. | Өмнөговь | www.umnugovi.gov.mn |
| 15. | Сүхбаатар | www.sukhbaatar.mn |
| 16. | Сэлэнгэ | www.selenge.mn |
| 17. | Төв | www.tuv.mn |
| 18. | Увс | www.uvsmongolia.mn |
| 19. | Хөвсгөл | www.huvsgul.mn |
| 20. | Хэнтий | www.khentii.mn |
| 21. | Ховд | www.khovd.gov.mn |

## Парламентийн харъяа байгууллагууд

| | | |
|---|---|---|
| 1. | Төрийн Албаны Зөвлөл | www.csc.gov.mn |
| 2. | Авлигатай Тэмцэх Газар | www.iaac.mn |
| 3. | Санхүүгийн Зохицуулах Хороо | www.frc.mn |
| 4. | Сонгуулийн Ерөнхий Хороо | www.gec.gov.mn |
| 5. | Хүний Эрхийн Үндэсний Комисс | www.mn-nhrc.org |
| 6. | Үндэсний Аудитын Газар | www.mnao.mn |
| 7. | Үндэсний Статистикийн Хороо | www.nso.mn |
| 8. | Монгол Банк | www.mongolbank.mn |
| 9. | Монгол Улсын Их Хурал | www.parliament.mn |

## Улаанбаатарын дүүргүүдийн ЗДТГ

| | | |
|---|---|---|
| 1. | Нийслэл Улаанбаатар хот | www.ulaanbaatar.mn |
| 2. | Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба | www.ubservice.ub.gov.mn |
| 3. | Баянгол дүүрэг | www.bgd.mn |
| 4. | Багахангай дүүрэг | www.bagakhangai.ub.gov.mn |
| 5. | Баянзүрх дүүрэг | www.bzd.ub.gov.mn |
| 6. | Багануур дүүрэг | www.bnd.ub.gov.mn |
| 7. | Чингэлтэй дүүрэг | www.chingeltei.gov.mn |
| 8. | Сүхбаатар дүүрэг | www.sbd.ub.gov.mn |
| 9. | Сонгинохайрхан дүүрэг | www.shd.mn |
| 10. | Хан-Уул дүүрэг | www.khanuul.mn |
| 11. | Налайх дүүрэг | www.nad.ub.gov.mn |

## ХАВСРАЛТ 4. ЦАХИМ ХУУДСУУДЫН ЭРЭМБЭЛЭЛТ

| № | Төрийн байгууллагууд | Мэдээллийн хамааралтай байдал | Мэдээллийн найдвартай байдал | Мэдээллийн цаг үеийн байдал | Мэдээллийн хүртээмжтэй байдал | Вебсайтыг хэрэглэхэд хялбар байдал | Нийлбэр хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Хөвсгөл аймаг | 24.8 | 19.0 | 20.0 | 15.0 | 15.0 | 93.8 |
| 2 | Завхан аймаг | 27.0 | 18.1 | 20.0 | 14.2 | 13.9 | 93.2 |
| 3 | Дорнод аймаг | 26.3 | 18.1 | 20.0 | 14.2 | 13.9 | 92.4 |
| 4 | Дорноговь аймаг | 24.8 | 19.0 | 20.0 | 14.2 | 13.9 | 91.9 |
| 5 | Орхон аймаг | 26.3 | 18.1 | 20.0 | 14.2 | 12.9 | 91.4 |
| 6 | Баянгол дүүрэг | 27.0 | 17.1 | 20.0 | 12.5 | 11.8 | 88.4 |
| 7 | Сүхбаатар аймаг | 23.3 | 18.1 | 20.0 | 13.3 | 12.9 | 87.5 |
| 8 | Хэнтий аймаг | 22.5 | 17.1 | 20.0 | 13.3 | 12.9 | 85.8 |
| 9 | Сүхбаатар дүүрэг | 26.3 | 18.1 | 13.3 | 14.2 | 13.9 | 85.8 |
| 10 | Хан-Уул дүүрэг | 24.0 | 16.2 | 16.7 | 13.3 | 10.7 | 80.9 |
| 11 | Цагдаагийн ерөнхий газар | 22.3 | 17.0 | 16.7 | 10.6 | 12.7 | 79.3 |
| 12 | Говьсүмбэр аймаг | 21.8 | 16.2 | 13.3 | 11.7 | 13.9 | 76.9 |
| 13 | Өвөрхангай аймаг | 21.8 | 16.2 | 16.7 | 10.8 | 10.7 | 76.2 |
| 14 | Баянхонгор аймаг | 23.3 | 16.2 | 13.3 | 12.5 | 10.7 | 76.0 |
| 15 | Булган аймаг | 19.5 | 16.2 | 13.3 | 11.7 | 13.9 | 74.6 |
| 16 | Өмнөговь аймаг | 17.3 | 16.2 | 16.7 | 11.7 | 11.8 | 73.6 |
| 17 | Дархан-Уул аймаг | 21.0 | 14.3 | 10.0 | 10.0 | 12.9 | 68.1 |
| 18 | Онцгой байдлын ерөнхий газар | 19.2 | 13.0 | 10.0 | 14.1 | 11.5 | 67.9 |
| 19 | Мэргэжлийн хяналтын ерөнхий газар | 23.8 | 15.0 | 3.3 | 11.5 | 13.8 | 67.5 |
| 20 | Хил хамгаалах ерөнхий газар | 21.5 | 14.0 | 13.3 | 9.7 | 8.1 | 66.7 |
| 21 | Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар | 19.2 | 13.0 | 10.0 | 11.5 | 12.7 | 66.4 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 22 | Сонгуулийн ерөнхий хороо | 20.8 | 13.0 | 13.3 | 8.8 | 10.4 | 66.3 |
| 23 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар | 21.5 | 13.0 | 6.7 | 10.6 | 13.8 | 65.6 |
| 24 | Говь-Алтай аймаг | 18.0 | 10.5 | 13.3 | 11.7 | 11.8 | 65.3 |
| 25 | Сэлэнгэ аймаг | 21.0 | 13.3 | 16.7 | 6.7 | 6.4 | 64.1 |
| 26 | Дундговь аймаг | 17.3 | 13.3 | 13.3 | 10.0 | 8.6 | 62.5 |
| 27 | Эрчим хүчний яам | 19.2 | 12.0 | 6.7 | 10.6 | 13.8 | 62.3 |
| 28 | Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар | 20.0 | 13.0 | 3.3 | 10.6 | 13.8 | 60.8 |
| 29 | Барилга хот байгуулалтын яам | 17.7 | 11.0 | 6.7 | 11.5 | 13.8 | 60.7 |
| 30 | Баянзүрх дүүрэг | 18.0 | 12.4 | 13.3 | 8.3 | 8.6 | 60.6 |
| 31 | Үндэсний аудитын газар | 19.2 | 14.0 | 13.3 | 7.1 | 6.9 | 60.5 |
| 32 | Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба | 16.9 | 13.0 | 6.7 | 9.7 | 13.8 | 60.1 |
| 33 | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар | 18.5 | 12.0 | 13.3 | 7.1 | 9.2 | 60.1 |
| 34 | Баян-Өлгий аймаг | 18.8 | 12.4 | 16.7 | 6.7 | 5.4 | 59.8 |
| 35 | Төв аймаг | 17.3 | 13.3 | 13.3 | 6.7 | 8.6 | 59.2 |
| 36 | Зам тээвэр хөгжлийн яам | 20.0 | 11.0 | 6.7 | 9.7 | 11.5 | 58.9 |
| 37 | Архивын ерөнхий газар | 18.5 | 12.0 | 3.3 | 10.6 | 13.8 | 58.2 |
| 38 | Цаг уур орчны шинжилгээний газар | 19.2 | 12.0 | 3.3 | 9.7 | 13.8 | 58.1 |
| 39 | Багахангай дүүрэг | 15.0 | 13.3 | 6.7 | 9.2 | 12.9 | 57.0 |
| 40 | Стандарт, хэмжил зүйн газар | 19.2 | 11.0 | 6.7 | 10.6 | 9.2 | 56.7 |
| 41 | Ашигт малтмал, газрын тосны газар | 16.2 | 10.0 | 3.3 | 11.5 | 15.0 | 56.0 |
| 42 | Үндэсний статистикийн хороо | 20.8 | 11.0 | 10.0 | 7.1 | 6.9 | 55.8 |
| 43 | Мал эмнэлэгийн үржлийн газар | 15.4 | 11.0 | 6.7 | 9.7 | 12.7 | 55.4 |
| 44 | Гадаадын иргэн харъяатын газар | 18.5 | 11.0 | 3.3 | 9.7 | 12.7 | 55.2 |
| 45 | Боловсрол соёл шинжлэх ухааны яам | 16.9 | 9.0 | 6.7 | 9.7 | 12.7 | 55.0 |
| 46 | Увс аймаг | 18.8 | 9.5 | 16.7 | 4.2 | 5.4 | 54.5 |
| 47 | Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар | 18.5 | 10.0 | 6.7 | 7.1 | 10.4 | 52.6 |
| 48 | Иргэний нисэхийн ерөнхий газар | 17.7 | 8.0 | 3.3 | 9.7 | 12.7 | 51.4 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 49 | Сангийн яам | 15.4 | 8.0 | 6.7 | 9.7 | 11.5 | 51.3 |
| 50 | Хүний эрхийн үндэсний комисс | 17.7 | 9.0 | 6.7 | 7.9 | 9.2 | 50.5 |
| 51 | Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрлэлийн яам | 16.2 | 9.0 | 3.3 | 8.8 | 12.7 | 50.0 |
| 52 | Уул уурхай хүнд үйлдвэрийн яам | 16.2 | 10.0 | 0.0 | 9.7 | 13.8 | 49.7 |
| 53 | Налайх дүүрэг | 11.3 | 8.6 | 6.7 | 10.0 | 12.9 | 49.3 |
| 54 | Багануур дүүрэг | 12.0 | 10.5 | 3.3 | 10.0 | 12.9 | 48.7 |
| 55 | Гаалийн ерөнхий газар | 15.4 | 11.0 | 3.3 | 7.1 | 11.5 | 48.3 |
| 56 | Батлан хамгаалах яам | 13.8 | 10.0 | 3.3 | 7.9 | 11.5 | 46.7 |
| 57 | Архангай аймаг | 15.8 | 11.4 | 3.3 | 8.3 | 7.5 | 46.3 |
| 58 | Гадаад харилцааны яам | 11.5 | 10.0 | 3.3 | 9.7 | 11.5 | 46.1 |
| 59 | Сонгинохайрхан дүүрэг | 15.8 | 11.4 | 3.3 | 5.8 | 9.6 | 46.0 |
| 60 | Татварын ерөнхий газар | 12.3 | 11.0 | 0.0 | 8.8 | 13.8 | 46.0 |
| 61 | Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар | 16.2 | 9.0 | 6.7 | 7.1 | 6.9 | 45.8 |
| 62 | Үндэсний хөгжлийн газар | 14.6 | 8.0 | 0.0 | 9.7 | 12.7 | 45.0 |
| 63 | Улаанбаатар | 10.0 | 10.0 | 3.3 | 8.8 | 12.7 | 44.8 |
| 64 | Монгол улсын их хурал | 16.2 | 9.0 | 3.3 | 7.9 | 8.1 | 44.5 |
| 65 | Биеийн тамир спортын газар | 11.5 | 10.0 | 0.0 | 9.7 | 12.7 | 43.9 |
| 66 | Гэр бүл, Хүүхэд, залуучуудын хөгжлийн газар | 11.5 | 7.0 | 6.7 | 7.9 | 10.4 | 43.5 |
| 67 | Чингэлтэй дүүрэг | 15.0 | 8.6 | 3.3 | 7.5 | 8.6 | 43.0 |
| 68 | Төрийн албаны зөвлөл | 16.2 | 8.0 | 0.0 | 8.8 | 9.2 | 42.2 |
| 69 | Авлигатай тэмцэх газар | 14.6 | 8.0 | 0.0 | 8.8 | 10.4 | 41.8 |
| 70 | Хөдөлмөр нийгэм хамгааллын яам | 13.8 | 8.0 | 6.7 | 6.2 | 6.9 | 41.6 |
| 71 | Газар зохион байгуулалт геодези, зураг зүйн газар | 13.1 | 8.0 | 0.0 | 8.8 | 11.5 | 41.4 |
| 72 | Санхүүгийн зохицуулах хороо | 16.9 | 7.0 | 0.0 | 7.9 | 9.2 | 41.1 |
| 73 | Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөөх газар | 16.9 | 10.0 | 0.0 | 7.1 | 5.8 | 39.8 |
| 74 | Хууль зүй дотоод хэргийн яам | 12.3 | 5.0 | 0.0 | 8.8 | 11.5 | 37.7 |
| 75 | Байгаль орчин аялал жуулчлалын яам | 14.6 | 7.0 | 3.3 | 5.3 | 6.9 | 37.2 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **76** | Ховд аймаг | 9.0 | 9.5 | 0.0 | 4.2 | 9.6 | 32.3 |
| **77** | Монгол банк | 14.6 | 2.0 | 10.0 | 3.5 | 1.2 | 31.3 |
| **78** | Эрүүл мэндийн яам | 14.6 | 5.0 | 0.0 | 3.5 | 5.8 | 28.9 |
| **79** | Зэвсэгт хүчний жанжин штаб | 9.2 | 4.0 | 3.3 | 5.3 | 4.6 | 26.5 |
| **80** | Соёл урлагийн газар | 13.1 | 4.0 | 0.0 | 0.9 | 4.6 | 22.6 |
| **81** | Тагнуулын ерөнхий газар | 7.7 | 1.0 | 3.3 | 0.0 | 0.0 | 12.0 |

## ХАВСАРЛТ 5. ЦАХИМ ХУУДСУУДЫГ ДӨРВӨН ҮЗҮҮЛЭЛТЭЭР НЬ ЭРЭМБЭЛСЭН

| Байр | Төрийн байгууллагууд | Байгууллагын хүний нөөций ил тод байдал /100 хувиас/ | Хүний нөөцийн ил тод байдал /100 хувиас/ | Төсөв санхүүгийн ил тод байдал /100 хувиас/ | Худалдан авах ажиллагааны ил тод байдал /100 хувиас/ | Дундаж оноо |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Завхан | 85.7 | 100.0 | 93.8 | 88.5 | 92.0 |
| 2 | Орхон | 78.6 | 100.0 | 92.4 | 88.5 | 89.9 |
| 3 | Баянгол | 92.9 | 100.0 | 100.0 | 65.5 | 89.6 |
| 4 | Дорнод | 78.6 | 91.4 | 100.0 | 85.3 | 88.8 |
| 5 | Дорноговь | 57.1 | 100.0 | 100.0 | 88.5 | 86.4 |
| 6 | Сүхбаатар Дүүрэг | 78.6 | 85.7 | 91.0 | 90.3 | 86.4 |
| 7 | Хөвсгөл | 57.1 | 91.4 | 100.0 | 96.8 | 86.4 |
| 8 | Хан-Уул Дүүрэг | 71.4 | 100.0 | 81.9 | 78.8 | 83.0 |
| 9 | Сүхбаатар | 42.9 | 100.0 | 91.0 | 93.2 | 81.8 |
| 10 | Мэргэжлийн хяналтын ерөнхий газар | 92.9 | 91.4 | 93.5 | 42.5 | 80.1 |
| 11 | Хэнтий | 71.4 | 65.8 | 79.3 | 100.0 | 79.1 |
| 12 | Баянхонгор | 71.4 | 91.4 | 97.1 | 55.8 | 78.9 |
| 13 | Өвөрхангай | 57.1 | 91.4 | 79.1 | 77.0 | 76.2 |
| 14 | Цагдаагийн ерөнхий газар | 57.1 | 77.1 | 87.7 | 75.2 | 74.3 |
| 15 | Хил хамгаалах ерөнхий газар | 71.4 | 91.4 | 63.6 | 67.3 | 73.4 |
| 16 | Сэлэнгэ | 64.3 | 100.0 | 57.7 | 64.5 | 71.6 |
| 17 | Говьсүмбэр | 57.1 | 60.0 | 98.6 | 68.8 | 71.1 |
| 18 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар | 92.9 | 60.0 | 86.5 | 44.2 | 70.9 |
| 19 | Онцгой байдлын ерөнхий газар | 57.1 | 91.4 | 74.7 | 59.3 | 70.7 |
| 20 | Зам тээвэр хөгжлийн яам | 78.6 | 91.4 | 76.6 | 32.7 | 69.8 |
| 21 | Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар | 78.6 | 65.8 | 76.6 | 55.8 | 69.2 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **22** | Булган | 42.9 | 68.6 | 92.4 | 67.3 | 67.8 |
| **23** | Говь-Алтай | 64.3 | 82.9 | 76.0 | 39.9 | 65.8 |
| **24** | Стандарт, хэмжил зүйн газар | 78.6 | 68.6 | 71.6 | 36.3 | 63.8 |
| **25** | Сонгуулийн ерөнхий хороо | 50.0 | 62.8 | 80.1 | 61.7 | 63.7 |
| **26** | Боловсрол соёл шинжлэх ухааны яам | 78.6 | 74.3 | 53.1 | 46.0 | 63.0 |
| **27** | Баян-Өлгий | 71.4 | 68.6 | 53.2 | 57.5 | 62.7 |
| **28** | Төв | 35.7 | 91.4 | 68.6 | 52.2 | 62.0 |
| **29** | Үндэсний аудитын газар | 57.1 | 60.0 | 77.0 | 53.4 | 61.9 |
| **30** | Дундговь | 42.9 | 68.6 | 56.3 | 77.0 | 61.2 |
| **31** | Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар | 85.7 | 60.0 | 63.5 | 34.5 | 60.9 |
| **32** | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар | 78.6 | 51.5 | 77.0 | 36.3 | 60.8 |
| **33** | Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрлэлийн яам | 64.3 | 82.9 | 61.5 | 32.7 | 60.3 |
| **34** | Дархан-Уул | 64.3 | 25.7 | 85.7 | 62.7 | 59.6 |
| **35** | Сангийн яам | 64.3 | 82.9 | 46.4 | 44.2 | 59.4 |
| **36** | Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар | 64.3 | 82.9 | 60.3 | 21.2 | 57.2 |
| **37** | Архангай | 42.9 | 82.9 | 72.9 | 27.4 | 56.5 |
| **38** | Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар | 78.6 | 8.6 | 93.2 | 44.2 | 56.2 |
| **39** | Мал эмнэлэгийн үржлийн газар | 50.0 | 60.0 | 69.8 | 44.2 | 56.0 |
| **40** | Эрчим хүчний яам | 78.6 | 8.6 | 79.7 | 54.0 | 55.2 |
| **41** | Хүний эрхийн үндэсний комисс | 85.7 | 37.2 | 53.5 | 44.2 | 55.2 |
| **42** | Үндэсний статистикийн хороо | 64.3 | 34.2 | 68.1 | 52.2 | 54.7 |
| **43** | Багахангай дүүрэг | 28.6 | 60.0 | 78.6 | 50.4 | 54.4 |
| **44** | Цаг уур орчны шинжилгээний газар | 78.6 | 8.6 | 84.9 | 44.2 | 54.1 |
| **45** | Архивын ерөнхий газар | 64.3 | 17.1 | 86.5 | 44.2 | 53.0 |
| **46** | Барилга хот байгуулалтын яам | 64.3 | 17.1 | 73.0 | 55.8 | 52.5 |
| **47** | Гадаадын иргэн харъяатын газар | 78.6 | 8.6 | 86.5 | 32.7 | 51.6 |
| **48** | Өмнөговь | 35.7 | 0.0 | 81.9 | 88.5 | 51.5 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 49 | Иргэний нисэхийн ерөнхий газар | 78.6 | 25.7 | 71.4 | 26.6 | 50.6 |
| 50 | Сонгинохайрхан дүүрэг | 57.1 | 37.2 | 56.3 | 50.4 | 50.2 |
| 51 | Увс | 50.0 | 40.0 | 63.0 | 46.8 | 49.9 |
| 52 | Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба | 50.0 | 8.6 | 76.6 | 63.7 | 49.7 |
| 53 | Баянзүрх | 57.1 | 17.1 | 81.9 | 42.5 | 49.7 |
| 54 | Монгол улсын их хурал | 57.1 | 45.7 | 74.1 | 21.2 | 49.5 |
| 55 | Гэр бүл, Хүүхэд, залуучуудын хөгжлийн газар | 50.0 | 74.3 | 42.5 | 31.0 | 49.4 |
| 56 | Хөдөлмөр нийгэм хамгааллын яам | 64.3 | 51.5 | 43.6 | 34.5 | 48.5 |
| 57 | Ашигт малтмал, газрын тосны газар | 64.3 | 8.6 | 73.0 | 47.8 | 48.4 |
| 58 | Уул уурхай хүнд үйлдвэрийн яам | 64.3 | 8.6 | 78.2 | 34.5 | 46.4 |
| 59 | Байгаль орчин аялал жуулчлалын яам | 71.4 | 45.7 | 48.4 | 19.4 | 46.2 |
| 60 | Санхүүгийн зохицуулах хороо | 78.6 | 25.7 | 66.7 | 11.5 | 45.6 |
| 61 | Налайх дүүрэг | 35.7 | 51.5 | 67.7 | 26.6 | 45.4 |
| 62 | Эрүүл мэндийн яам | 85.7 | 45.7 | 28.5 | 19.4 | 44.8 |
| 63 | Төрийн албаны зөвлөл | 71.4 | 17.1 | 55.4 | 34.5 | 44.6 |
| 64 | Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөөх газар | 64.3 | 17.1 | 57.1 | 38.9 | 44.4 |
| 65 | Үндэсний хөгжлийн газар | 57.1 | 17.1 | 67.8 | 34.5 | 44.1 |
| 66 | Гаалийн ерөнхий газар | 50.0 | 8.6 | 80.1 | 32.7 | 42.9 |
| 67 | Чингэлтэй дүүрэг | 64.3 | 8.6 | 48.7 | 46.0 | 41.9 |
| 68 | Монгол банк | 57.1 | 62.8 | 23.2 | 22.8 | 41.5 |
| 69 | Авлигатай тэмцэх газар | 64.3 | 8.6 | 65.1 | 24.8 | 40.7 |
| 70 | Батлан хамгаалах яам | 50.0 | 0.0 | 65.1 | 44.2 | 39.8 |
| 71 | Газар зохион байгуулалт геодези, зураг зүйн газар | 64.3 | 0.0 | 56.0 | 34.5 | 38.7 |
| 72 | Татварын ерөнхий газар | 28.6 | 8.6 | 71.1 | 44.2 | 38.1 |
| 73 | Хууль зүй дотоод хэргийн яам | 64.3 | 8.6 | 46.4 | 26.6 | 36.5 |
| 74 | Зэвсэгт хүчний жанжин штаб | 50.0 | 51.5 | 19.9 | 23.0 | 36.1 |
| 75 | Багануур дүүрэг | 21.4 | 8.6 | 81.5 | 32.7 | 36.1 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **76** | Гадаад харилцааны яам | 28.6 | 0.0 | 69.8 | 42.5 | 35.2 |
| **77** | Биеийн тамир спортын газар | 28.6 | 0.0 | 76.6 | 34.5 | 34.9 |
| **78** | Соёл урлагийн газар | 78.6 | 8.6 | 30.5 | 9.7 | 31.8 |
| **79** | Улаанбаатар | 14.3 | 0.0 | 79.7 | 31.0 | 31.2 |
| **80** | Ховд | 7.1 | 0.0 | 76.2 | 11.5 | 23.7 |
| **81** | Тагнуулын ерөнхий газар | 64.3 | 0.0 | 0.0 | 9.7 | 18.5 |